# СОНГОДОГ ЛИБЕРАЛИЗМИЙН ЦАГААН ТОЛГОЙ



**Иймонн БАТЛЕР**

*Стефен Дэвийс өмнөх үгийг бичив.*

iea

# СОНГОДОГ ЛИБЕРАЛИЗМИЙН ЦАГААН ТОЛГОЙ

Иймонн Батлер

ННА 66
ДАА 320
Б-336

Classical Liberalism - Primer
by Eamonn Butler
Copyright © 2015 Institute of Economics Affairs
First published by the Institute of Economics Affairs, London, in 2015.

Сонгодог либерализмийн цагаан толгой
Иймонн Батлер

Монгол орчуулгын анхны хэвлэл: 2024 он

Англи хэлнээс орчуулсан: Намхайнямын Жаргал

Монгол орчуулгын эрхийг © Намхайнямын Жаргал эзэмшдэг.
Бүх эрхийг хуулиар хамгаалсан болно.

Энэхүү бүтээлийг Улстөрийн Нам, ТББ-аас бусад хувь хүн файл хэлбэрээр татаж авах, олшруулж, бусдад дамжуулах, хэсэгчилж эсвэл бүтнээрээ нь хэвлэх нь цөм чөлөөтэй бөгөөд гагцхүү орчуулагчийн нэрийг түүндээ дурдах ёстой. Улстөрийн Нам, ТББ хэрэглэх бол орчуулагчаас зөвшөөрөл авна.

“Эрх Чөлөөт Хүмүүст Зориулсан Номын-Сан” нэртэй вэбхуудасанд зориулж файлаар бас хэвлэв. www.libraryforfreepeople.mn

Эдийн Засгийн Хэрэг Явдлын Хүрээлэнгийн зөвшөөрлөөр орчуулан гаргав.

ISBN: 978-9919-9058-5-9

Өөрийн анд
Жон Бланделл (1952–2014 он)-д
зориулав.

# ГАРЧИГ


**ӨМНӨХ ҮГ** 1

**УТГЫН ХУРААНГУЙ** 6

**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ:**
**Оршил** 9

*Энэ номын зорилго* 9

*Энэ номын ерөнхий тойм* 9

**ХОЁРДУГААР БҮЛЭГ:**
**Сонгодог Либерализм Гэж Юу Вэ?** 11

**Сонгодог либерализмийн арван зарчим** 12

*1. Эрх чөлөөнд гүнээ итгэх* 12

*2. Хувь хүнийг эрхэмлэх* 12

*3. Албадлагыг багасгах* 14

*4. Хүлцэхүй* 15

*5. Хязгаарлагдмал эрх мэдэлтэй, төлөөллийн засгийн газар* 16

*6. Хууль ёс* 17

*7. Өөрөө-тогтдог дэг журам* 18

*8. Өмч, Худалдаа, Зах Зээл* 19

*9. Иргэний нийгэм* 19

*10. Хүмүүний нийтлэг үнэт зүйлс* 20

*Мэдээллийн-цонх: Америкийн Либерализмийн тухай тэмдэглэл тайлбар* 22

**ГУРАВДУГААР БҮЛЭГ:**
**Сонгодог Либерализм: Ургийн бичиг** 23

**Эхэн Үеийн Өвөг Дээдэс** 23

**Англи-Саксоны Англи нутаг** 23

**Эзлэн түрэмгийлэлд өртсөн нь, дахин боссон нь** 24

**Сонгодог либерализм өндийн боссон нь** 26

*Соёлын болон шашины хувьсгал* 26

*Улстөрийн хувьсгал* 27

*Эзэн хаадын эрх мэдлийг хязгаарласан нь* 28

*Бахархалт Хувьсгал* 29

*Жон Локк (1632–1704 он)* 30

*Гэгээрлийн Эрин* 31

*Хуульзүйн дагуухь төр буюу Рехтштаат* 32

**Амжилт, Дахин Үнэлэгдсэн нь** 33

*Сонгодог либерализмийн шинэ гэр* 33

*Арваннаймдугаар Зуун* 33

*Дахин бахдуулан магтагдсан нь, уруудан доройтож буурсан нь* 34

**Сонгодог либерализм орчин цагт дахин амилсан нь** 35

*Бодлогын асуудал, түүнд өгөх сонгодог либерал хариулт* 35

*Оюун санаа хөгжиж урагшлав* 36

**Сонгодог либерал үзэл санааны олон салаалсан байдал** 37

**ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ:**
**Сонгодог Либерализм, Эрх Чөлөө** 39

**Эрх чөлөөг дэмждэг гаргалгаа нотолгоо** 39

*Эрх чөлөө өөрөө сайн зүйл юм* 39

*Жам ёсны эрх* 39

*Нийгмийн гэрээ* 41

*Түүхэн замнал, хөгжил дэвшил* 42
*Олон нийтийн сайн сайхан* 43
*Хувь хүний өвөрмөц байдлыг илэрхийлэх* 44
*Аргазүйн индивидуализм* 44

**Позитив, негатив эрх чөлөөт байдал** 45

**Эрх, эрх чөлөө** 47

**Эрх чөлөөнд тавих хязгаарлалт** 48

**ТАВДУГААР БҮЛЭГ:**
**Сонгодог Либерал Ёс Суртахуунт Байдал** 50

**Албадлага, Хүлцэхүй** 50

*Аюул хохирол, үл санал нийлэх явдал* 50

**Хүлцэхүйг Дэмждэг Гаргалгаа Нотолгоо** 52

*Төлөөс, хохирол* 52
*Олон янзын ашиг сонирхол* 53
*Олон янз байдлын ашиг тус* 54
*Олон янз байдал, ёс суртахууны үүсэл хөгжил* 55
*Үзэшгүй муухай үр дагавар* 55
*Гулсамтгай уруу газар* 57
*Шугам татах* 58

**Хүлцэхүй, төр** 59

*Эрсдэл, хүч хэрэглэх явдал* 60

**ЗУРГААДУГААР БҮЛЭГ:**

**Сонгодог Либерал Улстөрийн Ухаан** 62

**Төр засгийн гарал үүсэл, зорилго** 62

*Төр засгийн функц* 63

**Нийгмийн шударга ёсны тухай худал яриа** 67

**Олон нийтийн сонголт, хувийн ашиг сонирхол** 69

**Сонгодог либерализм ба ардчилал** 71

*Үндсэн хууль, эрх чөлөө* 72

**Төр засгийн хуульзүйн бүрэн эрхэт байдал** 74

**ДОЛООДУГААР БҮЛЭГ:**
**Сонгодог Либерал Нийгэм** 75

**Өөрөө-тогтдог дэг журам** 75

*Өөрөө-тогтдог дэг журмын хувьсал хөгжил* 76

*Ёс журам ба Дэг журам* 77

**Шударга ёс, хууль ёс** 79

*Хууль ёс* 79

*Хууль ёсыг хамгаалах* 80

*Хууль ёсонд учрах аюул занал* 81

**Жам ёсны дэг журмын рационал байдал** 83

**Иргэний нийгэм** 85

**Өөрөө-тогтдог дэг журам, жам ёсны эрх** 86

**НАЙМДУГААР БҮЛЭГ:**
**Сонгодог Либерал Эдийн Засгийн Ухаан** 88

**Зах зээлийн өөрөө-тогтдог дэг журам** 88

**Үнийн өөрөө-тогтдог шинжтэй 'гайхамшиг'** 88

*Үнэ бол харилцаа холбоо юм* 89

**Тушаал заавargүй зах зээл** 90

**Ёс журам ба өмч** 91

*Өмчийн ёс журам* 91

**Эдийн засгийн эрх чөлөөг дэмждэг гаргалгаа нотолгоо** 93

*Хувийн болон сарниж тархсан мэдээлэл* 93

*Өрсөлдөөн* 94

*Олон нийтийн ашиг тус* 95

**Төр засгийн тогтворгүй болгодог үр нөлөө** 96

*Төрөөс ангид эрүүлмэнд, боловсрол, халамж* 97

**Арилжаа ба Протекционизм** 99

**ЕСДҮГЭЭР БҮЛЭГ:**
**Өнөөдрийн Сонгодог Либерализм** 100

**Унтарсан нь, бас сэргэн мандсан нь** 100

*Сонгодог либерализмийн уналт* 100

*Төөрөлдөж будлисны үр дагавар* 100

**Сонгодог либерализм дахин төрсөн нь** 101

*Сонгодог либерализмийн утга учир* 102

*Сонгодог либерализмийн хамрах хүрээ* 103

**Сонгодог либерализмийн интернационализм** 105

*Либерал бус бүлэг хүнтэй харьцах* 106

*Нутагт нь байх эс либерализм* 107

**Сонгодог либерал алсын хараа** 109

*Сонгодог либерал ертөнц байх уу?* 111

**АРАВДУГААР БҮЛЭГ:**
**Гол Сонгодог Либерал Сэтгэгчид** 112

**Жон Локк (1632–1704 он),**
*Англи философич* 112

**Бернард Мандевилле (1670–1733 он),**
*Англи–Голландын шог зохиолч* 112

**Волтэйр [Франсуа-Марий Аруэ] (1694–1778 он),**
*Франц зохиолч* 113

**Адам Фергүсон (1723–1816 он),**
*Шотландын нийгмийн онолч* 113

**Адам Смит (1723–1790 он),**
*Шотландын философич, эдийн засагч* 114

**Томас Жефферсон (1743–1826 он),**
*Америкийн хувьсгалын удирдагч* 115

**Фредерик Бастиа (1801–50 он),**
*Франц, улстөрийн онолч* 115

**Ричард Кобден (1804–1865 он),**
*Английн үйлдвэрийн эзэн, улстөрч* 116

**Жон Стюарт Милл (1806–73 он),**
*Английн философич, шинэчлэгч* 116

**Хербэрт Спенсер (1820–1903 он),**

*Английн антропологич, философич* 117

**Фрийдрих А. Хаек (1899–1992 он),**
*Англи –Австрийн улстөрийн онолч* 118

**Айн Рэнд (1905–82 он),**
*Орос–Америкийн зохиолч, моралист* 119

**Исайя Берлин (1909–97 он),**
*Латви–Британийн философич* 119

**Милтон Фрийдмэн (1912–2006 он),**
*Америк эдийн засагч* 120

**Жэймс М. Бачэнэн (1919–2013 он),**
*Америк эдийн засагч* 121

**Роберт Нозик (1938–2002 он),**
*Америк философич* 122

АРВАННЭГДҮГЭЭР БҮЛЭГ:
СОНГОДОГ ЛИБЕРАЛ ЭШЛЭЛ 123

**Магна Харт буюу Эрх Чөлөөний Аугаа Тунхаг** 123

**Жам ёсны эрх** 123

**Хязгаарлагдмал-эрх мэдэлтэй төр засаг** 125

**Өөрөө-тогтдог дэг журам ...** 127

**...Найрсагаар удирдах заавар ...** 127

**...Төлөвлөлт болон хяналтын эсрэг** 128

**Шударга ёс ба хууль ёс** 129

**Эдийн засгийн эрх чөлөө** 131

**Хувийн эрх чөлөө** 132

**Улстөрийн эрх чөлөө** 135

**АРВАНХОЁРДУГААР БҮЛЭГ:**
**Сонгодог Либерализмийн Түүхэн Огноо** 137

**АРВАНДУГААР БҮЛЭГ:**
**Нэмж Унших Зүйлс** 143

ОРЧУУЛСАН БҮТЭЭЛҮҮД: 158

## ЗОХИОГЧ

Иймонн Батлер бол бодлогын тэргүүлэх тинк танк болох Адам Смит Хүрээлэнгийн захирал билээ. Тэрбээр эдийн засаг болон психологийн эрдмийн цолтой, философийн PhD, Нийгмийн Ухааны хүндэт Доктор юм. 1970-аад онд тэрбээр Вашингтонд АНУ-ын Төлөөлөгчдийн Танхимд ажиллаж байхдаа, НХУ[1] руу Адам Смитийн Хүрээлэнг байгуулахад туслахаар буцахаасаа өмнө Мичиганы Хиллсдэйл Коллежид философийн ухааны хичээл зааж байв. Тэрбээр НХУ-ын Үндэсний Чөлөөт Аж Ахуй Эрхлэлтийн Шагналтан билээ.

Тэрбээр Милтон Фрийдмэн, Ф. А. Хаек, Лүдвиг фон Мизэс зэрэг тэргүүлэгч эдийн засагчдын тухай ном, *Эдийн Засгийн Ухааны Австри Сургуулийн цагаан толгой*, *Үндэстнүүдийн Цугларсан Баялаг*ийг зохиосон. ЭЗХЯХ-д зориулж тэрбээр Адам Смит, Лүдвиг фон Мизэс, олон нийтийн сонголтын тухай онолын талаархи цагаан толгойг зохиожээ; түүний *Чөлөөт Нийгмийн Үндэс* 2014 онд Фишерийн Шагнал[2] хүртсэн. Тэрбээр цалингийн түүх, үнийн хяналтын тухайн, мөн IQ-гийн тухай цуврал номын хамтран зохиогч юм. Түүний сүүлийн үеийн алдартай бүтээл *Зах зээлийн тухай хамгийн сайн ном*, *Британийн Илжирсэн Төр*, *Өөр Нэг Хувилбар Тунха*г[3] нь хүмүүсийн сонирхлыг их татсан бөгөөд тэрбээр номын хэвлэл, өргөн нэвтрүүлэгт байнга оролцдог.

---

1 *UK-Нэгдсэн Вант Улс-*

2 *Fisher Prize*

3 *The Best Book on the Market, The Rotten State of Britain, The Alternative Manifesto*

# ТАЛАРХАЛ

Дахин нэг удаа Мэдсен Пайрийдаа эрт цагаас үргэлжилж буй зөвлөгөө, хувь нэмрийнх нь төлөө, мөн Адам Смит Хүрээлэнгийн бусад хамтран ажиллагсдадаа гаргасан тэсвэр тэвчээрийнх нь төлөө талархал илэрхийлье.

# ӨМНӨХ ҮГ

Сонгодог либерализм бол орчин үеийн улстөр болон нийгмийн хамгийн чухал философиудын нэг юм. Үнэндээ бид үзэл санааны энэхүү бүрдэлд итгэгчдийн хүчин чармайлт орчин үеийн ертөнц оршин тогтноход маш чухал үүрэгтэй байсан гэж хэлж болно. Өөрсдийгөө сонгодог либералчууд гэж тодорхойлдог хүмүүсийн ухуулга таниулга, гаргалгаа нотолгоо, сэтгэлгээ, шинжилгээ дүгнэлт үгүйгээр хөгжлийн тогтвортой эрчимтэй өсөлт, шашны хүрээллээ хувь хүн сонгох[1], боолчлолыг үгүй хийсэн зэрэг орчин үеийн олон чухал хэвшинж гарахгүй байх байлаа.

Ач холбогдлынх нь хажуугаар сонгодог либерализмийг өнөөдөр муухан ойлгож, голдуу (маш олон тохиолдолд зориудаар) буруу илэрхийлж, сэтгэлгээний бусад арга замтай адилхан гэж, ялангуяа консерватизм гэж түүнийг алдаатай үздэг. Либерал гэдэг хэллэгийг “социал демократ” гэсэн утгаар хэрэглэдэг Америк арга замаас гардаг тодорхой хүндрэл Англиар ярьдаг ертөнцөд уламжлалт либерализмд итгэдэг хүмүүс өөрсдийн үзэл санаандаа шинэ нэр хайх хэрэгтэй болгосон. (Ийм зүйл “либерал” гэдэг үг уламжлалт утга санаагаа хадгалсаар байгаа эхгазрын Европд алга.) Либертари гэдэг хэллэгийг өргөнөөр хүлээн зөвшөөрдөг ч энэ нь янз бүрийн учир шалтгаанаар сэтгэлд тийм хүрсэн үг биш.

Энэ байдлыг тооцож үзвэл Иймонн Батлерийн өгүүлсэн зүйлийг ихэд таашааж байна. Энэ ном бол бодол санааны тогтолцоо гэж үздэг сонгодог либерализм гэж юу болох, хаанаас энэ нь ирсэн, одоо энэ нь ямар зүйл байгаа, хаашаа энэ нь үргэлжлэх боломжтой болох талаархи гайхалтай ойлгомжтой, сайтар зохиомжилсон, энэ бүгдийг хүмүүст таниулах ном юм. Энэ номын нэг үнэ цэнэтэй хэвшинж бол улстөрийн сэтгэлгээ болон олон нийтийн бодлогын асуудалд хандах [сонгодог либерализм гэдэг] хоорондоо-

1 *privatisation of religious identity*

холбоотой хандлага хэдий хэвээр байсаар буй ч гэлээ энэ хандлага доторхи ялгаа, төрөл зүйлийг гаргаж ирж буй арга зам нь билээ. (Үүнтэй адил зүйлийг мэдээжээр социализм болон консерватизмд ч зориулж хэлэх боломжтой.) Түүнээс урган гарч буй зарим нэг асуудал, мөн эдгээр асуудлыг цаашид нэмж судалж шинжлэх арга замын талаар цаашид бодууштай.

Түүхийн сургамжаас харагддагчлан сонгодог либерализм бол бүр эрт Магна Харт буюу Эрх Чөлөөний Аугаа Тунхаг[2] болон дундаж зууны конституционализм[3] биш юм аа гэхэд дор хаяж арвандолоодугаар зуун руу хүрэх боломжтой, Английн түүхийн үе шатуудын улстөрийн хөдөлгөөн, мөн хууль болон төр засгийн талаархи сэтгэлгээний арга зам болж Англид үндэслэсэн, түүнээс гарал үүсэлтэй зүйл юм гэдэг нь ойлгомжтой. Гэвч эхгазрын түүхэнд ганцхан Франц (хэдий Ф. А. Хаек 'сонгодог либерализмийн хувьд хамгийн ирээдүйгүй' гэж энэ улсыг дүрсэлж тайлбарладаг ч гэсэн)-аар зогсохгүй сонгодог либерализмийн үүсгүүр болсон улсууд мөн байсныг энд тод харуулжээ. Энэ нь Гэгээрлийн эрин[4] хийгээд Кант зэрэг сэтгэгчид рүү хүрдэг ч мөн л үүнээс ч цааш Сэргэн Мандалтын эрин[5] хийгээд Саламанкагийн Сургууль[6]тай холбоотой тэр дундад зууны сэтгэгчид рүү, бас үндсэн хуулийн засгийн газрын дундад зууны уламжлал, эзэн хаадын эрх мэдэлд тавьсан хязгаарлалт руу ч хүрэх бөгөөд Иберийн Хойгоос Скандинави, Польш, Литва хүрч тархаж байжээ. Сонгодог либерализмийн Европын үүсэл гарал гэвч түүнийг сэтгэлгээний Европын арга зам болгодоггүй. Үүнийг "Өрнөдийн" идеологи гэж харах хэрэггүй; харин энэ бол илүүтэй хандах чиглэлээрээ универсал шинжтэй, мөн дэлхийн бүх соёл болон иргэншилд нийцтэй, таатай уламжлалыг зурж гаргах

2 *Magna Carta - Энэ тунхагийн монгол орчуулгыг www.libraryforfreepeople.mn онлайн номын-сангаас уншина уу.*

3 *medieval constitutionalism*

4 *Enlightenment*

5 *Renaissance*

6 *School of Salamanca-Иберийн хойгийн хамгийн эртний их сургууль Саламанка (1130 он)-д 16, 17-р зууны теологичдын дунд үүсэж гарсан бодол санааны сургууль ажээ. Испанийн схолистуудтай төстэй.*

боломжтой ирээдүйн алсын хараа юм.

Энэхүү номоор гаргуун бүтээж, ойлгомжтой тайлбарласан маш чухал үзэл санаанууд дээр нэмээд сонгодог либерализм хэд хэдэн дотоод үнэмшил болон хэвмаягийн шинж чанар[7]тай мөн л холбоотой байдаг. Хамгийн чухал зүйл бол хүмүүний нөхцөл сайжрах боломжтой гэсэн бат итгэл болох өөдрөг сэтгэл юм. Чухам тиймээс л сүүлийн хоёр зууны туршид хүмүүний нөхцөл сайжирчээ. Үүнтэй холбоотой өөр нэг зүйл бол урагшаа л хардаг, өнгөрсөн рүү гэхээсээ илүүтэй ирээдүй рүү тэмүүлдэг явдал юм. Бид Иймонн Батлер хувь хүний зан чанар болон өөрийгөө-мэдэх эсвэл бие даасан байдалд анхаарал хандуулсныг нь эндээс харах боломжтой. Магадгүй хамгийн чухал нь хорлонтой зорилго тавьж, гайтай далд бодолгүйгээр найрсаг байдал өрсөлдөгч болон харилцан ярилцагч улсдаа харуулж, тэднээсээ илүү сайн сэтгэж бодох явдал юм - энэ бол орчин үеийн ихэнхи эргэцүүлэл хэлэлцүүлэгт дутагддаг чанар.

Энэхүү бүтээл сонгодог либерализм юу болохыг энгийнээр, ойлгомжтой дүрсэлж тодорхойлсон, мөн сонгодог либерализм гэж юу биш болохыг дүгнэх байдлаар дүрсэлж тайлбарласан маш сайн ном юм. Мэдээж сонгодог либерализм нь социализм, нийгмийн ардчилал[8], нийгмийн буюу ‘шинэ’ либерализм[9] зэрэг эгалитарич хамтач үзл[10]ийн бусад хэлбэрээс ялгаатай. Энэ нь ерөнхийдөө илүү өөдрөг үзэлтэй байж, бас саруул ухаанд илүү итгэж (хувь тавилан эсвэл уламжлалыг эсэргүүцэн), өвлөж авсан эсвэл уламжлалт институцэд бага найддаг байж мөн л консерватизмтай адилгүй. Энэ номыг уншаад ойлгомжтой болдог, мөн нэмж унших зүйлсийг уншсанаар бүр илүү илэрхий болох зүйлсийн нэг бол консерватив үзлээс хол байснаараа сонгодог либерализм дэлхийн ихэнхи хүмүүсийн амьдрах нөхцөл, амьдрах арга замд асар их, гүн гүнзгий өөрчлөлт авчирсан, ингэж хийхдээ хуучны дэг журмын дийлэнхи хэсгийг шүүрдэн зайлуулсан (жишээлбэл Лүдвиг фон Мизэсийн

*7 A quality or feature that is characteristic of someone or something*

*8 social democracy*

*9 social or “new” liberalism*

*10 egalitarian collectivism*

гаргасан санаа) хурц дайчин итгэл үнэмшил[11] юм. Үүний нэг жишээ сонгодог либерализм болон феминизмийн хоорондохь түүхэн холбоос[12] бөгөөд феминистүүдийн "анхны давлагаа"-ны ихэнхи нь шатаж дүрэлзсэн либералчууд байсан, мөн өнөөдөр ч ийм байр суурьтай олон жишээ харагддаг.

Сонгодог либералчууд хөдөлгөөн болохынхоо хувьд, сонгодог либерализм нь үзэл санааны цогц байгууламж болохынхоо хувьд ихээхэн өөрчлөгдсөн, нилээд сайжирсан ч гэлээ энэ номд заасанчлан ухралт гарч байсан[13] бөгөөд одоо ч гэсэн маш их зүйл хийх хэрэгтэй байсаар байна. Сонгодог либералчууд үүнийг мартан юмс үзэгдлийн байгаа байдлыг хамгаалагч болоход тэд эрмэлзэл тэмүүллээ алдаж, танигдах шинжийнхээ үндэс болсон зүйлээ гээчихдэг. Энэ бүтээлд тухайн уламжлал дахь оюун санааны хөгжлийн шинэ өрнөлийг ойлгомжтой өгүүлсэн ч энэ үзэл санаа зөвхөн сургаж заах, тайлбарлах л боломжтой ариун бичигтэй, мөнхөд үл хувирах дүгнэлт бүхий хувиршгүй, төгс үзэл санааны цогц бүрдэл биш. Энд дүрсэлж тайлбарласан үндсэн чухал санаануудыг зүйлчилж гаргасан шинэ үзэл санаа, шинжилгээ дүгнэлт, саналын хамтаар байнга дахин давтан хэрэглэж, дахин бодож тунгаадаг, алдааны атгаалжин мангасын толгойнуудыг тастаж хаядаг, оюун санааны хурц тод, амьд хөдөлгөөн юм.

ЭЗХЯХ[14] улстөрийн тодорхой философийг илэрхий дэмждэггүй, үүнээс дутуугүйгээр улстөрийн тодорхой нам эсвэл

---

*11 radical creed*

*12 Энэ талаар Мизэс дараахь зүйлийг бичиж байжээ: "Феминизм эмэгтэйчүүдийн хуульзүйн байр суурийг эрэгтэйчүүдийнхтэй адил болгохыг эрэлхийлсээр байх хүртэл, мөн эмэгтэйчүүдэд өөрсдийнхөө хандлага, хүсэл, эдийн засгийн нөхцөл байдалдаа тааруулан хөгжиж дэвжих, үйл хийх хуульзүйн болон эдийн засгийн эрх чөлөө олгох явдал байсаар байх хүртлээ энэ нь эв найртай, чөлөөт эволюц буюу хувьсал хөгжлийг өмгөөлж хамгаалдаг аугаа либерал хөдөлгөөний нэг салаа нь байсаар байх байна. Гэвч феминизм үүнээс давж, жам ёсны [хүмүүсийн хоорондохь] ялгааг арилгах ёстой гэсэн сэтгэлээр нийгмийн амьдралын институцууд рүү дайрвал энэ нь Социализмын оюун санааны үр хөврөл болно" Лүдвиг фон Мизэс. Социализм, 4-р бүлэг, 1951 он.*

*13 remission*

*14 Institute of Economic Affairs (IEA)*

хөдөлгөөний байр суурийг өмгөөлж хамгаалдаггүй. Гэлээ гээд бас нийгмийн асуудлыг обьектив байдлаар ухаж ойлгон, тэдгээрийг үр дүнтэй шийдвэрлэх ажлыг тасралтгүй үргэлжлүүлэх бусад хүмүүс хэрэглэх боломжтой тодорхой арга хандлагыг хориглодоггүй. Сонгодог либерализм бол хэдий цор ганцаараа биш харин үүнд нийцэж таардаг, ертөнцийн тухай эргэцүүлж сэтгэх болон ухаарч ойлгох арга замд хүргэдэг, хоорондоо холбоотой философи, хөдөлгөөнүүдийн нэг билээ. Ийм учраас л энэ номыг ЭЗХЯХ-гийн жагсаалтад дуртайяа нэмсэн бөгөөд энэ ном орчин цагийг бүтээгч философиудын нэгнийг нь илүү сайн ухаж ойлгох явдалд чухал хувь нэмэр оруулах болно.

Стефен Дэвийс

Эдийн Засгийн Хэрэг Явдлын Хүрээлэнгийн Боловсрол хариуцсан Захирал

2015 оны 5-р сар

*Энэхүү монограф буюу нэг сэдэвт бүтээлд илэрхийлсэн санаа, ЭЗХЯХ-ийн бүх хэвлүүлсэн зүйлд байдагчлан энэ Хүрээлэн (байгууллагын гэх үзэл байдаггүй), түүнийг удирддаг итгэмжлэгдсэн хүмүүс, Шинжлэх Ухааны Зөвлөх Зөвлөлийн гишүүд эсвэл ахлах ажилчдынх биш харин энэ зохиогчийнх болно. Лекц хэвлүүлэх зэрэг зарим нэгнээс бусад, ЭЗХЯХ-гийн бүх монографийг тухайн салбарынхаа нэр нь үл мэдэгдэх мэргэжилтэн болох дор хоёр эрдэмтэн эсвэл судлаач нягталж шалгадаг.*

# УТГЫН ХУРААНГУЙ

- Сонгодог либералчууд нийгэм, улстөр, эдийн засгийн амьдрал дахь хувь хүний эрх чөлөөнд ач холбогдол өгдөг. Тэд өөр өөр хүмүүсийн эрх чөлөө зөрчилдөх, мөн эрх чөлөөний хязгаар хаагуур байх талаар санал нэгдэхгүй байж болохыг таньж мэддэг ч хувь хүний эрх чөлөө хамгийн их байх ёстой, хүч хэрэглэх явдал хамгийн бага байх хэрэгтэй гэдэгт өргөн хүрээнд санал нэг байдаг.
- Тэд нар хувь хүнийг хамт олноос чухал гэж үздэг бөгөөд хүмүүсээс хуульзүйн бүрэн эрх[1]ээ олж авдаг, хязгаарлагдмал эрх мэдэлтэй, төлөөллийн засгийн газрыг шаарддаг. Засгийн газрыг хууль ёсоор хязгаарлах ёстой, мөн шударга ёсыг хүлээн зөвшөөрсөн зарчим болон үйл явцын дагуу хэрэгжүүлэх хэрэгтэй гэж үздэг.
- Сонгодог либералчууд төрийн нарийн тодорхой үүргийн талаар санал нэгддэггүй ч гэсэн ерөнхийдөө хувь хүний ч, төрийн ч хүч хэрэглэх явдлыг хязгаарлахыг хүсэцгээдэг. Тэд нар төрийг цомхон, мэдэгдэж буй ёс журмын хүрээнд байлгахыг шаарддаг. Улстөрийн ухааны гол асуудал бол хэрхэн удирдагчаа сонгох вэ бус харин нэгэнт эрх эрх мэдэлтэй болмогц тэднийг хэрхэн эрх мэдлийг нь хязгаарлах вэ гэдэг асуудал юм.
- Сонгодог либерализм нийгмийн эрх чөлөөг үнэлж үздэг ч төрдөө эдийн засгийн ихээхэн эрх мэдэл өгдөг Америк Либерализмтэй адилхан биш. Бас энэ нь тусгаарлагдсан салангид бодгалийн тухай үзэл санаа[2] биш: түүнд хувь хүнийг гэр бүл, ёс суртахуун, шашин эсвэл бусад олон үнэнч зан чанар бүхий

---

1 *legitimacy*

2 *atomistic idea - сэтгэхүйн бүх үзэгдлийг ижил төстэй байдлаараа нийлмэл үзэл санааг бий болгодог ердийн элемент (мэдрэмж, сэтгэхүй)-үүд болгож багасгадаг онол ажээ.*

хоорондоо давхарддаг бүлэг хүмүүсийн гишүүн гэж хардаг. Иймэрхүү иргэний нийгмийн институц бол төрийн төвлөрсөн эрх мэдлийн эсрэг зогсдог хэрэгтэй түшиг тулгуур юм.

- Үг хэлэх эрх чөлөө[3], харилцан хүлцэх явдл[4]ыг чөлөөт хүмүүсийн хоорондохь эв найртай хамтын ажиллагааны гол суурь гэж үздэг. Сонгодог либералчууд иймэрхүү хамтын ажиллагаанаас, төвлөрсөн байдалтай төлөвлөсөн бодлоос гарах боломжтойгоос хязгааргүй илүү нарийн нийлмэл, илүү үр өгөөжтэй, илүү засан зохицомтгой (зах зээл, уламжлал, соёл, хэл яриа) нийгмийн өөрөө-тогтдог дэг журам үүсдэг гэж батлан өгүүлдэг.
- Эдийн засгийн ухааны хувьд сонгодог либералчууд эд баялгийг засгийн газар бүтээдэггүй харин чөлөөт хувь хүмүүсийн хамтын ажиллагаа бүтээдэг гэдэгт итгэдэг. Чөлөөт хувь хүмүүс шинийг зохион бүтээх, бүтээж байгуулах, хадгалж хураах, хөрөнгө оруулах, эцэст нь сайн дураараа бараа бүтээгдэхүүн, үйлчилгээгээ харилцан ашигтай байхаар солилцох явдлаас хөгжил цэцэглэлт бий болдог – энэ бол чөлөөт зах зээлийн эдийн засгийн өөрөө-тогтдог дэг журам юм.
- Сонгодог либерализмийн гарал үүслийг Англи-Саксоны Англи, түүнээс цааш бусад улс руу буцаан мөшгих боломжтой ч энэ нь Жон Локк (1632–1704 он), Адам Смит (1723–90 он), Америкийн Нэгдсэн Улсыг Үндэслэгчид зэрэг сэтгэгчдийн үзэл санаанаас голчлон үүсэж гарчээ. Сүүлийн үед үүнийг Ф. А. Хаек (1899–1992 он), Милтон Фрийдмэн (1912–2006 он) зэрэг эрдэмтэд сэргээсэн юм.
- Янз бүрийн сонгодог либералчууд эрх чөлөөг дэмждэг ондоо ондоо гаргалгаа нотолгоо хөгжүүлж гаргадаг. Зарим нь үүнийг сайн зүйл гэж хардаг бол бусдад нь бүх хувь хүмүүсийн эдэлдэг жам ёсны эрхийн тухай үзэл санаа таалагддаг. Зарим нь бусдыг захирах бүрэн эрх хуулийг дагаж мөрдөхөөр хүмүүс санал нэгддэг явдлаас л зөвхөн ургаж гардаг бөгөөд

*3 Free speech*
*4 mutual toleration*

нийгмийн гэрээнд энэ нь үндэслэдэг гэж хэлнэ. Хэдэн хүн нь нийгэм, улстөрийн эрх чөлөө хүн бүрийг шуудхан л элбэг дэлбэг байдалтай болгодог гэдгийг батлан өгүүлдэг.

- Сонгодог либералчууд хүлцэх тэвчих явдлыг дэмждэг янз бүрийн гаргалгаа нотолгоо хөгжүүлж дэвшүүлдэг. Олон хүн хүмүүсийг хүслийнх нь эсрэг зүйл хийхийг албадах нь төлөөс ихтэй, хор хөнөөлтэй үр дүн гаргадаг гэдэгт итгэцгээдэг. Бусад нь хүмүүс бусдадаа хор хүргэхгүй байвал амьдралынхаа хэвмаягаа сонгоход нь хөндлөнгөөс оролцох явдлыг зөвтгөдөггүй. Зарим хүн олон янзын үзэл санаа, бодол санааг зөвшөөрөх нь ашиг тустай болохыг дурдан хэлдэг.
- Сонгодог либерализм бол тогтчихсон идеологи биш ч харин эрх чөлөөнд итгэдэг итгэл үнэмшил, мөн хэн нэгэн хувь хүн нөгөө нэгэндээ хэрэглэх албадлагыг жигшиж зайлсхийх явдалд үндэслэдэг нийгэм, эдийн засаг, улстөрийн асуудлын талаархи үзлийн өргөн хүрээ юм. Сонгодог либерализм сүүлийн хэдэн арван жил дахин амилж байгаа боловч одоо шинэ, даруй шийдвэрлэх асуудлуудтай тулгарч байна – жишээлбэл эрх чөлөөг устгахыг хүсдэг бүлэг хүмүүст эрх чөлөө олгох хэрэгтэй болдог явдал юм.

# НЭГДҮГЭЭР БҮЛЭГ:
# Оршил

*Энэ номын зорилго*

Энэхүү цагаан толгойгоор сонгодог либерализмийн зарчим, алдартай зүтгэлтнүүд, гарсан хөгжлийн гол явдлуудын талаархи энгийн таниулга мэдээлэл өгөхийг зорилоо. Үүнийг нийгэм, улстөр, эдийн засгийн эрх чөлөөний ерөнхий концепцийг ухаж ойлгодог байж болох ч бас түүний үндсэн элементүүдийн зүйтогтолтой илэрхийллийг сонирхох хүмүүс, оюутан, чөлөөт жирийн уншигчдад зориулан зохиомжилсон болно.

Энэ номд сонгодог либерализм гэж бүгдээрээ хувь хүний эрх чөлөө, мөн хүчирхийллийг багасгах явдлыг гол чухалчлах зүйл гэж үздэг ч нэг хязгаар нь либертанианизм орчмоос нөгөө нэг хязгаар болох консерватив үзэл хүрсэн хязгаартай байж болох үзэл санааны өргөн хүрээ хамруулан хэлдэг. Үүнд сонгодог либерализмийг хувь хүний эрх чөлөөнд бат суурьтай итгэх ч бас засгийн газар болон шүүхийн дор хаяж зарим нэг захиргааны үйл түүнийг нь сахин хамгаалахад итгэх явдал гэж үзсэн болно. Энэхүү хэлбэлзэх хүрээний өөр өөр цэг орших сонгодог либералчуудын дунд маргаан мэтгэлцээн төр засгийн үүрэг нөлөө хэр их байх хэрэгтэй талаар гардаг ажээ.

*Энэ номын ерөнхий тойм*

2-р бүлэгт сонгодог либералчууд тэдний хооронд санал зөрөлдөх зүйл байдаг ч гэсэн тэднийг нэгтгэдэг 10 гол зарчмыг ерөнхийлж харууллаа. 3-р бүлэгт дараагаар нь сонгодог либерализмийн түүхэн хөгжлийг нь Англи-Саксоны үндэс сууриас нь Шинэчлэлийн Эрин, Гэгээрлийн Эрин, хувьсгалуудаар дамжин түүний арванесдүгээр зууны доройтол, орчин цагийн түүний дахин сэргэсэн явдал хүртэл нь үзүүллээ.

4-р бүлэгт өөр өөр уламжлалаас гарсан ондоо ондоо гэхдээ голдуу хоорондоо зөрчилдсөн, сонгодог либерализмийн үзлийг ерөнхийд нь харуулан эрх чөлөөг дэмждэг гаргалгаа нотолгоонд анхаарал хандууллаа. Тэгээд араас нь 5-р бүлэгт ёс суртахуунт байдлын тухай сонгодог либерализмийн үзэл санаа, мөн тэдгээрийн төвд хувь хүн эсвэл төрийн алинаас ч гарах албадлагыг багасгах явдал байдгийг харуулсан болно. 6-р бүлэгт төрийн үүрэг нөлөө, хязгаар ямар байх ёстой талаархи хурц ширүүн маргааныг ерөнхийлж харуулав. 7-р бүлэгт яагаад сонгодог либералчууд хүмүүний нийгэм өөрөө өөрийгөө тохируулж удирддаг, мөн өөрийгөө сахин хамгаалахад нь том хэмжээтэй, төвлөрсөн захиргааны хэрэгцээ байдаггүй, бас ийм бүтэцгүйгээр олон нийтийн ашиг тусыг бий болгодог гэдэгт итгэдгийг тайлбарлав. 8-р бүлэгт эдийн засгийн ухаанд энэ байдал мөн үнэн байдаг, үүнд зах зээл болон үнэ зэрэг жам ёсны [өөрөө-гарсан] институцийн хувьсал хөгжил буюу эволюцэд талархах учиртай болохыг үзүүллээ.

9-р бүлэгт сонгодог либерал сэтгэлгээний сүүлийн үеийн дахин сэргэж буй байдал, сонгодог либерал уламжлал дотор гарч ирж буй бодол санааны шинэ сургуулийн заримыг харуулсан болно.

Энэ номд гол либерал сэтгэгчдийн хувь нэмрийн талаархи ерөнхий мэдээллийг, сонгодог либерал асуудлын тухай зарим нэг чухал эшлэл, сонгодог либерализмийн хөгжлийн явцын он цагийн түүхэн хэлхээ, нэмж унших зүйлсийн хамтаар дурдаж дуусгасан болно.

# ХОЁРДУГААР БҮЛЭГ:
# Сонгодог Либерализм Гэж Юу Вэ?

Сонгодог либералчууд гэдгийг хамгийн тодорхой болгодог зүйл бол *хувь хүний эрх чөлөө*г илүү чухалчилдаг явдал юм. Хүмүүн төрөлхтөн мөн л мэдээжээр чигч шударга зан, үнэнч байдал, аюулгүй байдал, гэр бүл, гм. өөр бусад үнэт зүйлтэй. Гэвч бидний *нийгэм, улстөр, эдийн засг*ийн амьдралын тухай ярих болоход сонгодог либералчууд биднийг хувь хүн эдлэх эрх чөлөөг хамгийн их байлгахаар зорих ёстой гэдэгт итгэдэг.

Сонгодог либералчууд хүмүүс бусад хүмүүс эсвэл засаг захиргаанаас үзүүлэх зайлшгүй хэрэгцээтэй хамгийн бага хязгаарлалт дор өөрийн хүссэнээрээ амьдрах ёстой гэдгийг сахин хамгаалдаг. Тэд нар нэгэнт нэг хүний эрх чөлөө нөгөө хүнийхтэй зөрчилдөж болох учраас хэзээ ч абсолют байх боломжгүй гэдгийг хүлээн зөвшөөрдөг: бид бүгд чөлөөтэй нүүж шилжих эрх чөлөө[1]тэй ч гэсэн бид нэг цаг хугацаанд нэг газар нэг дор бүгд явж очих боломжгүй байсаар л байна. Эрх чөлөө гэдэг нь *өөрсдийнх нь эрх чөлөө*г зөрчих түүнд халдах үйлдэл болох хулгайлах, заналхийлэх, албадаж хүчлэх, бусдын биед халдах эсвэл алах нь чөлөөтэй гэсэн үг биш.

Хувь хүний эрх чөлөөний хязгаар нь тэгвэл юу байх вэ? Сонгодог либерализмд үүнд өгөх цор ганц хариулт гэж байдаггүй. Энэ нь ёс журмын догма буюу хатуу чанд маягтай бүрдэл биш. Сонгодог либералчууд бие хүний (болон төр засгийн) үйлдлийн хязгаар хаагуур байх хэрэгтэй талаар бүрэн санал нэгддэггүй. Гэвч тэд нар өргөн хүрээнд үүний аливаа хариулт хувь хүний эрх чөлөө хамгийн их болгох арга замд байх ёстой, хувь хүний эрх чөлөөг хязгаарлахыг хүсэж буй хүнд ингэх маш чухал үндэслэл байх хэрэгтэй гэдэгт санал нийлцгээдэг.

1 *freedom of movement*

## Сонгодог либерализмийн арван зарчим

Сонгодог либерализм гэж юу болохыг ойлгохын тулд бид сонгодог либералчууд бүгдээрээ санал нийлдэг арван зарчмыг жагсаан бичих учиртай.

### *1. Эрх чөлөөнд гүнээ итгэх[2]*

Сонгодог либералчууд хувь *хүний эрх чөлөө* эсвэл эрх чөлөөт байдал (Англи хэлэнд энэ хоёрыг үгийн харилцан сэлгэж хэрэглэдэг)-*д гүн итгэдэ*г. Тэд нар бидний улстөр, нийгэм, эдийн засгийн амьдрал дахь эрх чөлөөг хамгийн их байлгахыг хүснэ. Гэвч тэд энэ дүгнэлтдээ өөр өөр үндэслэл шалтгааныг хэлдэг.

Олон нь эрх чөлөө *өөрөө сайн зүйл* гэнэ. Сонголт өгвөл хүмүүс эргэлзээгүйгээр албадлагаас ангид чөлөөтэй байхыг илүүд үзнэ гэж тэд психологийн үүднээс батлан өгүүлдэг. Жам ёсны эрхийг өмгөөлж хамгаалагч бусад нь эрх чөлөө бол Бурхан эсвэл Байгаль бидэнд өгсөн ямар нэг зүйл юм гэж хэлдэг. Зарим нь эрх чөлөө “жам ёсны төлөв”-д байгаа хүмүүс үймээн самуун, зөрчилдөөнөөс сэргийлэхийн тулд санал нэгддэг *нийгмийн гэрээ*нд үндэслэдэг гэж батлан өгүүлцгээнэ.

Олон хүн эрх чөлөө бол *хөгжил дэвшлийн зайлшгүй нөхцөл* юм гэж сануулдаг. Зарим нь эрх чөлөө нь хүмүүн байхын амин сүнс гэнэ: бусдын хяналтад байгаа хэн нэгэн хүн бол бүрэн хүн биш харин цэвэр хэрэггүй хүн юм гэсэн *хүмүүнист*[3] санааг гаргадаг. Эцэст нь *утилитарич* сонгодог либералчууд нийгмийн элбэг дэлбэг байдлыг бүх байдлаар нь хамгийн их болгох хамгийн сайн арга зам бол эрх чөлөө юм гэж үнэлж цэгнэдэг.

### *2. Хувь хүнийг эрхэмлэх*

Сонгодог либералчууд хувь хүнийг хамт олноос илүү чухал гэж

---

2 *The presumption of liberty*

3 *humanist-саруул ухаан, шинжлэх ухаанд итгэдэг ч бурханлаг зүйлд итгэдэггүй, ертөнцийг үзэх үзэлтэй хүнийг хэлнэ.*

үздэг. Тэд нар зарим нэг хамтач ашиг тусын төлөө хувь хүний эрх чөлөөг дор хаяж зарим нэг маш сайн үндэслэлгүйгээр золиослохгүй. Тэдэнд ингэх хэд хэдэн өөр учир шалтгаан бий.

*Методологийн индивидуализм*[4] гэж нэрлэдэг нэг үзэлд хамт олон түүнийг бүрдүүлдэг хувь хүнгүйгээр орших боломжгүй гэж үздэг. Мэдээжээр овоолсон тоосгоноос байшин илүү том байдагчлан нийгэм хувь хүмүүсийн бөөгнөрлөөс илүү том зүйл байдаг. Гэвч *нийгэм*д өөрт нь бие даасан ухаан гэж байдаггүй; харин бодож сэтгэдэг, үнэлж цэгнэдэг, сонголт хийдэг, үйл явцыг хөдөлгөдөг *хувь хүмүүс*ийн ухаан л гэж бий. Хүмүүсийн хүрээлэл үүсгэдэг хувь хүмүүсийн ашиг сонирхлоос давсан хамтач ‘олон нийтийн ашиг сонирхол’ гэж байдаггүй.

Хоёрдохь нь тэдгээр хувь хүмүүс хоорондоо санал нэгддэггүй гэх санаа. Нэг бие хүний ашиг сонирхолд таарсан зүйл нь өөр нэгний ашиг сонирхлын эсрэг байж болно. Хувь хүний эрх чөлөөг “хамтач” үзлийн төлөө золиосолж буй нь бодит байдал дээр бид энэ эрх чөлөөг хүн бүрийн ашиг сонирхолд бус харин тодорхой ашиг сонирхлын бүрдэлд зориулж золиослох болно гэсэн үг ажээ.

Өөр нэг шалтгаан бол зүгээр л сургамж юм. Хамтын сайн сайхны төлөө зарим нэг удирдагчийн будличихсан мэдлэгт [найдан] эрх чөлөөгөө золиослон өгөхөд тухайн хүн амд учирч байсан аймшигт зовлонгийн жишээгээр бидний түүх дүүрэн. Бүр саяхны л Хитлерийн харгис балмад үйлдэл[5], Сталины үүсгэсэн өлсгөлөн, хийсэн цэвэрлэгээ[6], эсвэл Пол Потын тушаасан үй олноор нь

4 *methodological individualism*

5 *atrocities of Hitler- Хитлерийн Нацист дэглэм 15-аас 32 сая хүн алсан гэдэг ч хамгийн магадлалтай нь 20 сая орчим хүнийг, үүнд дотроо 6 еврей үндэстнийг хядсан байдаг. Энэ дэглэм Сталины коммунист дэглэмтэй хамтарч Дэлхийн 2-р дайныг эхлүүлж 50-аад сая иргэдийн амиар тоглосон билээ. Энэ гурван хүн-араатан дунд Хятадын Маогийн дэглэмийн хядлагыг дурдсангүй. Энэ дэглэмийн Соёлын Хувьсгалын үеэр 1958-1962 оны хооронд 45 сая хүнийг хядсан нь одоогийн байдлаар дэлхийн түүхэн дэх хамгийн харгис хядлагаар тодорчээ.*

6 *starvation and purges under Stalin-Засгийн эрх авсан 1920-оод оноос 1953 он хүртэлх хугацаанд Сталины дэглэм 9 сая хүн алсан, үүн дотроо 1932-33 онд Украинд 2-3 тариачин өлбөрч үхсэн, 1937-38 он 1 сая хүнийг*

хядсан аллаг[7]ын тухай бодоход л хангалттай.

Дөрөв дэх нь нийгэм маш нарийн нийлмэл байдаг, байнга сүлэлдэж байдаг явдал ажээ. Ямар ч цор ганц засаг захиргаа энэхүү нарийн нийлмэл, хөдөлгөөнтэй амьд ертөнцөд хүн бүрд юу хамгийн сайн байхыг мэдэх ямар ч боломжгүй. Хувь хүмүүс өөрсдийнхөө төлөө шийдвэр гаргахдаа хамаагүй илүү байдаг бөгөөд тэднийг үүнийгээ чөлөөтэй хийдэг байхаар тайван орхих хэрэгтэй.

### *3. Албадлагыг багасгах*

Сонгодог либералчууд албадлагыг багасгаж бууруулахыг хүсдэг. Тэд нар хүн бүр бусдыг ашиглаж мөлжих эсвэл тэдэнд хүслээ тулгахын тулд хүч хэрэглэдэг эсвэл заналхийлдэг биш харин хүмүүс эв найртай санал нэгдэн хамтдаа амьдран суудаг ертөнцийг хүснэ.

Үүнийхээ дагуу сонгодог либералчууд хүч хэрэглэх монополь эрхийг засгийн газар болон шүүхийн захиргаан[8]д өгдөг. Гэвч тэд ингэсэн ч энэ эрхийг хэрэгцээтэй хамгийн бага хэмжээтэй л байлгахыг хүсдэг; тэд нар эрх мэдлийг хэрхэн хялбархан буруугаар ашиглах боломжтойг нь мэддэг.

Сонгодог либералчууд хүмүүсийн үйлдлийг хорьж саатуулах аливаа хүч хэрэглэх явдал *үндэслэлтэй байх ёстой* гэдгийг сахин хамгаална. Эрх чөлөөг хязгаарлахыг хүссэн хүмүүс яагаад ийм үйлдэл шаардлагатай, мөн хангалттай үр ашигтай болохыг харуулах хариуцлага хүлээдэг.

Ерөнхийдөө сонгодог либералчууд хувь хүн хүссэнээрээ, ямар нэг зүйл хийхээсээ өмнө хэн нэгний зөвшөөрөл авдаггүй байх

*цаазласан, энэ дундаа Монголын 600 мянган хүнээс 40-өөд мянгыг нь янз бүрийн нэр зүйж аймаглан устгасан, Гулаг, албан хөдөлмөрлүүлэх зэргээс олон хүн үхсэн гэдэг. Гэвч тоо нь ЗХУ-ын сэтгүүлчдийн хэлэхээр 20-60 сая болж өсөх боломжтой, үнэн тоо баримт одоо хүртэл нууц гэсэн дардастай.*

7 *Pol Pot (1925-1998 он) -Камбожийн хувьсгалч, дарангуйлагч, 1976-79 онд Ардчилсан Камбожийн Ерөнхий Сайд байсан, коммунист намын удирдагч асан, цэргийн генерал энэ яргачин энэ хугацаандаа 7.8 сая хүнийхээ 1.5-аас 2 сая хүнийг аймаглан устгасан байдаг.*

8 *government and judicial authorities*

ёстой гэдгийг баримталдаг. Хүмүүсийн үйлдлийг хорих хориглоход сайн үндэслэл байж ч болно; гэвч ингэхийг хүссэн хүмүүс л ийм үндэслэлээ гаргаж өгөх ёстой.

### *4. Хүлцэхүй*

Сонгодог либералчууд хүмүүсийн эрх чөлөөнд хөндлөнгөөс оролцох гол эсвэл магадгүй цор ганц үндэстэй шалтгаан бол бусдадаа бодит аюул хохирол учруулах эсвэл ингэхээр заналхийлэхээс сэргийлэх явдал юм гэж итгэдэг. Тэд бид зүгээр л эдгээр үйлдэлд дургүй эсвэл энэ гутаан доромжилсон шинжтэй гэж үздэг учраас хүмүүсийн үйлдлийг хязгаарлах хэрэгтэй гэдэгт итгэдэггүй.

Жишээлбэл сонгодог либералчууд бүр хүмүүсийн зарим нь бусад хүмүүс, эсвэл бүр өөр хэн нэгэн эсэргүү зүйл гэж бодож болох зүйлийг хэлэх ярихад хэрэглэдэг байсан ч үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх явдл[9]ыг хамгаалдаг. Үүнтэй адилаар хувь хүн бүр бусад хүн тэдний зорилго болон үйл ажиллагааг нийцгүй гэж харж байсан ч клуб, холбоо эсвэл улстөрийн нам зэрэг хүмүүсийн бүлэг үүсгэж эвлэлдэн нэгдэх чөлөөтэй байх ёстой. Тэд бараа бүтээгдэхүүн болон үйлчилгээ, бүр бусад хүмүүс дургүй байдаг зүйл (хар тамхи татах, биеэ үнэлэх мэт)-ийг чөлөөтэй арилжаалж худалдаалдаг байх хэрэгтэй. Тэд нар өөрсдийн таалллаараа амьдрах, ямар ч үзэл бодолтой байх, хүссэн шашнаа шүтэх эрх чөлөөтэй байх ёстой.

Сонгодог либералчууд ийм хүлцэхүйг өөрийг нь сайн гэж үзэхээр зөвхөн зогсдоггүй, мөн тэд нар хүлцэхүй, харилцан биесээ хүндлэхийг эв найртай хамтын ажиллагаа, мөн сайн ажиллаж буй, үр ашигтай нийгмийг бүтээх үндсэн суурь гэж ойлгодог. Хүмүүний ялгаа бол нийгмийн амьдралын маань бодит байдал бөгөөд үргэлж ийм л байдаг ажээ. Либералчууд эдгээр ялгаатай байдлыг устгаж үгүй хийх боломжтой гэдэгт итгэдэггүй бөгөөд ингэх гэсэн Утопи оролдлогод маш итгэлгүй ханддаг. Үүнээс харвал хүлцэхүй бол ажиллаж буй нийгмийн амьдралын салшгүй хэсэг ажээ.

---

*9 free speech*

*5. Хязгаарлагдмал эрх мэдэлтэй, төлөөллийн засгийн газар*

Сонгодог либералчууд зарим нэг хүч хүмүүсийг бусдыгаа гэмтээхээс сэргийлэхэд хэрэгтэй байж болох, мөн зөвхөн засаг захиргаа л ийм эрхтэй байх хэрэгтэй гэдэгт санал нийлдэг. Гэлээ гээд тэд нар эрх мэдэл “төр”-д гагнагдчихаагүй харин үлдсэн биднийхээ л адил алдаа хийдэг бодит хүмүүн төрөлтөнтэй эрх мэдэл гагнагдчихдаг гэдгийг мэддэг. Тэд нар эрх мэдэл авилгад автах хандлагатай, мөн улстөрчид үнэндээ өөрийн ашиг сонирхол болох бодлогоо “олон нийтийн ашиг сонирхол” гэж голдуу хэлж дурддаг гэдгийг бас мэднэ.

Үүн дээр нэмээд Английн философич Жон Локк (1632–1704 он) зэрэг нийгмийн гэрээний онолч нар засгийн газрын эрх мэдэл үүний эсрэгээр хувь хүмүүсээс ирдэг гэж батлан өгүүлдэг. Хүмүүс нийт олноороо эрх чөлөөгөө хамгийн их байлгахын тулд зарим эрх чөлөөгөө засгийн газарт өгөх болно. Тийм учраас засгийн газар хувь хүмүүст өөрсдөд нь байдаг эрх мэдлээс давсан хуульзүйн дагуух эрх мэдэлтэй байдаггүй; засгийн газрын бүхэл зорилго эрх чөлөөг хязгаарлах биш харин түүнийг өргөжүүлж тэлэх явдал байдаг. Америкийн хувьсгалч сэтгэгч Томас Пэйне (1737–1809 он) иргэд энэхүү итгэлийг эвдсэн аливаа засгийн газрыг авч хаях эрхтэй байх хэрэгтэй гэж батлан өгүүлсэн байдаг.

Гэвч хувьсгал бол хамгийн сүүлд ашиглах эд ажээ/юм. Сонгодог либералчууд төлөөллийн, үндсэн хуулийн ардчиллыг хууль тогтоогчдоо хүмүүсийн өмнө хариуцлагатай байлгах гэж одоохондоо олж нээсэн хамгийн сайн арга зам гэдэгт итгэдэг. Сонгууль бол сайн удирдагчийг сонгох явдлаар зөвхөн зогсохгүй бас муу нэгнийг эрх мэдлээс авч хаях явдал байдаг. Сонгогчид нь сайтар хэр мэдээлэл сайтай, илүү няхуур байна удирдагчид нь илүү сайн ажиллана. Бүр ийм байсан ч ардчилалд хязгаар бий: ардчилал зарим нэг шийдвэр гаргах сайн арга зам байж болох ч ийм зүйл цөөхөн байдаг; ерөнхийдөө бид хувь хүмүүст сонголтоо хийхийг нь үлдээвэл тэр хамгийн сайн зүйл болно.

## *6. Хууль ёс*

Эрх мэдлийг хязгаарладаг, олон нийтэд зориулсан аюулгүй байдлыг бий болгодог өөр нэг зарчим бол хууль ёс[10] юм. Энэ нь бид засгийн газрын албан тушаалтны дур зоргын шийдвэрт биш харин мэдэгдэж буй хуульд захирагдах хэрэгтэй гэсэн, Америкийн төрийн зүтгэлтэн Жон Адамс (1785–1836 он) "хүмүүсийн биш харин хуулийн засгийн газар'[11] гэж хэлдэг үзэл санаа юм.

Сонгодог либералчууд хуулийг жендер, арьсны өнгө, шашин, хэл, гэр бүл эсвэл аливаа бусад үл зохих шинж байдлаас үл хамаарч хүн бүрд ижил тэнцүү хэрэглэх ёстой гэж ятгацгаадаг. Жирийн хүмүүст үйлчилдэг тэр хэмжээгээр хуулийг төр засгийн ажилтанд хэрэглэх ёстой; хэн ч "хуулийн дээр" байх ёсгүй.

Хууль ёсыг сахин хамгаалахад хувь хүмүүс эсвэл төр засаг залж чиглүүлэх боломжгүй бие даасан шүүхийн тогтолцоо шаардлагатай. Тэнд мөн эрх мэдэлтэй байгаа хүмүүс хуулийг өөрийн ашиг сонирхолд ашиглахаас сэргийлэх хабеас корпус буюу хувь хүний халдашгүй байдлын зарчим[12], шүүхийн иргэдийн төлөөлөгчөөр шүүлгэх[13], зохистой арга ажиллагаа[14] зэрэг шүүхийн суурь зарчимтай байх хэрэгтэй.

Хууль ёсны өөр нэг таатай үр дагавар бол энэ нь хүмүүс (үүн дотроо албан тушаалтнууд)-т хэрхэн үйл хийх, үйл хийхгүй

---

*10 rule of law-орос. верховенство закона-бас манайхан хуулийн засаглал гэж орчуулсан байдаг. Энэ нь алдаатай утгатай тул улам л их төөрөгдөлд оруулах тул хууль ёс гэж буулгалаа. Угтаа rule of law гэдэг зүйл rule of conduct гэдгээс үүсэж гарсан зүйл юм.*

*11 a government of laws, and not of men*

*12 habeas corpus-Үндсэн хуульд заадаг, хуульгүйгээр, тодорхойгүйгээр шоронд хоригдохоос хамгаалдаг суурь эрх. Латинаар "надад биеийг нь харуул" гэсэн утгатай ажээ. Habeas corpus нь түүхэндээ гүйцэтгэх дур зоргын эрх мэдлээс хувь хүний эрх чөлөөг хамгаалах чухал арга хэрэгсэл байсаар ирсэн.*

*13 trial by jury*

*14 due process-орос. Правовы́е гара́нтии (или надлежащая правовая процедура) -Энэ бол үүсэж тогтсон ёс журам, зарчмын дагуу хуульзүйн хэрэг явдлыг шийдэх, мөн хувь хүмүүстэй чин шударга харьцахыг шаарддаг зарчим юм.*

болохыг ухаж ойлгох боломж олгодог учраас амьдралыг илүү сайн таамаглахуйц болгоно. Тиймээс л бид бусдын олон аашаар сүйд болно гэсэн айдасгүйгээр урт хугацааны төлөвлөгөө гаргах боломжтой байдаг.

### *7. Өөрөө-тогтдог дэг журам*

Та нар том хэмжээтэй, нийлмэл нийгэмд бас түүнийг хэвийн удирдахад том, хүчирхэг засгийн газар хэрэгтэй гэж бодож болох юм; гэвч сонгодог либералчууд үгүйсгэж маргацгаана. Тэд нар төр засаг нийгмийн дэг журмын суурь биш гэдэгт итгэдэг. Бид эргэн тойрондоо байна гэж хардаг, нийгмийн нийлмэл институцүүд дийлэнхидээ төлөвлөж бодож гаргаагүй зүйл байна. Ийм институц *хүмүүний төлөвлөсөн бодлын үр дагавар биш харин хүмүүний үйлдл*ийн үр дүн байдаг.

Жишээлбэл ямар ч төв захиргаа эсвэл ухамсартай төлөвлөлт[15] хэл яриа, бидний уламжлал болон соёл, эсвэл бараа бүтээгдэхүүн болон үйлчилгээний зах зээл бий болоход хэрэгцээтэй байдаггүй. Иймэрхүү институц зүгээр л чөлөөт хүмүүсийн хоорондохь тоо томшгүй харилцаанаас үүсэж гаран, хувьсаж хөгжсөн. Хэрэв зуун зуун жилийн хугацаанд эдгээр нь хэрэгтэй, үр өгөөжтэй болох нь батлагдвал л тэсэж үлдэнэ; хэрэв үгүй бол тэдгээр нь өөрчлөгдөнө эсвэл гээгдэж орхигдоно.

Австрийн нийгмийн онолч Ф. А. Хаек (1899–1992 он) үүнээс гарах үр дүнг нь өөрөө-тогтдог дэг журам гэж нэрлэсэн. Өөрөө-тогтдог дэг журам асар их нарийн нийлмэл байх боломжтой. Тэдгээр дэг журам хувь хүмүүс дагаж мөрддөгөө ч анзаарч мэддэггүй, ховорхон л дүрсэлж тайлбарлах боломжтой, жишээлбэл хэлний зүйн дүрэм мэт зан үйлийн ёс журмыг дагаж мөрдөхөд хувьсаж хөгждөг. Хэн нэгэн ухаантан иймэрхүү нийлмэл дэг журмыг сайжруулдаггүй юм аа гэхэд ухаж ойлгох боломжтой гэж үздэг улстөрчид, албан тушаалтнууд адгийн тэнэгүүд билээ.

*15 central authority or conscious planning*

## *8. Өмч, Худалдаа, Зах Зээл*

Сонгодог либералчууд эд баялгийг засгийн газар бий болгодоггүй харин зах зээл дээр хувь хүмүүс хамтран ажиллах замаар л бүтээдэг гэдэгт итгэдэг. Чөлөөт хувь хүмүүс шинийг зохион бүтээх, бүтээж байгуулах, хадгалж хураах, хөрөнгө оруулах, эцэст нь сайн дураараа бараа бүтээгдэхүүн, үйлчилгээгээ харилцан ашигтай байхаар солилцох явдлаас хөгжил цэцэглэлт бий болно – энэ бол *чөлөөт зах зээлийн эдийн засг*ийн өөрөө-тогтдог дэг журам юм.

Энэхүү баялаг-бүтээдэг нийгмийн дэг журам жирийн ёс журмаас үүсэж гардаг: энэ бол төрөлжиж нарийн мэргэжих, арилжаа хийх боломж олгодог хувийн өмч болон гэрээг хүндлэх явдал ажээ.

Эрх чөлөө болон хувийн өмч хоорондоо маш нягт холбоотой. Зах зээлийн эдийн засаг, түүний бүтээдэг үүсгэдэг эд баялаг хүмүүс, эд бараа, үйлчилгээ, хөрөнгө үзэл санаа чөлөөтэй шилжих явдлаас хамаардаг. Хувийн эд хөрөнгө оршин байх нь араатан-шинжтэй засгийн газрын мөлжлөгийг хүмүүс эсэргүүцэх боломж олгоно.

Сонгодог либералчууд өмчийг хүчээр олж авахыг зөвшөөрдөггүй. Үнэндээ ихэнхи өмчийг бүтээдэг, мөн тариа ногоог тарьж ургуулдаг, байшинг барьж бүтээдэг, бас шинэ санааг хөгжүүлж боловсруулдаг билээ. Өмч өмчлөгчдөө үр өгөөжтэй байдаг нь илэрхий. Гэвч үнэндээ өмч л өргөн хүрээний хөгжил цэцэглэлтийг тэтгэдэг учраас л бүх хүнд өгөөжтэй байдаг.

## *9. Иргэний нийгэм*

Сонгодог либералчууд сайн дураараа л эвлэлдэн нэгдэх явдал[16] хувь хүний хэрэгцээг засгийн газраас илүү сайн хангадаг гэдэгт итгэцгээнэ. Тэд нар хувь хүмүүсийг чухалчлах явдлыг тодруулж харуулахынхаа хажуугаар тэд л хүмүүс гарцаардмал, ганц нэгээрээ амьдардаг[17], өөрийгөө-чухалчилдаггүй бодгаль[18] биш гэдгийг олж таньсан. Нөгөө талаасаа тэд нар нийгмийн амьтан бөгөөд

16 *voluntary associations*
17 *atomistic*
18 *self-centred beings*

тэдний үнэт зүйлийг хэсэгчилж хэлбэржүүлдэг гэр бүлэг, бүлэг хүн, хүмүүсийн хүрээлэлд амьдардаг - клуб, холбоо, нэгдэл, шашин, сургууль, хүмүүсийн цахим хүрээлэл, ухуулгын ажил[19], өөрсөддөө туслах бүлгэм[20], буяны байгууллага гээд бусад бүх институцийг бид *иргэний нийгэм* гэж нэрлэдэг.

Нэг нэгтэйгээ хүмүүс хэрхэн холбоотой байх явдалд эдгээр институц чухал хэсэг нь байна. Бидний ертөнцийг харах явдал[21], үнэ цэнэ, үйлдэл эдгээр институц дотор хэлбэржиж төрхөө олдог. Хамтын ажиллагааг эдгээр институцэд тулгуурлан бүтээх цогцлоох боломжтой. Үнэндээ иймэрхүү байдлаар эвлэлдэн нэгдэх эрх чөлөөгүй бол хамтын ажиллагаа орших боломжгүй бөгөөд эдгээр нь харилцан ойлголцлын үндэс суурь болдог.

Иргэний нийгэм мөн засгийн газар болон хувь хүмүүсийн дундахь *жийргэвч* институц байдаг. Хэрэв бид бүгд жинхэнээсээ тусгаарлагдмал, ганцаардмал хувь хүмүүс байсан сан бол бидний эрх чөлөөг дарангуйлагч засгийн газар хялбархаан гэгч нь дарж дарангуйлах байсан. Гэвч иргэний нийгмийн нийлмэл хоорондоо давхацсан хүрээ төр засгийн үйлдлийн өөр нэг хувилбар байгааг, жишээлбэл төрийн халамж[22]ийн оронд хувийн буяны байгууллага байх боломжтойг зөвхөн харуулаад зогсохгүй бас бидэнд төлөө нь тэмцэх нийтлэг ашиг сонирхол, тэмцэлдэх хүч чадал өгдөг билээ.

## *10. Хүмүүний нийтлэг үнэт зүйлс*

Сонгодог либералчууд тэгээд нийтлэг хүмүүнлэг чанараа харилцан үр өгөөжтэй байхад ашиглахыг хүсдэг. Тэд нар хууль ёсон дор орших амьд явах, эрх чөлөөт байдал, өмчийн үндсэн зарчмыг дэмжиж хамгаалцгаана. Эдгээр зарчим тэдний итгэдэгчлэн чөлөөт хүмүүсийн хоорондохь харилцан биесээ хүндлэх, хүлцэн тэвчих, түрэмгийллэл үл хэрэглэх, хамтран ажиллах явдал үндэслэсэн, нийгмийн өөрөө-тогтдог цэцэглэн хөгжиж буй дэг журмын үндэс

*19 campaigns*
*20 selfhelp groups*
*21 outlook*
*22 state welfare*

суурь ажээ.

Улстөрийн хувьд тэд нар үг хэлэх эрх чөлөө/үзэл бодлоо илэрхийлэх эрх/чөлөөтэй үзэл бодлоо илэрхийлэх, чөлөөтэй эвлэлдэн нэгдэх, хууль ёс[23]ыг талархан дэмждэг – мөн нэгэнт удирдагчид маань биднээс дутуугүй нүгэлтэй улс байдаг учраас эрх мэдэлд хүрсэн хүмүүс хамаагүй их муу зүйл хийхээс нь сэргийлэхийн тулд төр засагт хязгаарлалт байх ёстой гэдгийг дэмждэг.

Тэд нар сайн нийгэм дан ганц хүмүүний сайхан сэтгэл[24]д тулгуурлах боломжгүй гэдгийг мэддэг. Ийм нийгэм хоорондоо адилгүй, өөрийн-тусыг боддог хувь хүмүүсийн эв найртай хамтын ажиллагаанд үндэслэнэ. Тиймээс л тэд нар эрх чөлөө, хуулийн өмнө тэгш байдалтай байх, бидний бусдыг хохироохоос сэргийлдэг ч бидний амьдралыг чиглүүлэхийг оролддоггүй хүчтэй, итгэл даасан шүүхийн тогтолцоотой байхыг таашаан дэмждэг ажээ.

Эдийн засгийн хувьд сонгодог либералчууд чөлөөтэй үйлдвэрлэл эрхлэх, солилцоо хийх, хүмүүс, бараа бүтээгдэхүүн, хөрөнгө чөлөөтэй шилжиж нүүх явдлыг дэмжиж талархдаг. Тэд хувийн өмчийг хамгаалдаг бөгөөд татварлах явдлыг олон нийтийг батлан хамгаалах, зах зээлээс дутуу хангадаг аливаа бусад “олон нийтийн сайн сайхан”-ыг бүтээхэд шаардлагатай байхаар хэмжээтэй байлгахыг хүсдэг.

Энэ байдал бол сонгодог либерализмийг цомхон, лэзе фээр, харуулын үүрэгтэй төр[25] гэсэн нийтээр мэдэх ёжилсон дүрслэл[26]ээс нилээд ондоо зүйл юм. Шүүх нь дангаараа, жишээлбэл сахин хамгаалахад нь асар их, тасралтгүй үргэлжлэх хүчин чармайлт шаардагддаг маш нийлмэл институц байдаг. Сонгодог либералчууд хүмүүний амь нас, эрх чөлөөт байдал, өмчийг хамгаалах явдал жижиг ажил биш гэдгийг мэддэг билээ.

---

23 *free speech, free association, the rule of law*

24 *human benevolence*

25 *tiny, laissez-faire, night-watchman state*

26 *caricature -орос. карикатура-утга нь өвөрмөц шинжийг тодруулж ихэсгэн хошиноор аливаа зүйлийг дүрслэхийг хэлнэ.*

*Мэдээллийн-цонх: Америкийн Либерализмийн тухай тэмдэглэл тайлбар*

Америкчууд 'либерализм' гэж ярихдаа тэд нар сонгодог либерализмаас тэс ондоо зүйлийн тухай ярьж байдаг. Сонгодог либерализм, мөн 'хуучны либерализм' эсвэл 'Европ ойлголтоорхи либерализм[1]' гэдэг зүйл хувь хүмүүсийн эрх чөлөө; албадлагыг бууруулах; өмч, чөлөөт солилцоо; эрх чөлөөг хамгаалдаг, түүнийг тэлж өргөжүүлдэг хязгаарлагдмал, хариуцлага хүлээдэг төр засагт анхаарал хандуулна.

Америкийн эсвэл 'шинэ либерализм' эсвэл 'орчин үеийн либерализм' нь хувийн эрх чөлөөнд гүн итгэх үзлийг хуваалцдаг ч эрх чөлөө бол зүгээр нэг албадлага байхгүй байхаас ч илүү том зүйл гэж үздэг – үүнийг патерналист буюу халамжлагч болон интервенционалист төр засаг нөхцөлдүүлэх боломжтой гэж үзнэ.

Америкийн либералчууд төр хүмүүсийг өөрсдөөс нь, голдуу өмчийн өмчлөх эрхээс бий болдог эрх мэдлийн шударга бус тэгш бус байдлаас хамгаалах үүрэгтэй гэж хэлдэг. Тэд нар ядууст нөхөн төлбөр өгч, ажилчдыг (илүү хүчирхэг) ажил олгогчийнх нь эсрэг тэмцэхэд дэмжих гэж нийгмийн өгөөмөр халамжийг шаарддаг. Тэд эдийн засгийн эрх мэдлээс олон нийтийн (ажил эрхлэх байдал их болох зэрэг) үр өгөөж гардаг гэдэгт итгэл муутай байдаг ч харин төр хүмүүсийн бололцоог ихэсгэж өргөжүүлэх, олон нийтийн сайн сайхнаар хангах, зах зээлийг болон нийтийн ашиг сонирхолд үйлчилдэг болгохын тулд хөндлөнгөөс оролцох хэрэгтэй гэдэгт итгэцгээнэ.

Сонгодог либералчууд ийм бодлогод маш сэжиглэнгүй ханддаг. Тэд нар засгийн газрын эрх мэдлийг хэрэгцээтэй хязгаараас нь хамаагүй давуулж хялбархаан томруулах боломжтой гэж айж эмээнэ; бүр хамгийн сайн зорилго тусгасан бодлого ч гэсэн баргар, зориогүй үр дагаварт хүрдэг гэдгийг зааж хэлцгээдэг.

---

1 *liberalism in the European sense'*

# ГУРАВДУГААР БҮЛЭГ:
# Сонгодог Либерализм: Ургийн бичиг

## Эхэн Үеийн Өвөг Дээдэс

Зарим сонгодог либералчууд өөрсдийнх нь үзэл санаа удирдагчдад тавих хязгаарлалтыг өмгөөлж хамгаалдаг байдаг байсан, Хятадын философич Лаоз[1]д байсан гэж үзэх нь бий. Хоёр мянганы өмнө, Энэтхэгийн эзэн хаан Ашока бас л эрх чөлөө, улстөрийн хүлцэн тэвчих явдлыг уриалж шаардаж байсан. Бүр дөнгөж дэлгэрч эхэлж асан 6-р зуунаас л Исламд эдийн засгийн эрх чөлөөг хүлээн зөвшөөрч байлаа.

Гэвч эдгээр хүмүүс орчин үеийн сонгодог либерализмийн холын хамаатнууд юм. Европ дахь шууд удам нь үнэндээ Англичууд байв. Сонгодог либерал сэтгэгч, улстөрч Даниэл Ханнан (1971 онд төрсөн)-ы бодлоор Англи-Саксоныхон өнөөдөр бидний Англи гэж нэрлэдэг газар [НТ-ын] 400 оны орчимд суурьшиж энэ бүхэн эхэлсэн ажээ.

## Англи-Саксоны Англи нутаг

Эзлэн түрэмгийлэхэд хэцүү арлын үндэстэн болох Англи эхгазрын Европоо бодвол ажин түжин байдлыг хамаагүй ихээр таашаан эдэлж ирсэн бөгөөд тэнд л өмчийн эрх болон шүүхийн аюулгүй тогтолцоо үүсэж гарсан. Энэ нь хэн нэгний ухамсартай зорьсон зүйл биш харин бэлчээрээ харуулдах бух адил бат зогсдог, гадны халдагсдаас эрхээ хамгаалдаг, бие даасан бодолтой Англи-Саксончуудын аажуу явцтай үйлийн үр дагавар юм.

Хожим нь 800-аад оны үед суурьшиж эхэлсэн Викингүүдтэй

---

1 *Laozi, (хятад. "Lao Багш" эсвэл "Настай Багш", )- Энэ хүн НТӨ 6-р зуунд Хятадад мандан бадарч байжээ. Хятадын Даоизмын анхны гүн ухаантан, анхны Бумбын сургаал болох "Даодежинг" номын зохиогч гэгддэг хүн юм. Лаозыг Күнзийнхэн гүн ухаантан гэдэг бол ард олон нь гэгээнтэн эсвэл бурхан гэж биширдэг ажээ. Күнз, Бумба, Буддизм бол хятадын бодол санааны гурван гол урсгал юм,*

зэрэгцэж амьдрах хэрэгцээ шаардлагаас урьдаас зорьж тэмүүлээгүй нийтлэг хэл, хуульзүйн нийтлэг харилцаа бас адилхан үүсэж гарав. Европ маягийн феодалын засаг захиргаа байхгүй байсан учраас л энэхүү хайлах зуухнаас *нийтийн хууль*[2] гэдэг зүйл гарчээ – энэ хууль бол хүчирхэг мэдэлтнүүдийн гаргасан *хан хөвүүдийн хууль* гэхээсээ илүүтэй хувь хүмүүсийн харилцаанаас хөгжиж хувьссан, *улсын хууль*[3] юм.

Энэ нийтийн хууль өнөөдөр сонгодог либерализмийн гол үндэс болсон хэвээр байна. Энэ нь эзэн хааны тогтоодог биш харин хүмүүс өөрсдөө тогтоодог зүйл байв. Энэ хуульд хувь хүн өмчтэй байх болон гэрээг хүндэлдэг байсан. Түүнд хуулийн дор орших эрх чөлөөт байдлыг хүлээн зөвшөөрсөн байлаа. Хэн ч үйл хийхээсээ өмнө зөвшөөрөл авдаггүй: тусгайлан хориогүй аливаа зүйл хуульзүйн дагуу зөвшөөрсөн зүйл байсан. Хууль хүн бүрийн хэрэг байж, хуулийн түшмэд ч хариуцлага хүлээдэг байв. Бүр хааныг ч гэсэн түүнээс үнэнч байхыг шаарддаг Өтгөсийн Зөвлөл (Витан[4])-өөс сонгож байсан байдаг - эзэн хаан зөвлөлөөс өөрт нь үнэнч байхыг шаарддаггүй байжээ.

## Эзлэн түрэмгийлэлд өртсөн нь, дахин боссон нь

Энэ байдал 1066 онд Нормандчуудын эзлэн түрэмгийлэл, цэргийн хүчээр эзлэн авсан явдл[5]аар дуусгавар болов. Английг хэл, захирч

---

2 *common law-нийт олон+хууль=нийтийн хууль (СЭХ-сондгойруулахгүйг эрхэмлэх хууль)*

3 *law of the land -Улсын хууль бол улс оронд эсвэл юрисдикц эсвэл тодорхой хугацаанд хүчинтэй байгаа, байсан хүчин төгөлдөр хууль, статутын бүрдлийн нийт бүтцийг хэлдэг. Улсын хууль гэдэг энэ хэллэг бол хуульзүйн хэллэг юм. Энэ нь Латины lex terrae, эсвэл legem terrae гэсэнтэй дүйнэ. Түүнд улс орон эсвэл мужид хүчин төгөлдөр, үүн дотроо статут хууль эсвэл тодорхой жишээнээс гардаг хууль (анг. case-made law) ч ордог бүх хуулийг хэлдэг*

4 *Witan (The Witan)- "цэцэн хүмүүс" гэсэн утгатай энэ зөвлөл Англи-Саксоны Англид 7-р зуунаас 11-р зуун хүртэл хааны зөвлөл байжээ. Энэ зөвлөлд сүм хийд, жирийн иргэдийн магнатуудаас бүрдэж байв. Үүнийг заримдаа Witenagemot гэдэг байсан.-Цэцдийн Зөвлөл*

5 *Norman invasion and military occupation - 1066 оны Зул Сарын өдөр Английн хаан Виллиам Вестминстер Аббейд Английн хаанаар өргөмжилжээ. Тийм*

удирдах арга замаараа Английн хүн амаас хол хөндий хүмүүс болох Европын элитүүд буюу язгууртнууд захирах болсон. Тэд нар феодализм[6], боол, нийгэм давхаргажих явдал[7], хууль-хийх дээрээс доош хандсан явц[8]ыг хүчээр авчирч хэрэгжүүлэв – энэ нь бүхэлдээ Англи-Саксончуудын мэддэг байсан эрх чөлөө, хязгаарлагдмал-эрх мэдэлтэй төр засгийн эсрэг зүйл байлаа.

Гэвч хэдхэн үеийн дотор л Нормандын газрын эзэд[9] энэ нутгийнхнаас улам бүр хөндийрцгөөв; эдгээр ордны Франц бараа бологсдоороо тусгаарлагдсан Жон Хаан (1166–1216 он) улам бүр харгис, дарангуй болж харагдан, татварын орлогоо нэмэгдүүлэхийн тулд хуулийг дур зоргоороо өөрчилж янзалдаг болов.

Үр дүнд нь 1215 онд Английн баронууд хаанаа эрхүүд болон давуу эрхүүдийн аугаа тунхаг болох Магна Харт буюу Эрх Чөлөөний Аугаа Тунхаг[10]д гарын үсэг зуруулахаар албадан хүчилж чадав.

Энэхүү тунхгийн ихэнхид нь өнөөдөр чухал ач холбогдолтой гэж сонгодог либералчуудын үздэг, хүмүүсийн эртний *өмчийн эрх*ийг дахин бататгасан, албан тушаалтнуудын аливаа дур зоргын эзэрхэх гэсэн үйлдлээс хамгаалсан, өмчийн эрхийн баталгаажсан төрлүүд[11]ийн тухай дурдсан байдаг.

Гэвч энэхүү тунхгийн гол хэсэгт нь эртний эрх чөлөөнүүдийг, сүм, хот, нийт олны эрх чөлөө болон иргэдийн төлөөлөгчдөөр шүүлгэх[12], хуулийн зохих арга ажиллагаанд эрх эдлэх[13] зэрэг

---

*учраас энд онд Английг Виллиам Английг цэргийн хүчээр Нормандчууд эзлэн авсан явдал юм. Тэрбээр Нормандчууд, Бретон, Флемиш, Францын бусад цэргүүдээс бүрдсэн асар том флот болон армиар эзлэн түрэмгийлжээ.*

6 *feudalism*

7 *social stratification*

8 *topdown law-making*

9 *Norman landowners*

10 *great charter (Magna Carta) - Тунхаг -орос. Великая хартия вольностей- Үүний монгол орчуулгыг www.libraryforfreepeople.mn -ээс бүрнээр нь уншина уу.*

11 *secure rights of tenure*

12 *trial by jury*

13 *Due process - 16-р нүүрний 14-р тайлбар зүүлтийг уншина уу.*

сонгодог либерал зарчмуудыг хөдөлшгүйгээр томьёолон бичсэн байдаг. Түүнд бүр хаан бусад бүх хүний адил “улсын хууль”-аар хязгаарлагдсан байх болно гэдгийг батлан өгүүлсэн. Өөрөөр хэлбэл *хууль ёс*онд төр засаг захирагдана гэсэн үг ажээ.

Хэдий Жон хаан энэхүү тунхгийг хүлээн зөвшөөрөхөөсөө татгалзаж буйгаа зарласан ч удалгүй үхжээ. Түүний хүү III Хенри балчир насандаа хаан суудалд суусан бөгөөд эрх мэдэл эзэн хаанаас баронуудын хурал руу үл мэдэг шилжив. Хенри сайн дураараа 1225 онд энэхүү тунхгийг дахин гаргав. Гэвч баронуудтай дайнд зориулсан татвартай голчлон холбоотойгоор улам цааш тэмцэлдсэн явдал Англид сонгодог либералчуудын өөр нэг санаачилга, Парламент[14] үүсэхэд хүргэжээ.

## Сонгодог либерализм өндийн боссон нь

### *Соёлын болон шашны хувьсгал*

Английн түүхч Лорд Актон (1834–1902 он): ‘Эрх чөлөөт байдал эрх мэдлүүдийн зөрчилдөөнөөс үүсэж тогтсон’ гэж бичсэн байдаг. Эхгазрын Европд Баруун хэсэгт нь байх Ром Гүрэн болон түүнийг дагуул феодалын лордууд, эзэн хаадын засаг захиргаа Загалмайтны Сүм хийд өсөж өндийхөд сорилтод оров. Тэд нар чөлөөт институцийг ухамсартайгаар хөгжүүлээгүй харин нэг нэгэндээ харилцан хязгаарлалт тавьсан нь хувийн эрх чөлөөний асар их бололцоог нээж өглөө.

Европ дахь өөр хоёр түүхэн үйл явдлаар хувь хүний эрх чөлөө төрийн эрх мэдлээс чухал болохыг хөдөлшгүй харуулав. Ойролцоогоор арвантаваас арванзургаадугаар зууны хооронд гарсан Гэгээрлийн Эрин[15] болох соёлын хувьсгалын гол хэсэг нь

14 *Parlament -1295 онд зарлан хуралдуулсан, Үлгэр Парламент гэж нийтээр мэдэх, бас өргөн олноороо анхны төлөөллийн парламент гэж үздэг энэхүү парламентэд анх удаа гүнлэг болгоноос хоёр хөлөг баатар, сум болгоноос хоёр аж ахуйтан, хот бүрээс хоёр иргэний хамтаар доод зиндааны лам нар оржжэ.*

15 *Renaissance*

1450 онд хэвлэлийн дардас Европт гарч ирсэн явдал байсан[16]. Энэхүү жирийн шинэ бүтээл шинжлэх ухаан, суралцах явдал дахь язгууртнууд буюу элитүүдийн монополь байдлыг устгаж, жирийн иргэд мэдлэг олж авах боломж олголоо. Хэн ч одоо зааварчилгаа, зөвшөөрөл авах гэж засаг захиргаатай зөвлөлдөх хэрэггүй болов: тэд сонголтоо хийхдээ үүнийгээ үндэслэх мэдээлэлтэй болжээ.

Мартин Лүтер[17] ламтан 1517 онд очийг нь асаасан Протестант Шинэчлэл[18] үүнд улам бүр хүч нэмэв. Энэ шинэчлэл Католик Сүмийн эрх мэдлийг сорьж, жирийн хүмүүсийн өөрийгөө үнэлэх үнэлэмжийг тэд Бурхантай язгууртан ламтны давхарг[19]ын зуучлал үгүйгээр шууд, хувиараа, ижил тэнцүү харьцах боломжтой гэдгийг батлан өгүүлэх замаар өсгөж нэмэгдүүлэв.

Энэ бүгд эрх мэдлийн үүсэж тогтчихсон институцээс давж хувь хүний байр суурь, ач холбогдол өсөж өндийхөд үйлчилсэн байна. Энэхүү эрх чөлөө хаана хамгийн их хөгжиж цэцэглэсэн улс байна тэнд урлаг, аж үйлдвэр, шинжлэх ухаан, арилжаа мөн л цэцэглэж байв.

## *Улстөрийн хувьсгал*

Улстөрийн хувьд юмс үзэгдэл бас өөрчлөгдөж байлаа. Эрх чөлөөний төлөөх олныг хамарсан хөдөлгөөн болох Левеллерчүүд[20] 1650

---

16 *Иоханнес Гүтенберг (1393-аас 1406 онд төрсөн – 1468 онд нас барсан) өрдөг үсэг бүхий метал дардасаар хэвлэх төхөөрөмж зохион бүтээснээр хэвлэлийн шинэ эрин эхлэжээ. 15-р зууны сүүлээр Гүтенбергийг Библ судар Европ даяар тархах болсноор хямд өртөгтэй ном бүтээх үйлдвэрлэлийг хаа сайгүй түгээн дэлгэрүүлжээ.*

17 *Martin Luther-(1483-1546 он)-Герман үндэстэн, шашны номлогч, германы бичгийн-хэлний үндэслэгчдийн нэг. Протестант шашины урсгалыг үндэслэгчдийн нэг. Библийг анх Герман хэлээр орчуулан гаргажээ. Үүнээс урьд библийг зөвхөн латин хэлээр үздэг байв. Түүний утгыг лам нар, номлогч нар л өргөн олонд хэлж өгч байжээ.*

18 *Protestant Reformation*

19 *elite priesthood*

20 *The Levellers - Английн Иргэний Дайн (1642–1651 он) ард олны бие даасан байдал, бүх нийтийн сонгогдох сонгох эрхийг өргөжүүлэх, хуулийн өмнө бүгд ижил тэгш байх, шашны хүлцэхүйг үнэнчээр дэмжиж асан, улстөрийн хөдөлгөөн. Левеллерчүүдийн бодол санааны гол шинж нь тэд*

онд Англи даяар өрнөв. Энэ хөдөлгөөнийг хүмүүсийн эрх төрөлх байдаг харин төр засгаас эсвэл хуулиар бэлэглэсэн зүйл биш гэж шаргуу ятгадаг байсан Жон Лилбөрн (1614–57 он) удирдсан билээ. Лицензгүй (албан монополь эрхийг үл харгалзан)-гээр ном хэвлэсэн гэж баривчлагдсан тэрбээр алдартай Одот Танхим[21]ын өмнө гарсан ч шүүгчдэд сөгдөхөөсөө (өөрийгөө тэд нартай эрх тэгш хүн гэж зүтгэн) эсвэл тэдний арга ажиллагааг хүлээн зөвшөөрөхөөс татгалзаж байв. Бүр гутаах шон[22]д дөнгөлөгдсөн байхдаа ч тэрбээр эрх чөлөө, тэгш эрхийн төлөө марган мэтгэлцэж байсан бөгөөд засаг захиргаатай тэрсэлдсэн түүнийг эргэлзэх юмгүйгээр хэд хэдэн удаа шоронд хорьжээ.

Лилбөрн олонд таалагддаг тогтсон төрийн байгуулалтын эсрэг тэмцдэг зүтгэлтэн болсон. Тэрбээр төрийн монополь эрхийг төгсгөж үгүй хийхийн төлөө зарга мэдүүлж байсан бөгөөд эрхийн тухай билл[23]д заасан зүйлсийг тайлбарлан таниулж байв. Энэ үйлсийг нь Лордын Танхимын шүүх эрх мэдлийг хүлээн зөвшөөрөхөөс татгалзаж шоронд хоригдож байсан, мөн өөрийн нэр дээрээ өмчтэй, өөр хэн нэгэн хүн түүнийг хүчээр булаан авах боломжгүй тийм чөлөөт хүмүүсийн хоорондох бичмэл үндсэн хуулийн “нийгмийн гэрээ” байгуулахыг уриалж шаарддаг байсан Ричард Овертон (ойр. 1610–63 он) цааш нь үргэлжлүүлжээ.

### *Эзэн хаадын эрх мэдлийг хязгаарласан нь*

Английн Иргэний Дайн (1642–51 он)-ы дараагаар хаанчилж байсан эзэн хаан I Чарлз шүүхээр орж, улсаасаа урвасан гэж цаазлуулсан

*жам ёсны тэгш эрхийн дээдлэдэг, мөн олон нийтэд чанга дуугаар ханддаг, элдэв зурагт хуудас таардгаараа популизм байжээ.*

21 *Star Chamber (The Star Chamber (Latin: Camera stellata)) - 15-р зуунаас 17-р зууны дунд хүртэл эзэн хааны Вестминстер Ордонд хуралддаг байсан Англи Шүүхийн байр.*

22 *pillory -орос. позорный столб-Босоо шонд хүний гар толгойг нь оруулан дөнгөлдөг хийцийг хэлнэ. Хажуугаар явсан улс элдэв зүйл шидэж, доромжилдог байжээ*

23 *bill of rights-1689 оны Bill of Rights бол Английн Парламентад тодорхой эрх оноон өгсөн хууль юм. Энэ бол эрхүүдийн тухай хууль ажээ. Түүнд иргэн болон улс оронд чухал эрхүүдийг жагсаан бичдэг.*

– энэ бол төр засгийн засаг захиргаанд тавьсан хязгаарлалтын маш харгис ширүүн илэрхийлэл байсан юм.

Гэвч хаан болон Парламентын хоорондохь эрх мэдлийн харилцаа аль хэдийнээ эргэв. Арлын үндэстэн болох Их Британид өөрийгөө халдан довтлох явдлаас хамгаалахад шаардлагатай байнгын армитай байсангүй. Иймээс л эхгазрын Европтой адилгүй нь эзэн хаадад нь олон нийтийг дарж дарангуйлах, мөлжихөд ашиглах боломжтой цэргийн хүч байхгүй байсан. Чарлзад гадаадад хийх дайнаа санхүүжүүлэх гэж татвараа нэмэгдүүлэхийн тулд Парламенттайгаа санал нэгдэх хэрэгтэй байв.

Гарцгүй болсон, атаархуу эзэн хаан олон ч зөрчилдөөн үүсгэв. Энэ бүгдийн дунд Чарлз Парламентыг тарааж, тэдний зөвшөөрсөн саналгүйгээр татвар татахыг эрэлхийлэн хамгийн нэр хүндтэй таван гишүүнийг нь хүчээр баривчлахыг оролдсон байдаг. Тэрбээр эрхийг нь аюулгүй болгож баталгаажуулсан хүмүүстэйгээ байгуулсан тов тодорхой гэрээгээ зөрчжээ.

### *Бахархалт Хувьсгал*[24]

Оливер Кромвелийн дарангуйлал доорхи засаглал хоорондын завсрын үе[25] (1649–60 он)-ийн дараа засаг захиргааны тэнцвэр 2-р Чарлзын хүү хаан болохын тулд Парламентийг номотгох гэхэд дахин ил болов. Түүний өв залгамжлагч, Чарлзын хоёрдохь хүү II Жэймсийг хаан ширээнээс зайлуулаад, (Оранжийн Хан хүү Герцог) Виллиам болон Мэрийг хаан ширээнд урьж авчирсан нь Парламентын шийдвэр байжээ. Хүмүүсээс эзэн хаанаа удирдсан, засаг захиргааг удирдах чиглүүлэх явдал үүнээс илүү тод харагдсан нь үгүй.

1689 онд Виллиам болон Мэри хоёр Британийн иргэдийн эрх чөлөө болон эрх чөлөөт байдлын баталгаа болох, мөн эрх, эрх чөлөөт байдлыг нь зөрчсөн гэсэн үндэслэлээр Жэймсийг хаан

---

*24 Glorious Revolution*

*25 interregnum - орос. междуцарствие - дараалсан засаглал эсвэл дэглэмийн дунд эзэн хааны ор эзгүй байх үеийг, төр засгийн жирийн хяналт зогссон үеийг хэлдэг байна.*

ширээнээс буулгах үндэслэл болсон Эрхийн тухай Билл[26]-д гарын үсэг зуржээ. Түүнд эзэн хаанаас хамааралгүй бие даасан шүүхийн тогтолцоо, Парламентын зөвшөөрөлгүйгээр татвар татах явдлыг дуусгавар болгох, өширхөх явдлаас эмээхгүйгээр засгийн газарт зарга мэдүүлэх эрх, чөлөөт сонгууль, Парламентад үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө[27], 'харгис хэрцгий, ер бусын шийтгэл' оноох явдлыг эцэс болгохыг шаардсан байдаг. Энэ нь дахин нэг өөр аугаа сонгодог либерал санаачилга Америкийн Эрхийн тухай Билл нэг зууны дараа гарахад шууд уриалан дуудсан билээ.

## *Жон Локк (1632–1704 он)*

Жон Локк сонгодог либерализмийн эртний номлолуудыг хамтад нь сонгодог либерал сэтгэлгээний хүлээн зөвшөөгдөхүйц, ялгарч танигдахуйц орчин үеийн бүтэцтэй болгож зураглаж буулгасан. Түүний зорилгын нэг хэсэг нь II Жэймс хаан ширээгээ нийгмийн гэрээгээ зөрчсөний улмаас хураалгасан болохыг харуулах явдал байв. Бүх бие даасан байдал түүний хэлэхээр аюулгүй байдлаа улам сайжруулах, ерөнхий эрх чөлөөгөө тэлж өргөжүүлэхийн тулд л түүнд гагцхүү захирагддаг хүмүүсээс үүсэж гардаг гэдгийг тэрбээр батлан өгүүлжээ. Энэхүү гэрээ зөрчигдөхөд хувь хүн бүр эзэн хааныхаа эсрэг босох эрхтэй.

Локк мөн хүмүүн төрөлхтөн төр засгаас ч өмнө байсаар ирсэн, засгийн газарт өргөл болгон өгөх боломжгүй төрөлхи эрхтэй гэж баталж өгүүлдэг, *жам ёсны эрхийн онол*ыг хөгжүүлжээ. Эдгээр эрхийг хязгаарладаг төр засаг хуульзүйн бүрэн эрхгүй[28] байсан.

Гэвч Локкийн үзэл санааны цөм зөвхөн биет өмчөөр зогсохгүй бас хувийн өмч байсан билээ. Локк хүмүүс амь нас, бие хаа, хөдөлмөрөө өмчилдөг, *өөрийгөө-өмчилдөг*[29] гэдгийг сахин хамгаалж байв. Энэхүү гүнзгий ойлголтоосоо тэрбээр хүмүүс бүтээхэд нь хувийн хүчин чармайлтаа оруулсан, "хөдөлмөрөө хамтруулан шингээсэн"

*26 Bill of Rights-Эрхийн тухай Цааз гэвэл ч зүгээр юм уу.*
*27 freedom of speech*
*28 illegitimate*
*29 self-ownership*

бүх зүйлээ өмчлөх ёстой гэдгийг дүгнэн гаргасан. Тиймээс л энэ өөрийгөө-өмчлөх зарчим л иймэрхүү өмчийг хуулийн дор айх аюулгүй баталгаатай болгох ёстой гэдгийг чухал зүйл болгов.

Эдгээр үзэл санаа Америкийн Хувьсгалын ард байсан олон сэтгэгчийн нүдийг нээх болно.

*Гэгээрлийн Эрин*

Арваннаймдугаар зуун сонгодог сэтгэлгээ дахин нэг удаа амилан боссон явдлын гэрч болсон билээ. Францад Монтескю (1689–1755 он) чөлөөт нийгэмд, чөлөөт эдийн засагт хувь хүмүүс эв найртай хамтын ажиллагааг бататган хамгаалах тийм арга замаар үйл хийх хэрэгтэй, ингэхдээ аливаа засаг захиргаанаас тушаал шийдвэр авах хэрэгцээгүй тухай үзэл санааг хөгжүүлэв. Тиймээс л тэрбээр Америк сэтгэгчдийн нүдийг нээх өөр нэг санаа болох төр засгийн эрх мэдэлд тавих биесээ хянах болон эрх мэдлийг тэнцвэржүүлэх тогтолцоо[30]г уриалж шаардаж байжээ.

Үүний хажуугаар сүм хийдийн авторитарианизмын эсрэг өсөн нэмэгдэж буй оюун санааны бослого Волтэйр (1694–1778 он) зэрэг сэтгэгч нар саруул ухаан болон хүлцэхүй, шашны ондоошил болон хүмүүнлэг шударга ёс[31]ыг шаардахад хүргэв. Эдийн засгийн ухаанд бас л Тюрго[32] (1727–81 он) зэрэг сэхээтнүүд арилжаа худалдааны хориг саадыг арилгах, татварыг хялбаршуулах, хөдөлмөр болон хөдөө аж ахуйн илүү өрсөлдөөнтэй зах зээлийг өмгөөлөн мэтгэлцэж маргаж байлаа.

Шотландын философич, эдийн засагч Адам Смит (1723–90 он) Монтескюгийн чиг шугамын дагуу олон тохиолдолд хэрхэн хувь

---

*30 system of checks and balances on government power - орос. система сдержек и противовесов*

*31 reason and toleration, religious diversity and humane justice*

*32 Turgot -(Anne Robert Jacques Turgot, 1727 – 1781 он)- Франц үндэстэн, эдийн засагч, төрийн зүтгэлтэн байв. Анхандаа физиократ гэж үздэг байсан тэрбээр өнөөдөр эдийн засгийн либерализмийн түрүү үеийн төлөөлөгч гэж дурсагдах болжээ. Энэ хүнийг хөдөө аж ахуйн салбар дахь хязгаарын ашгийг үгүй хийж буй хуулийг анх таньж мэдсэн эдийн засагч гэж бас үздэг.*

хүмүүсийн чөлөөт харилцаанаас бүх нийтэд үр өгөөжтэй үр дүн гарах хандлагатай байдгийг тайлбарлав – энэ үр нөлөөг *үл үзэгдэх гар* гэж нэрлэдэг. Өөрийн-тусыг бодох[33] нь бидний эдийн засгийн амьдралыг хөдөлгөх боломжтой ч бид өөрсдөдөө аливаа ашиг тустай байхын тулд хэрэглэгчдэдээ тус хүргэх хэрэгтэй ажээ.

Смит албан ёсны монополь байдал[34], худалдааны хориг, их татвар, засгийн газар болон бизнесийн хооронд тогтдог боомилогч кронизм[35]ын эсрэг муу үгээр тэмцэлдэж байв. Тэрбээр нээлттэй, өрсөлдөөнт зах зээл олон нийтийг, ялангуяа ажил эрхэлж буй ядуусыг хүлээснээс чөлөөлөх болно гэдэгт итгэдэг байсан. Түүний үзэл санаа аливаа бодлогод асар ихээр нөлөөлсөн бөгөөд урт хугацаанд үргэлжилсэн чөлөөт худалдаа, эдийн засгийн өсөлтийн үүдийг нээсэн билээ.

### *Хуульзүйн дагуухь Төр буюу Рехтштаат[36]*

Энэ үеэр Европ тивд Герман философич Иммануэл Кант (1724–1804 он) зэрэг сэтгэгчид хожим нь арваннаймдугаар зуунд Америк болон Францын үндсэн хуулийн мэдлэгийн суурь болох “шударга төр” эсвэл *Рехтштаат*ын зарчмыг хөгжүүлж байв.

Кант бичмэл үндсэн хуулийг хоорондоо ялгаатай хувь хүмүүс байнга эв найртай хамтаараа амьдрах арга зам гэж түүний төлөө маргаж мэтгэлцэж байлаа. Тэрбээр ёс суртахууны боловсрол энэ ялгаатай байдлыг багасгах, хүн бүрийн зорилгыг хооронд нь давхцуулах боломжтой гэсэн Утопи санааг үл тоосон юм. Төр хоорондоо ялгаатай хувь хүмүүсийг харилцан үр өгөөжтэй байхаар нэгдэх боломж олгох төдий л зүйл байсан бол үндсэн хууль энэ нэгдлийг нэгдмэл байлгадаг зүйл ажээ.

Рехтштаатад иргэний нийгмийн институц, үүн дотроо клүб,

---

*33 Self-interest*

*34 official monopolies*

*35 suffocating cronyism*

*36 Rechtsstaat - (lit. “state of law”; “legal state”) -Герман болон Голландын юриспрүденцээс үүсэж гарсан, эхгазрын Европын хуульзүйн сэтгэлгээний сургаал ажээ-орос. Правовое государство*

нийгэмлэг, сүм хийд зэрэг сайн дурын нэгдэл энэхүү нийгмийн зохицлыг дэмжихэд ижил тэнцүү үүрэгтэй байх болно. Төр засгийн эрх мэдлийг зааглаж хуваан хязгаарлах бөгөөд шүүх болон улстөрч хариуцлага хүлээдэг, хуульд захирагддаг болно. Хууль нь өөрөө ил тод, сайтар тайлбарласан, зохистой[37] байх болно. Хүч хэрэглэх явдлыг нь шүүх тогтолцоогоор чанд хязгаарлах болно. Үндсэн хуулийн энэ шударга дэг журмыг сахин хамгаалах явдал төр засгийн шалгуур байх болно.

## Амжилт, Дахин Үнэлэгдсэн нь

### *Сонгодог либерализмийн шинэ гэр*

Томас Пэйне жам ёсны эрх, нийгмийн гэрээ, засгийн газар хэрэв хянахгүй л бол үл тэвчих зүйл болж хувирдаг, зайлшгүй хэрэгцээтэй муу зүйл юм гэсэн Локкийн олон сонгодог либерал санааг авсан байдаг. 1776 оны 1-р сард тэрбээр эдгээрийг шилжин суурьшигчид[38]тай хийсэн гэрээгээ зөрчсөн гэж Британийг буруутгаж, зэвсэглэхийг уриалсан, маш нөлөөтэй байсан *Саруул Ухаан*[39]даа шигтгэж суулгажээ.

Энэ дайн самууны дараагаар Америкчууд өөрсдөө болон тэдний байгуулж буй төр засгийн хоорондохь сонгодог либерал шинэ гэрээг эрж хайх хэрэгтэй болсон нь жам ёсны хэрэг билээ. Тэд Үндсэн Хуульдаа Локкийн жам ёсны, салшгүй эрхийн үзэл болон төр засгийн мэдлийг Монтескю-маягтайгаар хуваах явдлыг суулгаж өгсөн.

### *Арваннаймдугаар Зуун*

Гэвч шинэ, радикал сонгодог либерал үзэл санаа Британид эргэн ирлээ. 1833 он гэхэд сонгодог либерал идэвхтэнүүд Британи Гүрэн даяар боолчлох явдлыг үгүй хийх явдлыг баталгаажуулсан бөгөөд 1843 он гэхэд энэхүү шинэчлэл бүрэн дуусжээ.

37 *transparent, explained and proportionate*
38 *colonists*
39 *Common Sense*

Мөн нийгмийн тэргүүн шугам дээр Британийн философич, эдийн засагч Жон Стюарт Милл (1806–73 он) хүмүүс хүссэнээр үйл хийх боломжтой байх хэрэгтэй, ингэх үедээ бусдыг хохироохгүй, үүнээс улбаалаад тэдний эрх чөлөөг хумихгүй тухай "үл хохироох" зарчмаа зүйлчилж томьёолов. Тэрбээр мөн л төр хүрч оролцож чадахгүй 'хувийн оронзай[40]'-н төлөө маргаж мэтгэлцдэг байсан бөгөөд дараагаар нь утилитарич философич Жереми Бентам (1746–1832 он) эрх чөлөө олон нийтийн ашиг тус эсвэл "тав тух"[41]-ыг хамгийн их байлгах хамгийн сайн арга зам байсан гэдгийг батлан өгүүллээ.

Эдийн засгийн ухаанд худалдаа, үйлдвэрлэл, хөдөлмөрийн тухай лэзе фэер бодлогыг уриалж шаардаж байсан Ричард Кобден (1804–65 он), Жон Брайт (1811–89 он) нар гарамгай зүтгэлтэн нь байсан, импортолсон улаан буудайд оногдуулдаг протекционист татвар[42]ыг үгүй хийх арга эрэлхийлж байсан, Үр Тарианы Хуулийн Эсрэг Лиг буюу Нэгдэл Манчестерийн Сургууль[43] болж өсөж өндийв.

### *Дахин бахдуулан магтагдсан нь, уруудан доройтон буурсан нь*

Гэвч хурдтай өрнөсөн аж үйлдвэржилтийн дараагаар арванесдүгээр зууны дундуур ажиллах тааруу нөхцөл, нийгмийн давхраажилт, шилжилт хөдөлгөөн, төв суурины ядуурал зэрэг сорилт сонгодог либерализмд тулгарчээ. Хүмүүс улам бүр ихээр иймэрхүү муу зүйлийг зохицуулж шийдвэрлэ гэж төр засгаас шаардав.

Дараагаар нь хорьдугаар зуунд Европ дахь дайн самуун, аюул занал националист буюу үндсэрхэг соёл, төрийн үүрэгт илүү их итгэх явдлыг өрджээ. Дайны цаг үед өргөжиж тэлснийхээ дараагаар засгийн газрууд буцаж агшиж чадалгүй бүтэлгүйдэв. 1913 онд Дэлхийн Нэгдүгээр Дайны өмнө засгийн газрын зардал Францад дөнгөж ДНБ-ий 17 хувь, Германд 15 хувь, Нэгдсэн Хаан Улсад 13

---

40 *personal sphere*

41 *'utility'*

42 *protectionist taxes*

43 *Manchester School (бас Manchester Liberalism, Manchester Capitalism, Manchesterism гэнэ)*

хувь байжээ. Энэ нь одоо ДНБ-ий хувь хэмжээнд ойролцоогоор гурав дахин их болсон бөгөөд абсолют утг[44]аараа асар олон дахин их болжээ.

Үүний хажуугаар физикийн эрдэмтэд бодит дэлхийг өөрчилж байгаагийн адилаар эдийн засагч, социологич нар хүмүүний нийгмийг шинжлэх ухаанчаар хэлбэржүүлэх боломжтой гэж өөдрөгөөр бодож баясацгааж байлаа. Тэд нар гадаад хүчин зүйлсийнхээ адилаар зах зээл жам ёсны эмх цэгцгүй зүйл байдаг, мөн түүнийг монополь байдал үүсгэх эсвэл ажилгүйдэл бий болгох хандлагатай гэж үзсэнээсээ болж төвлөрсөн төлөвлөлтийг зах зээлээс илүү рационал буюу эрүүл зүйл гэж ойлгож байсан. Интервенционистууд[45] ямар ч дарамт ачаа байхгүй боллоо; харин одоо сонгодог либералчууд эрх чөлөөг давамгайлуулах хүчин чармайлтаа зөвтгөж үндэслэлтээ гэдгийг харуулах хэрэгтэй хүмүүс болцгоолоо.

## Сонгодог либерализм орчин цагт дахин амилсан нь

### *Бодлогын асуудал, түүнд өгөх сонгодог либерал хариулт*

Гэвч интервенционистуудын хөөрсөн итгэл найдвар талаар болов. Эдийн засаг ажилгүйдэл, инфляц буюу үнийн хөөрөгдөл (заримдаа өөрсдөд нь ч ойлгомжгүй зүйл байсан), бага өсөлт, засгийн газар үнэ тогтоосон эсвэл эрэлт нийлүүлэлтийг удирдаж залж байсан орон сууц, эрчим хүч, зээллэг, валютын арилжааны зах зээлийн хямралд автаж хүндрэв. Өсөж томорч буй халамжийн төр[46] хамааралтай байдлын зовлон, санаачилгын дутагдалд орж өвчлөв. Төр засгийн газрын хэмжээг бууруулах, бас татвар төлөгчдөд тулгаж байсан шаардлагаа ч хорогдуулахаас өөр арга зам тэдэнд үлдсэнгүй ээ.

Хэдий хамгаалах байр сууриндаа шилжсэн байсан ч гэсэн олон сонгодог либералчууд олны сүүдэрт иймэрхүү асуудлын талаар

*44 absolute terms*

*45 interventionists - Засгийн газар бизнесд хөндлөнгөөс оролцох явдлыг дэмждэг, тийм бодлого хэрэгжүүлдэг хүмүүсийг хэлнэ.*

*46 welfare state*

удаан хугацаанд бодож сэтгэж байжээ. Тэд хуучны сонгодог либерал зарчмаа эргэн харж, тэдгээрийг дахин бодож тунгаан, өөрчлөгдсөн цаг хугацаанд илүү сайн тохирсон шинэ эсвэл сайжруулсан гаргалгаа нотолгоо хөгжүүлцгээсэн байдаг. Эцэст нь сая нэг 1980-аад онд энэхүү оюун санааны хувьсгал Америкийн Нэгдсэн Улсад Роналд Рейган, Их Британид Маргарет Тэтчер зэрэг дэлхийн удирдагчдын бодлогын суурь мэдлэг мэдээлэл болох болно.

*Оюун санаа хөгжиж урагшлав*

Австрийн Сургуулийн эдийн засагчид Карл Менгер (1840–1921 он)-ээс авахуулаад, эдийн засгийн ухаан бол шинжлэх ухаан биш харин хувь хүний үнэ цэнэ, үйлдлийн хэрэг явдал юм гэдгийг ялгаж танив. Лүдвиг фон Мизэс (1881–1973 он), Ф. А. Хаек (1899–1992 он) нарын Австричууд төрийн хяналт эдийн засгийн дохиог сарниулж бусниулдаг, мөн таамаглах аргагүй үр дагаварт хүргэдэг гэдгийг олж мэдэв.

Энэ үеэр Чикагод Фрэнк Найт (1885–1972 он) мөн л эдийн засгийн ухаанд хувь хүнийг цөмд нь тавьж, нийгэм бол өөрийн гэсэн ухаан байхгүй харин хувь хүмүүсийн бөөгнөрөл байдаг гэж дахин дахин баталж байлаа. Милтон Фрийдмэн (1912–2006 он) хувь хүмүүс өөрийн гэсэн нийгэм эдийн засгийн амьдралаа босгох боломжтой тийм нөхцөл (мөнгөний тогтвортой байдал зэрэг)-ийг бүрдүүлэхээр л чанд хязгаарлагдсан засгийн газрын төлөө маргаж мэтгэлцэж байв. Роналд Коүз (1910–2013 он) бохирдол зэрэг бэрхшээлийг зах зээл шийдвэрлэх боломжтой бол харин засгийн газар хөндлөнгөөс оролцох явдал хэрэг явдлыг бүр муутгаж ч болно гэдгийг олж нээлээ.

Хаек 1947 онд дайны дараахь харанхуй үед сонгодог либерализмд тохиолдож буй зарим нэг гол сорилтын талаар мэтгэлцээн өрнүүлэх бага хуралд хэсэг эдийн засагч, түүхч, улстөрийн эрдэмтдийн бүлгийг цуглуулж хуралдуулжээ. Мон Пелерин Нийгэмлэг[47] гэж хожмоо алдаршсан энэ нийгэмлэг түүнээс хойш Нобелийн

*47 The Mont Pelerin Society*

шагналтнууд, бусад нөлөөтэй хүмүүс багтсан, хэдэн зуун гишүүнтэй болж томорсон. Энэ нийгэмлэг сонгодог либерал үзэл санаа, маргаан мэтгэлцээнд анхаарал хандуулсан хэвээр л байна.

Дайны дараа хөгжлийн өөр нэг жим гарсан нь Виржиниагийн Их Сургуулийн Жэймс М. Бачэнэн (1919–2013 он), Гордон Таллок (1922–2014 он) нараар алдартай болсон, Олон Нийтийн Сонголтын Сургууль[48] байлаа. Энэ сургуулийнхан ноёлж буй эдийн засагчид[49] *зах зээлийн бүтэлгүйдл*ийн талаар ярихдаа, мөн “олон нийтийн ашиг сонирхол”-ын төлөө “рационал” бодлого гаргаж зардал-өгөөжийн шинжилгээ[50]г хэрэглэхдээ тэд нар *засгийн газрын алдаан*ы талаар ярихаа мартсаныг нь харуулсан. Энэ байдал улстөрийн үйл явц төгс бус байгаагаас эсвэл энэ үйл явцад оролцдог хүмүүсийн өөрийн-тусыг бодох явдлаар өөрөө илэрч харагдаж болно.

Сонгууль жишээлбэл “олон нийтийн ашиг сонирхол”-ын шалгуур биш харин өрсөлдөж буй ашиг сонирхлын уралдаан юм; 50%+1 санал нь цөөнхийг мөлжиж ашиглах явдлыг хэт хялбар болгодог зүгээр л олонхийн дүрэм ажээ; улстөрчид заавал сонгогдохын тулд ашиг сонирхлын бүлгүүдийг сэтгэлийг тайтгаруулах ёстой байдаг бол харин лоббичид энэ байдлыг өөрсдөдөө ашиг гаргах гэж ашигладаг; бодлого хэрэгжүүлдэг албан тушаалтнууд ч гэсэн мөн өөрийн ашиг сонирхолтой байдаг. Үүнээс гарах дүгнэлт сонгодог либералчуудын аль хэдийнээ мэдэж буйчлан хувийн шийдвэр гаргах явц нь хувь хүний эрх чөлөөг хамгаалахын тулд чанд зайлшгүй хязгаарлах шаардлагатай улстөрийн шийдвэр гаргах явцаас ерөнхийдөө илүү сайн гэсэн дүгнэлт байх болно.

## Сонгодог либерал үзэл санааны олон салаалсан байдал

Сонгодог либералчуудын дунд төрийн үүрэг нөлөөний талаар нийгмийн сайн сайхан болон олон нийтийн ашиг тусыг бүрдүүлэхэд

48 *Public Choice School*

49 *mainstream economists-эдийн засгийн бодлого, мэтгэлцээнд давамгайлах байр суурьтай, ө.х. олонхи болсон эдийн засагчдыг хэлдэг.*

50 *cost–benefit analysis*

төрийг мэдэгдэхүйц оролцуулах явдл[51]ыг баталгаажуулахаас авахуулаад төрийг маш цомхон байхаар хязгаарлахыг хүсдэг илүү *либертарич* байр суурьтай байдаг янз бүрийн үзэл бий. Гэвч цомхон засгийн газартай байна гэдэг нь жижиг, дундаж нийгэм тэнд оршино гэсэн үг биш.

Америк философич Роберт Нозик (1938–2002 он) жишээлбэл зөвхөн хамгаалах л үүрэгтэй цомхон төрийн төлөө маргаж мэтгэлцэж байсан. Ийм төр дотор нь хүмүүс өөрийн бичил-Утопио байгуулж бүтээн хамтдаа хүмүүсийн хүрээллийг бүрдүүлж, хамтран ажиллаж, мөн сонгож авсан бүлгээсээ авсан үйлчилгээнийнхээ төлөөсөнд аль эрх чөлөөнөөсөө татгалзаж болохоо шийдэх боломжтой аюулгүй бүтцээр хангадаг ажээ. Либертарич сонгодог либералчуудын цөөн л үүнтэй санал нийлдэггүй; хэдий тийм ч тэд нар бүгд Нозикийн зөгнөсөн нийгмийн олон янз байдал, динамизм[52]ийг талархан дэмжих болно.

---

*51 provision of social welfare and public goods*

*52 diversity and dynamism*

# ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ: Сонгодог Либерализм, Эрх Чөлөө

## Эрх чөлөөг дэмждэг гаргалгаа нотолгоо

Төрийн үүрэг нөлөөний талаар сонгодог либералчуудын дунд үзэл санааны өргөн хүрээ буюу спектр бий. Гэлээ гээд бүгдээрээ хувь хүн, эдийн засаг, нийгмийн амьдрал дахь эрх чөлөөнд ач холбогдол өгдөг бөгөөд хүн бүрийн амьдрах эрх, эрх чөлөөт байдал, өмч, аз жаргалынхаа төлөө тэмүүлж зорих явдлыг хамгаалдаг. Гээд эдгээр зарчимд итгэх тэдний итгэл үнэмшилд нь өөр өөр учир шалтгаан бий.

### *Эрх чөлөө өөрөө сайн зүйл юм*

Олон хүн эрх чөлөөг сайн зүйл, түүнд хүрэхээр зорьж тэмүүлэх хэрэгтэй зүйл гэж харж ойлгодог. Боломцоо боломж олгоход ихэнхи хүмүүс бусдаар заалгуулж зааварчлуулалгүйгээр өөрийнхөө хүссэнээр амьдрахыг илүүд үзнэ. Тэд нар сонголтоо өөрөө хийх, бие даасан байдлыг хүсдэг. Энэ байдал хүмүүс эрх чөлөөг үнэлдэг гэдгийг харуулдаг; тиймээс эрх чөлөөг өргөжүүлж тэлэн, албадлагыг бууруулангаа бид хувь хүмүүсийн элбэг дэлбэг байдлыг хурдтай нэмэгдүүлж, үүнээс улбаалаад хүмүүсийн хүрээллийг цэцэглүүлэх ажээ.

### *Жам ёсны эрх*

Жон Локкоос авахуулаад Томас Жефферсон (1743–1826 он) зэрэг Америкийн үндэслэгчид хүртэлхи олон сонгодог либералчуудын дунд өнөөдөр ч байдаг хүчирхэг үндсэн санаа бол хувь хүн тодорхой жам ёсны эрх[1]тэй байдаг гэсэн бат итгэл юм. Бидний, хүмүүн төрөлтхөний салшгүй нэг хэсэг гэж тэдний үздэг эдгээр эрхээсээ бид татгалзах боломжгүй, эдгээр эрх оршин байх нь хуулиас эсвэл

*1 natural rights-орос. естественные права*

төр засгаас үл хамаардаг.

Жам ёсны эрх тэдний хэлэхээр хууль, уламжлал, шашин, итгэл үнэмшил, соёл эсвэл төр засгаас гардаггүй ч гэсэн хүмүүн төрөлхтөнд жам ёсоор оршиж байдаг ажээ. Эдгээр эрх бол бүх хүнд хүртээлтэй, тэднээс салшгүй зүйл юм – тэдгээр эрх хүмүүн төрөлхтөний нэг хэсэг учраас бид эдгээрийг зарах боломжгүй, бусдад өгөх, эсвэл тэднээс татгалзах ч бололцоогүй.

Хэдий Локк амьд явах буюу амьдрах суух, эрх чөлөөт байдал, өмчийн эрхийг жагсаахдаа олон хүний өмнөөс ярьсан ч гэлээ эдгээр суурь эрх юу болох талаар өөр өөр үзэл санаа бий: хүмүүс бусдын ижил тэнцүү эрхийг зөрчихгүйгээр амьдрах, хүссэнээ хийх, мөн хүчээр олж аваагүй өөрсдөө бүтээсэн эсвэл бэлэг авах эсвэл арилжаа хийж олж авсан бүх зүйлээ эдэлж хэрэглэх эрхтэй. Бидний амин чухал хэсэг болох тул эдгээр эрхийг бусдад өгөх боломжгүй. Бид өөрсдийн эрхээ зөрчихгүй, өөрсдийнхөө өгч чадахгүй ямар нэг зүйлээ бусдад өгөхийг оролдохгүй учраас өөрсдийгөө боолчлуулахаар гарын үсэг зурах ч боломжгүй. Бас эдгээр эрхийг бусдаас тогтоол шийдвэрээр авах эсвэл бусдад өгүүлэх ч боломжгүй.

Хүн бүрийн таашааж эдэлдэг жам ёсны эрхийн энэхүү үзэл санааг *хаадын бурхнаас авсан эр*х[2] гэх зүйлээр сорьж үзсэн; Америкэд шилжин суурьшигчид Британийн засгийн газраас тэдний суурь эрхийг дарж дарангуйлах гэсэн оролдлогыг түүний эсрэг тэмцлийнхээ үндэслэл болгож дурдацгаасан билээ.

Сэтгэлгээний энэхүү чиг шугам бүхнээс дээгүүр эрх чөлөөг тавьдаг. Бүх хүнд аливаа эрх байхын тулд эхлээд тэнд эрх чөлөөт байдал байх ёстой бөгөөд хэрэв бид чөлөөтэй үйл хийх боломжгүй бол бусад аливаа эрх (өөр хэн ч хорьж чадахгүй үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө[3])-ээ эдлэх боломжгүй. Эрх чөлөөт байдал бол бидэнд эрхээ эдлэх боломж олгодог үндсэн нөхцөл, мөн тэдгээр эрхийг хүндэтгэдэг хэрэг явдлын төлөв юм.

---

*2 divine right*

*3 our freedom of thought*

*Нийгмийн гэрээ*

Английн улстөрийн философич Томас Хоббэс (1588–1679 он) зэрлэг балмад байдал хязгааргүй байдаг "байгалийн төлөв"-д төсөөлж буй эрх, эрх чөлөө өчүүхэн үнэ цэнэтэй байх болно гэж батлан өгүүлсэн; эв найртай амьдрахын тулд бид өөрсдөд маань хязгаарлалт тавихыг хүлээн зөвшөөрч, *иргэний* шинэ *эрх*, үүрэг гаргах болно гэсэн байдаг. Хэдий Хоббэсийг сонгодог либерал гэж бултаараа үздэггүй ч Локк түүний нийгмийн гэрээний арга замыг чөлөөт, бие даасан хувь хүмүүсийн жам ёсны ертөнцөд хэн ч бусдыг захирах *ямар ч эрхгүй* байх болно гэж батлан өгүүлж дагав; гэвч хэрэв хүмүүс хүчирхийллийг хумих боломжтой иргэний засаг захиргаа байгуулахаар, мөн түүнийгээ хүндлэхээр санал нэгдсэн бол тэд нар шинэ бололцоо нээж, эрх чөлөөгөө тэлэх боломжтой. Бүр саяхан Америк философич Жон Роолс (1921–2002 он) үүнтэй адилхан хандлагаар шинэ нийгэм байгуулах боломж олгон, амьдралын тааварлашгүй байдлыг сануулбал хүмүүс гарах үр дүнгийн ялгаатай байдлыг хэрэв энэ ялгаатай байдал хамгийн муу боломжтой нэгэнд тустай байвал л зөвхөн хүлцэн тэвчдэг нийгмийн гэрээг л илүүд үзэх болно гэж батлан өгүүлж байв.

Нийгмийн гэрээний аль ч зохиогч чөлөөт, бие даасан хувь хүмүүс жинхэнээсээ ямар нэг хэлцлийн гэрээ[4]нд гарын үсэг зурсан тийм түүхийн мөч хэзээ нэгтээ байсан гэж санал хэлээгүй байдаг. Тэдний онол засгийн газрын үндэс суурь нь ямар рационал зарчим байх хэрэгтэй талаар тайлбарлах гэсэн цэвэр 'бодол санааны туршилт' юм.

Гэвч гарах үр дүн нь үргэлж өөрсдийнх нь үзэл санааг зөвтгөсөн мэт эдэнд харагддаг байжээ. Хоббсын нийгмийн гэрээ Английн Иргэний Дайнаар ганхаж суларсан зүйл болох, жишээлбэл хүчтэй эзэн хаант засаглал[5]ыг таашаадаг бол харин Францын хувьсгалт

4 *contractual agreement*
5 *monarchy*

сэтгэгч Жан Жак Рүссо (1712–78 он) үүнээс ялгаатай нь нийгмийн гэрээгээ *бүгд найрамдах засаглал*ын сайн чанар[6]т үндэслэсэн. Локкийн хувьд улстөрийн засаг захиргаа захирагдаж буй, үүнээс улбаалаад хэрэв тухайн “гэрээ” зөрчигдвөл *өөдөөс нь тэмцэх эрх*тэй хүмүүс зөвхөн зөвшөөрснөөр гарч ирдэг – энэ нь II Жэймсийг хаан ширээнээс буулгах үндэслэл болжээ. Роолсын тогтолцоо тэр үедээ улстөрийн илүү *эгалитарич* үзэл санааг харуулж байсан.

Америкийн босогчдын сэтгэл зүрх Локкийн гэрээний онолоор хөглөгдсөн байсан бөгөөд Америкийн Эрхийн тухай Билл нь жам ёсны эрхийн үзэл санаанд ихээр тулгуурласан байдаг. Гэвч нийгмийн гэрээний онол заавал жам ёсны эрх оршиж буй явдалд үндэслэдэггүй: Хоббэсын онол жишээлбэл зөрчилдөөнийг бууруулахад зөвхөн таатай зүйл байсан.

Нийгмийн гэрээний онолоор засаглалын *рационал үндс*ийг л ялгаж танихыг оролддог. Гэвч бодит байдал дээр амьдрал тийм ч сайхан байдаггүй. Нийгмийн амьтад ч гэлээ бид сайн нийгмийг юу бүрдүүлэх боломжтой талаар хоорондоо зөрчилтэй үзэл санаатай байдаг, мөн ямар ч “рационал гэрээ” байх боломжгүй мэт санагддаг. Хэн нэгэн хүн төсөөлсөн “рационал” нийгмээ бий болгохоор оролдох үед үр дүн нь үргэлж сүйрэл байдаг билээ. Рүссогийн загвар төлөвлөгөөнд үндэслэсэн Францын Хувьсгал Европд иймэрхүү сэтгэлгээнээс олон нийтэд учрах боломжтой аллага хядлага ямар байж болохыг харуулав.

### *Түүхэн замнал, хөгжил дэвшил*

Милл болон орчин үеийн улстөрийн Америк эрдэмтэн Фрэнсис Фүкүяма (1952 онд төрсөн) зэрэг хэдхэн сонгодог либералчууд эрх чөлөөг эдийн засгийн хөгжил дэвшлийн алхааны[7] нэг хэсэг гэж үздэг - эрх чөлөөний эдийн засгийн үр өгөөж (хувь хүмүүс шинэ бүтээл гаргах, сонгож авснаараа хөдөлмөр эрхлэх, хөрөнгө бүтээж цогцлоох, эд баялаг бүтээх боломж олгодог) болон иргэний

6 *republican virtues*

7 *march of progress-*

үр өгөөж (шүүх, аюулгүй байдал, төлөөллийн засгийн газар) маш илэрхий байдаг учраас хүн төрөлхтөний улам бүр олон хүн түүнийг хүлээн зөвшөөрөх болно. Иймэрхүү зүйл гарч болох юм; гэвч бид бас үүний эсрэг хүчтэй ерөнхий хандлага байдаг гэдгийг дурдаж хэлэх ёстой.

*Олон нийтийн сайн сайхан*

Бусад сонгодог либералчууд, үүн дотроо Шотландын Гэгээрлийн эриний сэтгэгч Адам Смит, Дэвид Юм (1711–76 он) нар эрх чөлөөнөөс гардаг үр дагаврын ашиг тусыг нийт олноороо хүртдэг гэж илэрхийлсээр байсан. Эрх чөлөө тэдний батлан өгүүлснээр хувь хүнд байдаг сонгох боломжийг асар ихээр тэлдэг бөгөөд хувь хүмүүс зорилго, түүндээ хүрэхэд ашиглах арга хэрэгслийн талаар үндэслэлээ гаргахдаа хол хөндий байгаа ямар ч засаг захиргаанаас хамаагүй илүү сайн байдаг ажээ. Тиймээс сонголт нь хувь хүмүүсийн элбэг дэлбэг байдл[8]ыг ихэсгэдэг, үүнээс улбаалаад мөн хүмүүсийн хүрээллийн элбэг дэлбэг байдлыг бүхэлд нь хурдтай нэмэгдүүлнэ.

Түрүү үеийн энэ сонгодог либералчууд хувь хүний эрх чөлөө, олон нийтийн сайн сайхны дундаас зөрчил олж хараагүй бөгөөд Смит нэг нь нөгөөгөө бий болгодог гэдгийг харуулсан. Гэвч тэд нар тэдгээрийн хоорондох харилцан хамаарал нийлмэл, нарийн, төгс бус байсан гэдгийг л мэдэж байлаа. Бид зөвхөн *ойр дотныхноо хайрлах зарчим*д найдах боломжгүй: хүмүүсийг өөрийн-тусыг бодох гэсэн хамаагүй илүү хүчирхэг сэтгэл[9]ийг нь үр бүтээлтэйгээр чиглүүлэх хэрэгтэй. Тиймээс аюул хохирлоос сэргийлэх, эв зохицлыг тэтгэж хамгаалахад ёс зүй, уламжлал болон заншлын ёс журам, мөн дээр нь хууль болон шүүхийн тогтолцооны багахан албадлагаас гардаг зааварчилгаа шаардлагатай ажээ.

Энэ сэтгэгчдийн хувьд өөр зүйл биш харин эрх чөлөө л олон нийтийн тав тухыг бүрдүүлж бий болгодог зүйл байсан. Бентам[10] үүнээс ялгаатай нь хуулийн албадлагаар түшиг болгоогүй эрх ямар

8 *welfare of individuals*

9 *sentiment*

10 *Bentham, Жереми Бентам (1746-1832 он)*

ч утгагүй зүйл гэж батлан өгүүлжээ: түүний хувьд жам ёсны эрх ‘утга учиргүй зүйл’ байсан, жам ёсны салшгүй эрх ч ‘чалчаа яриа[11]’ байв. Үүнтэй адилаар Америк хуульч бага Оливер Венделл Холмс (1841–1935 он) үл хэлэх эрх чөлөө[12] зэрэг эрхийг засгийн газар бий болгосон бөгөөд нийт нийгэмд тустай учраас л үүнийг зөвхөн зөвшөөрдөг гэж батлан өгүүлсэн нь бий.

Сонгодог либералчуудын олон нь бодол санааны энэ чиг шугамаас бушуу түргэн зайлж холддог. Энэ нь төр засаг бидний эрхийг хүссэнээрээ шийдэх боломжтой; бидний удирдагчид биднээс давсан онцгой эрхтэй, дурдаж нэрлэвэл бид ямар эрхтэй байхыг шийдэх эрхтэй; олонхи зөвшөөрч сонгож авснаас өөр ямар ч эрх байхгүй гэдгийг харуулдаг ажээ. Сонгодог либералчууд энэ явдал цөөнхийг ямар ч хамгаалалтгүй үлдээдэг гэж үздэг.

### *Хувь хүний өвөрмөц байдлыг илэрхийлэх*

Милл, Смит, Юм нар эрх чөлөө хүмүүст өвөрмөц чанараа, ондоо байдл[13]аа илэрхийлэх боломж олгодог гэж цааш нь үзэл санааг нарийвчилжээ. Энэ нь л хүмүүсийн хүрээлэлд бүхэлд нь үр өгөөжтэй байж, нарийн мэргэжих, бололцоо боломжийн үүдийг нээнэ. Гэвч бүр илүү чухал зүйл бол ёс суртахууны хэмжүүр юм. Хэрэв хэн нэгэн хүн тэдний бүх үйлдлийг чиглүүлж байвал хүмүүс бүрэн бүтэн хүмүүн төрөлтөн байх боломжгүй, бас эргэцүүлэл бодрол, хүмүүний сэтгэл эсвэл ёс суртахууны хариуцлага ч байх боломжгүй.

### *Аргазүйн индивидуализм[14]*

Бидний харсанчлан сонгодог либералчууд хамт олонд хувь хүний амьдралаас давсан амьдрал гэж байдаггүй учраас хувь хүнийг хамт олноос илүү чухалчилж хардаг. Хүмүүн төрөлхтөн нийгмийн амьтан байж болох ч тэд нар *хувь хүн байдлаар бодож сэтгэн, үйл хийнэ.*

---

11 *nonsense upon stilts*
12 *free speech*
13 *personality and diversity*
14 *Methodological individualism*

Хүмүүс ‘олон нийтийн ашиг сонирхол’-ын талаар ярьдаг ч бодит байдал дээр нэг хүний ашиг сонирхлыг бусад хүмүүсийн ашиг сонирхлоор наймаалцах боломжтой математикийн томьёо байдаггүй. Бид хэн нэгэнд учруулж буй аюул хохирол (жишээлбэл сэтгэл санаагаар унагаах, уурлуулах, эсвэл уй гашууд автуулах), бидний хэн нэгэн бусдад өгч буй ашиг тус (баяр хөөр эсвэл аз жаргал) бол хүмүүний хэмжих боломжгүй сэтгэл хөдлөл юм. Тиймээс бид хувь хүний эрх чөлөөг бүлэг хүмүүсийн төсөөлсөн боловч хэмжих боломжгүй ашиг тусын төлөө золиослох явдлыг зөвтгөх боломжгүй.

Нийгмийн бодгаль болох бидний амьдрал бидний үзэл санаа, үнэт зүйлсийг хэлбэржүүлдэг нь үнэн билээ. Биднийг ойр тойрныхоо хүмүүст, ялангуяа дотно хүмүүстээ туслах, тэднийг тайтгаруулахад түлхэлж байдаг, нийгмийн холбоос, зөн совин бидэнд бий. Бид бүгдэд ерөнхийдөө ашиг тустай байдаг, нийгмийн институц, уламжлал, зуршил, ёс суртахууны ёс журмыг эдгээр нь бусад хүмүүс хэрхэн ямар зан араншин гаргаж болохыг бага сага нарийвчлалтайгаар урьдаас таамаглах боломж олгодог, энэ нь илүү сайн төлөвлөгөө, шийдвэр гаргах бололцоотой болгодог учраас л хүлээн зөвшөөрч өөриймшүүлдэг. Гэвч эдгээр институц болон зүй тогтол салангид үйлдлүүдийн зориогүй үр дагавар байдаг; бид ухамсартайгаар хувь хүмүүсийн үйлдлийг чиглүүлэх боломжтой бас үүнээс нийгмийн илүү сайн ерөнхий үр дагавар гарах боломжтой гэж төсөөлөх нь хэт өөртөө итгэсэн хэрэг билээ.

## Позитив, негавит эрх чөлөөт байдал

Сонгодог либерал эрх чөлөө бол үндсэндээ *негатив шинжтэй буюу хөндлөнгөөс үл заасан байдал*[15]тай байдаг. Энэ нь эрх чөлөөг ялангуяа бусад хувь хүн эсвэл *бусад хүмүүс* эсвэл тэдний байгуулдаг, засгийн газар зэрэг *институц*ийн заналхийлэл, албадлагаар хязгаарлах боломжгүй гэсэн үг юм. Энэ нь эрх чөлөөг Британийн философич Исайя Берлин (1909– 97 он) илэрхийлсэнчлэн агаарт бид арван метр үсрэх чадалгүй гэх мэт *бодит хязгаарлалт* биш гэсэн

*15 negative-юу хийхийг нь үл заах байдал*

үг ажээ.

Гэвч зарим сэтгэгч эрх чөлөөнд хандах *позитив шинжтэй* буюу *хөндлөнгөөс заах байдал*[16]тай хандлагыг өмгөөлж хамгаалдаг. Жинхэнээсээ чөлөөтэй байхын тулд тэдний батлан хэлэхээр бид заавал эрх чөлөөгөө эдлэх эрх мэдэл, нөөц баялагтай байх ёстой ажээ. Хэрэв та нар Роллс Ройс авч чадахааргүй хэт ядуу бол та хэд үүнээс нэгийг авч өмчлөхөөр "чөлөөтэй" байх нь юу л бол гэнэ. Бүр илүү шулуухан хэлэхдээ хэрэв та нарын зарим нэг зарим нэг хамааралд автсан бол та нар чөлөөтэй биш: чөлөөтэй байхын тулд таны үйлдэл чинь зөвхөн өөрийнх чинь байхаар зогсохгүй заавал сайтар бодсон, үндэслэлтэй байх ёстой гэдэг.

Мэдээжээр бид бүгдээрээ үйл хийх эрх чөлөөнийхөө хүмүүний болон бодит хязгаарлалт[17]ыг *хоёулыг* нь бууруулахыг хүсдэг. Энэ бол яагаад бид артрит өвчнийг дарах гэж эм зохион гаргаж, нисэхийн тулд онгоц зохион бүтээсэн тэр л зүйл ажээ. Гэвч сонгодог либералчууд *позитив эрх чөлөө* буюу *хөндлөнгөөс заасан байдалтай эрх чөлөөний* үзэл санаанд сэжиглэнгүй итгэлгүй ханддаг. Хаекийн тайлбарласанчлан эхнээсээ л *эрх чөлөө*г *эрх мэдэл*тэй хольж хутгасан байжээ. Та нар мэдээжээр Роллс-Ройс өмчлөх нь чөлөөтэй, энд ямар ч бие хүн эсвэл хууль та нарыг зогсоохгүй ч гэсэн харин та нарт ингэх худалдан авах чадвар байхгүй байж болно. Та нар агаарт арван фүт [гурван метр] үсрэх тань чөлөөтэй, хэн ч та нарыг зогсоохоор оролдохгүй ч гэсэн харин та нарт түүнд хүрч үсрэх булчин шөрмөсний хангалттай *хүч чадал*гүй байж болно.

Мөн сонгодог либералчууд позитив эрх чөлөөт байдлын хандлага хүмүүний хүчирхэг эрхмүүд[18]ийн рационал байдал болон обьектив зан[19]д хэт их найдвар тавьдаг гэж санаа зовцгоодог. Хэт олон удаа зарим төр засаг эсвэл язгууртан бүлэг хүмүүс хар тамхинд ухаан нь балартсан хүмүүс адилаар бид "жинхэнээсээ" юу бидний хамгийн сайн ашиг сонирхолд нийцэж байгааг харж

---

*16 positive-орос. позитив- юу хийхийг нь заах байдал*

*17 human and physical limitations*

*18 human authorities*

*19 rationality and objectivity*

чадахгүй, тиймээс тэд бидний өмнөөс шийдэх ёстой гэж тулгадаг. Энэ явдал бол хол хөндий засаг албан тушаалтнаас өөрсдийнхөө ашиг сонирхлыг хамаагүй илүү сайн ихэвчлэн ухаарч мэддэг олон нийтийг ивээлдээ авч буй явдал юм; мөн аймшигтай зүйл гэдгийг хөдөлшгүй баталсан, нийгмийн бүх төрлийн инженерчлэлийн төслийг үндэслэлтэй болгож зөвтгөх гэж түүнийг ашиглаж иржээ.

## Эрх, эрх чөлөө

*Эрх* болон *эрх чөлөө*ний хоорондохь ялгаа тун үл ялиг бөгөөд магадгүй тэдгээрийг эсрэг талаас нь харвал хамгийн сайн харагдаж болох юм. *Эрх чөлөө*ний эсрэг зүйл бол *боолчлол*, бусдаар мэдүүлсэн байдал билээ. *Эрх*ийн эсрэг зүйл нь *үүрэг* – энэ бол бусдын өмнө *үүрэгтэй байх* эсвэл бусдад тавих шаардлага юм. Үүнээс болоод бид хэн ч та нарыг өөрийнхөө төлөө бодож сэтгэхийг хориглож чадахгүй, мөн та нарын чөлөөтэй бодож сэтгэх тань өөр бусдад ямар ч үүрэг хүлээлгэхгүй учраас *оюун санааны эрх чөлөө*[20]ний талаар ярьдаг. Гэвч таны биетээр орших байдал тань бусад хүмүүст үүнийг тань хүндлэх, гэмтээхгүй байх эсвэл алж үгүй хийхгүй байх хуульзүй эсвэл ёс суртахууны үүрэг оногдуулдаг учраас бид *амьдрах эрх*ийн талаар ярьдаг. Үүнтэй адилаар та нар бусадтай эв найртайгаар арилжаа хийх замаар өмчтэй болох тань чөлөөтэй бөгөөд та бүхэн энэхүү өмчөө бусад хүмүүс хулгайлж авах явдалгүйгээр өөртөө эзэмшиж, эдэлж хэрэглэх эрхтэй билээ.

Сонгодог либералчууд эрх төр засгаас ч өмнө оршдог байсан гэж бодох дуртай – төр засгийн гаргасан хууль эрхийг бэхжүүлэх, хадгалж үлдэхэд тус болж болох ч ямар ч төр засаг олонхиороо эдгээр эрхийг үгүйсгэх үл тоомсорлох ёсгүй. Миллийн хэлсэнчлэн бүр хэрэв хэн нэгэн бидэнтэй санал нийлэхгүй байсан ч гэсэн бид чөлөөтэй ярих хэлэх эрхтэй байх ёстой: эрх бол зүгээр л тоонд захирагддаг зүйл биш.

---

20 *freedom of conscience-орос. свобода совести-Бие даан өөрийгөө идэвхжүүлэх итгэл үнэмшил, үнэт зүйлстэй болох жам ёсны эрхийг хэлнэ-НҮБ-ын Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглалын 18-р заалтад байх энэ эрх чөлөөг Монголоор орчуулалгүй үлдээсэн байх юм.*

Гэвч эдгээр эрх чухам юу байх ёстой талаар тодорхой яг таг тодорхойлоход хэцүү байдаг. Сонгодог либералчууд өмчийн эрхийн галзуу хамгаалагчид билээ; гэвч Америк эдийн засагч Милтон Фрийдмэн (1912–2006 он)-ээс жишээ авбал та өмчилдөг хэсэг газрынхаа дээгүүр онгоц нисэхээс сэргийлж чадах уу? (Эсвэл өнөөдөр бид фракинг хийдэг[21] компани тэр газрын тань хамаагүй доогуур өрөмдөж буйд ингэж хэлж чадах уу?). Эдгээр эрхийг олон нийтийн хэлэлцүүлгээр нарийвчилж, шүүхээр тогтоож гаргах явдал чухал байна.

Зарим эрх бусдаасаа илэрхий давуу байдаг. Милл тайлбарласанчлан нударгаа савлах таны эрх миний хамарт ирээд дуусдаг; харин таны чөлөөтэй ярих эрх[22] бусад хүмүүсийн аюулгүй байдлыг аюулд оруулан хүн ихтэй театрт "Гал гарлаа" гэж орилох хүртлээ хүртэл даамжрах ёсгүй. Гэвч дахиад л Хаекийн асуусанчлан цөлд худаг өмчилж буй таны өмчлөх эрх цангаж үхэж буй хүнд ус өгөхөөс татгалзана гэсэн үг үү – эсвэл ингэх нь тэдний амьдрах эрхийг зөрчсөн болох уу?: Энэ нь үзэл бодлын хэрэг гэж харагддаг: гэвч сонгодог либералчууд бидний "эрх"-ийг олонхиор шийдвэрлэх явдалд асар их аюул бий гэж хардаг.

## Эрх чөлөөнд тавих хязгаарлалт

Сонгодог либералчуудын хувьд гол асуудал тийм учраас хүмүүсийн үйл хийх эрх чөлөөг хумих явдлыг юунд үндэслэдэг талаархи зүйл байдаг – цаашилбал хэн хэрхэн үүнийг шийддэг тухай асуудал болдог ажээ.

Хэрэв бид хүмүүсийн ашиг сонирхлыг хэмжих, бас нэмэх боломжтой, мөн хамгийн их үнэ цэнийг юу бий болгож байгаа явдалд үндэслэж шийдвэрээ гаргадаг байсан сан бол энэ нь маш амархан байх байв. Гэвч хүмүүний үнэ цэнэ хувийн шинжтэй, эсвэл *субьектив шинжтэй* байдаг бөгөөд энэ байдлаар нь нийлбэрийг нь гаргах боломжгүй. Бид засгийн газар буюу төр засагт албадлагын

21 *газар доорхи хурдасыг шингэн шахаж даралтаар нь хагалж сийрэгжүүлэхийг хэлнэ.*

22 *right of free speech*

монополь эрхийг яг л ийм шийдвэр гаргуулах, түүнийг албадан хэрэгжүүлүүлэх гэж өгдөг. Гэвч бид энэ үйл явцыг тэд нар ч гэсэн гаргах шийдвэрт нь гарцаагүй нөлөөлөх өөрийн гэсэн субьектив ашиг сонирхол байдаг учраас төрийн албан хаагчдад энэ үйлийг аюулгүй гэж бүхэлд нь өгөх ёсгүй.

Энэ талаар сонгодог либералчуудын санал нийлдэг зүйл бол нотолж батлах үүрэг нь энд хөндлөнгөөс оролцохыг хүсэж хүмүүст оногдох ёстой гэсэн санаа юм. Тодорхой ойлгомжтойгоор, рационал байдлаар үндэслэлийг нь гаргаагүй л бол хүмүүсийн эрх чөлөөг хязгаарлахад хүч хэрэглэх ёсгүй. Үгүй бол бид хүмүүсийг өөрийн амьдралаараа амьдар гэж орхих ёстой. Тэд нар алддаг байж болох ч гэвч бүр ингэх нь хол хөндий, буруу-ухаарсан, өөрийн-тусыг бодсон, дүр эсгэсэн улстөрчдийн гарт бидний эрх, эрх чөлөөг өгснөөс л хамаагүй дээр зүйл юм.

# ТАВДУГААР БҮЛЭГ:
# Сонгодог Либерал Ёс Суртахуунт Байдал

## Албадлага, Хүлцэхүй

Сонгодог либералчууд албадлага ерөнхийдөө хүсүүшгүй зүйл гэдэгт санал нийлдэг нэгддэг. Хүмүүс хүсэл зоригоо бусдадаа түрэмгийлэл, заналхийлэл, айлгах эсвэл хүчирхийллээр дамжуулан тулгахыг зөвшөөрөх нь сайн нийгмийг авчрахгүй. Хүчийг бусад хувь хүн эсвэл засгийн газар хүч хэрэглэж буй эсэхээс үл хамаарч хэрэв бид үүнээс зайлсхийх боломжтой бол бид тэгэх л хэрэгтэй.

Гэвч чөлөөт хүмүүсийн дунд үргэлж зөрчил гарах болно. Тэд нар өмчлөлийн хэрэг явдлын талаар санал нийлэхгүй байж болох бөгөөд нэг хүний үйлдэл нөгөө нэгнийг хохироож болно. Тиймээс л эв найрыг сахин хамгаалах болон хүчирхийллийг хумьж багасгах гэсэн ашиг сонирхлын үүднээс бидэнд иймэрхүү маргааныг шийддэг, түрэмгийллийг зогсоодог, хүнээс үл хамаардаг[1] шүүхийн тогтолцоо хэрэгтэй. Гэвч бид эдгээр үндэслэл, ёс журм[2]ыг хүн бүр сайн дураараа хүндэлнэ гэдэгт найдах боломжгүй: эв найрыг хадгалж хамгаалахын тулд бидэнд сонгодог либералчууд маш их дургүй байдаг зарим нэг албадлага зайлшгүй хэрэгтэй болдог.

Сонгодог либералчууд энэхүү хэцүү сонголт буюу дилеммаг төрд хүч хэрэглэх монополь эрх өгөх замаар шийдвэрлэдэг – төр бол тэд нар өөрсдөдөө үлдээхээсээ эмээдэг ч хүч хэрэглэхдээ жирийн хүмүүсийг бодвол илүү бие даасан байдалтай байх болно гэж найддаг тийм институц юм.

### *Аюул хохирол, үл санал нийлэх явдал*

Тиймээс л шүүхэд хүч шаардлагатай ажээ; гэвч хүч хэрэглэхэд үндэслэл хэрэгтэй. Сонгодог либералчуудад институцийн энэхүү

1 *impartial*
2 *judgements and rules*

хүчийг зөв хэрэглэх явдал маш онцгой зүйл байдаг: энэ бол хүмүүсийг бусдыгаа хохироох гэмтээх эсвэл заналхийлэхээс сэргийлэх, ерөнхийдөө хүчирхийлэл болон албадлага хэрэглэх явдлыг бууруулах явдал юм. Гэвч энэ сэргийлэх гэсэн зүйл нь *бодит аюул*, эсвэл бусдад аюул учруулсан *бодит аюулын заналхийлэл* байх учиртай. Сонгодог либералчууд зүгээр л бидэнд тэд эсвэл үйлдэл нь таалагдахгүй байгаа учраас хувь хүмүүсийн эсрэг албадлага хэрэглэх ёсгүй гэдгийг эрс шийдэмгий дэмждэг.

Бид бусад хүмүүсийн шашныг үзэн ядаж, улстөрийн үзэл санааг нь үгүйсгэж, амьдралын хэвмаягт нь зэвүүцэж, зан араншнийг нь үл таашааж, дадал зуршлыг нь нүд үзүүрлэж болно. Бид тэдний санаа, үзэл бодлыг нь сонсоод цочирдож ч болно. Бид бүр тэд эрүүл мэндээ хар тамхиар гэмтээж байна, эсвэл өөрийн хөгжил дэвшлээ нийгмийн эсрэг зан авираараа сүйтгэж байна гэж санаа зовж ч болно. Гэвч эдгээрийн аль нь ч тэднийг үүнээс өөрөө үйл хийлгэхээр хүч хэрэглэхээр оролдох явдлын хүчин төгөлдөр учир шалтгаан болдоггүй. Сонгодог либералчууд хүмүүсийн итгэл үнэмшил, зан төлөв, амьдралын маяг эсвэл ёс суртахууны сонголт төрийн эрс шийдэмгий албадлагын эрх мэдэл ашиглаж хориглохуйц зүйл биш гэж хэлдэг. Бид нар тэдэнд, жишээлбэл хар тамхи хэрэглэх зуршлаа хаяхад нь туслахаар оролдох нь чөлөөтэй боловч хэрэв тэдний үйлдэлд өөрсдөөс нь өөр хэн ч хохирогч биш байвал бид хүч хэрэглэх явдлаа зөвтгөх үндэслэлтэй болгох ямар ч арга байхгүй.

Гэвч сонгодог либералчууд хүмүүс “утга учиртай” эсвэл “зөв” сонголт хийхийн тулд заавал “боловсрол эзэмшсэн” байх ёстой гэсэн гаргалгаа нотолгоонд сэтгэл дундуур байдаг. Мэдээжийн хэрэг хар тамхи хэрэглэхэд гарч болох эрсдэл эсвэл хүнсний илчлэгийн хэмжээ гэх зэрэг илүү сайн мэдээлэлтэй байдаг хүмүүс илүү сайн-үндэслэлтэй сонголт хийдэг. Гэвч сонгодог либералчууд ихэнхи хүмүүс хамгийн интервенционистч таамаглалаас ч илүү сайн мэдээлжсэн байдаг гэдгийг баримтална. Тэд нар мэдээжээр тодорхой байдлаар өөрийнхөө зорилго, бололцоо, хувийн нөхцөл байдлынхаа талаар аливаа нэг улсчтөрчийн мэдэж чадахаас хамаагүй илүү сайн мэдээлэлтэй байдаг. Гэвч тэдний мэдэж буй

их мэдээлэл нь обьектив байдлаар “зөв” эсвэл “буруу” байдаг ямар нэг зүйл биш бөгөөд харин тэдний цор ганц сонголт нь хувийн үнэлэмжийн л хэрэг явдал хэвээр үлддэг. Сонгодог либералчууд бусад хүмүүсийн сонголтод өөрсдийнхөө үнэт зүйлийг тулгах замаар хөгжүүлж буй интервенционистуудын ‘боловсрол’-ын гаргалгаа нотолгоонд хэт их санаа зовцгоодог.

## Хүлцэхүйг Дэмждэг Гаргалгаа Нотолгоо

Сонгодог либералчуудад хүлцэхүйн талаар иймэрхүү зүйл илэрхийлсэнд ёс суртахуун болон оновчтой байдлын олон шалтгаан бий.

### *Төлөөс, хохирол*

Юуны түрүүнд гүн бат суусан итгэл үнэмшил болон дадал зуршлыг нь өөрчлүүлэхээр хүмүүсийг ятгахаар оролдох нь маш их төлөөстэй. Энэ төлөөс арми босгох, хамгаалалт барих асар их зардал, Дундаж Зууны шашны загалмайтны аян дайны үеэр тэдэнд зориулж татвар төлөх зэрэг *санхүүгийн* зүйл ч байж болно. Эсвэл энэ нь Ромын засаг захиргаанаас эхэн үеийн Загалмайтны шашинтнуудыг ялгаварлан гадуурхсан, Шинэчлэлийн эриний үеэр Протестант шашинтнуудыг мөшгөж залхаан цээрлүүлсэн, 1990-ээд онд Сербийн Загалмайтны шашинтнууд лалынхныгаа алсан зэрэг *хүмүүний золиос* ч байх боломжтой.

Франц философич Монтескю (1689–1755 он) цохон заасанчлан хэрэв шашны итгэл үнэмшил улстөрийн хэрэг явдал биш байсан сан бол эв найртай байх хамаагүй илүү их боломж байх байсан. Мэдээжээр улстөрийн ялгаатай байдлаас болж хүн төрөлхтөн маш их золиос төлцгөөв. Дөнгөж зуухан жилийн хугацаанд л бид хоёр Дэлхийн Дайны аллага, Сталины Зөвлөлт Холбоот улсад явуулсан харгислал, Маогийн соёлын хувьсгал, Улаан Кхмерчүүд өрсөлдөгчдөө үй олноор хядсан гээд, мөн олон өөр зүйлийг харцгаалаа.

Ийм золиос төлж ямар нэг зүйл олж авсан билүү? Хэдий

хүмүүсийг баттай айлгаж аюул өртүүлэх боломжтой байсан ч тэдний гүн бат итгэл үнэмшлийг өөрчлөх бараг боломжгүй хэвээр л байна. Ийм зүйл болсон гэдгийг бид хэрхэн мэдэх бил ээ? Английн I Элизабет (1533–1603 он) хэлсэн үгээр хэлбэл бид 'хүмүүсийн сэтгэлд нүх гаргаж' чадахгүй. Бас Жефферсоны хэлснээр шашны ялгаатай байдлаас ямар ч аюул учрахгүй тул бид оролдож өөрсдийгөө зовоох ёсгүй: 'Засгийн газрын хуульзүйн дагуухь эрх мэдл[3]ийг иймэрхүү үйл нь бусдыг гэмтээхүйц байвал л зөвхөн тийм үйлд хэрэглэж болно. Гэвч манай хөршид хорин бурхан байдаг эсвэл бурхан байдаггүй гэж хэлэх нь намайг хохироож гэмтээхгүй. Энэ мөн л миний халаасыг хоослох ч үгүй бас миний хөлийг ч хугалахгүй.'

### *Олон янзын ашиг сонирхол*

Хүлцэхүйг дэмждэг сонгодог либерал хоёрдохь гаргалгаа нотолгоо бол бид юу хүлээн зөвшөөрөхүйц, хүлээн зөвшөөрөхүйц биш, юу хүлцэхүйц эсвэл хүлцэхүйц биш талаар зүгээр л *санал нэгдэж чадахгүй* байж хүмүүсийн итгэл үнэмшил, амьдралын маяг эсвэл ёс суртахууныг хүчээр өөрчлөх явдлыг зөвтгөх боломжгүй байдаг явдал юм. Кантын батлан өгүүлсэнчлэн хүмүүс юу хүлцэхүйц болох талаар маш их санал зөрөлдөхөд үнэндээ бусдад *тулгах* гэж оролдохоосоо илүүтэй тэдэнд өөрийн үзэл бодлоо *үндэслэлтэй болохыг нь харуулах* гэж бид жинхэнээсээ оролдох хэрэгтэй.

Бүр саяхан Исайя Берлин хувь хүн бүр аюулгүй байдал, бие даасан байдал, гэр бүл, эд баялаг, тайван байдал зэрэг олон өөр үнэт зүйлтэй байдаг бөгөөд тэд бас тэдгээрээ ондоо ондоогоор эрэмбэлдгийг тайлбарласан. Тиймээс амьдрах өөр арга зам сонгож авах нь тэдний хувь төгс рационал буюу ухаалаг зүйл байж болно. Өөр өөр хүмүүсийн үнэт зүйл илүү үнэ цэнэтэй эсвэл бага үнэ цэнэтэй эсэхийг эсвэл тэдгээрийг эрэмбэлсэн байдал илүү сайн эсвэл муу гэдгийг шийдвэрлэх ямар ч обьектив арга зам байдаггүй. Энэ нь зүгээр л эд баялаг тайван байдлаас илүү хүсүүштэй, эсвэл гэр

3 *legitimate powers of government*

бүл аюулгүй байдлаас илүү чухал болох талаархи үзэл бодлын хэрэг явдал байдаг. Хүмүүний зорилго маш олон янз байдаг ертөнцөд хэн ч хүн бүрд зөв байх тийм сонголт хийх боломжгүй.

Тиймээс л өөрсдийн үзэл санаагаа бусдад тулгахаар оролдохын оронд сонгодог либералчууд биднийг бусад хүмүүс бол тооцож үзсэн сонголт хийдэг, тэр сонголт нь бидний хүндлэлийг ижил тэнцүү хүлээхүйц байдаг бодгаль юм гэдгийг хүлээн зөвшөөрөх ёстой гэж хэлдэг. Бид үргэлж тэдэнд дуртай байхгүй ч байж болох гэсэн бид тэднийг хүндлэх хэрэгтэй бөгөөд тэд нар эргээд үүний оронд бидний хийсэн сонголтыг хүндлэх ёстой.

### *Олон янз байдлын ашиг тус*

Жон Стюарт Милл бусдын хэрэгт хөндлөнгөөс оролцох явдлын цор ганц үндэслэл бол аюулаас сэргийлэх, эсвэл аюулд оруулахаар заналхийлэхийг нь хорих явдал гэж батлан өгүүлсэн байдаг; гэвч үзэл бодлын ялгаа хүлцэн тэвчдэг хүмүүсийг хохироодоггүй. Үнэндээ Милл бид яагаад үзэл бодлын иймэрхүү ялгаатай байдлыг түүнийг үзэл сананы шүүлтүүрээр харахыг оролдолгүйгээр үнэнээсээ таашаадгийн олон зэрэг шалтгаан бий гэж үзсэн. Хувь хүний чанар[4], шинэлэг байдал[5], шинэ санаа, олон янзын санаа бол хүмүүн хөгжиж дэвжих хувьсал хөгжлийн шатахуун юм гэж тэр боджээ.

Бүр хэрэв хэн нэгэн хүн бусад ихэнхи хүмүүсийн нүдэнд илэрхий буруу үзэл бодол илэрхийлдэг ч байсан энэ нь мөн л бидэнд тустай байсаар байх боломжтой. Сайтар эргэцүүлэхэд зөв болж эргэх боломжтой эсвэл олон нийтийн ойлголт ухаарцыг урагшлуулахад тус болох үнэн болон сэцэн ухааны зарим элементийг энэ нь агуулж байх боломжтой билээ. Бүр хэрэв алсын хараа нь бүхэлдээ худал байсан ч давамгайлж буй үзэл бодолд хэрэв үүнийг баталгаатай зүйл гэж хүлээн авбал хоосон ягшмал хатуу үзэл болж хувирахаар тийм сорилт энэ зүйл учруулсаар байж болох юм. Оливер Венделл

4 *Individuality*
5 *originality*

Холмэсийн ажигласанчлан үнэний хамгийн сайн шалгуур бол үзэл санааны зах байдаг ажээ.

### *Олон янз байдал, ёс суртахууны үүсэл хөгжил*

Хүлцэхгүйг дэмжсэн өөр нэг гаргалгаа нотолгоо бол хувь хүмүүсийн *ёс суртахууны хөгжил* юм. Прүссийн философич, дипломатч Вилхелм фон Хамболдт (1767–1835 он), жишээлбэл хүмүүн төрөлхтөний хамгийн дээд зорилго бол өөрийгөө-хөгжүүлэх гэж батлан өгүүлсэн байдаг: тиймээс хүн бүр заавал байж болох хамгийн их эрх чөлөөтэй, дүгнэлт хийх янз бүрийн туршлагатай байх ёстой ажээ. Төр биднийг гадны халдлагаас хамгаалдаг ч бидний өөрийгөө-хөгжүүлэх явдалд хөндлөнгөөс оролцохгүй зөвхөн *харуул*ын л үүрэгтэй байх ёстой.

Миллд ч ёс суртахууны харьцуулахуйц үзэл санаа байсан. Бусад хүмүүсийн үйлдэлд хөндлөнгөөс оролцох явдал түүний батлан өгүүлснээр ёс суртахуунтай хүмүүн төрөлтөн болж хөгжих явдлыг саатуулдаг. Тэд нар жинхэнээсээ өөрийнхөөрөө сонголтоо хийгээгүй л хэзээ ч сонголтынхоо төлөө хариуцлага хүлээх явдлаас суралцахгүй, бас хөгжиж дэвжих боломжгүй. Хэрэв хэн нэгэн хүн хүмүүсийн бүх үйлдлийг чиглүүлж удирдвал тэр хүмүүсийг бид магтууштай эсвэл ёс суртахуунтай хүмүүн төрөлтөн гэж хүндлэх ч боломжгүй; тэд нар хүмүүн төрөлхтөн гэхээсээ илүүтэй роботтой илүү адилхан болох болно.

### *Үзэшгүй муухай үр дагавар*

Өөр нэг чухал санаа бол үл хүлцэх тэвчих бодлого ерөнхийдөө *хэрэгждэггүй*, эсвэл *хүсүүшгүй үр дагавар*тай байдаг, эсвэл жинхэнээсээ зохиогчийнхоо зорьсон зүйлээс *эсрэг зүйлд хүрдэг* явдал юм.

Эхнийх нь жишээ болгож бид хүмүүсийн шашны итгэл үнэмшлийг ганхуулж сулруулах хэр хэцүү болохыг аль хэдийнээ харсан билээ. Үүнтэй адилаар эмчилгээний мансууруулах эмний хэрэглээг дарж зогсоох гэсэн хууль тогтоох оролдлого үр дүнгүй

байх болно.

Хоёрдохийн нь тод жишээ Америкийн Нэгдсэн Улсын Хорионы цаг үе (1920–33 он)-ийн хүсүүшгүй үр дагавар байх болно. Архи согтууруулах ундаа болон баарны соёлыг үл таашаадаг ёс суртахуунаас нилээдгүй сэдэлжсэн энэ Хориглох Хууль[6] далд арилжааг өдөөж, хууль зөрчихийг хүсэж буй хүмүүст энэ арилжааг өгчээ. Үр дүнд дээрэмчдийн бүлгийн хүчирхийллийг гааруулж, цагдаа болон олон нийтийн тушаалтны дунд хээл хахуулийг хавтгайруулж, зохих ёсоор албадан хэрэгжүүлэх боломжгүй болгон хуулийг хаа сайгүй үл хүндлэхэд хүргэв.

Амьдралын хэв маягийн сонголтыг, жишээлбэл биеэ үнэлэх, мансууруулах бодис хэрэглэх талаархи бусад хориглолт бас л хар тамхины бүлэглэл, эзэмшил газраа булаалдсан дайн, хүмүүний наймаа үүсэж гарахад хүргэж үүнтэй адил үр дагавартай байжээ. Эдгээр үйл ажиллагаанаас бий болсон жинхэнэ бэрхшээл (бэлгийн замаар дамжсан халдварт өвчин, донтолт гэх мэт)-ийг шийдвэрлэх явдлыг эдгээр үйл ажиллагаа далд хэлбэрт орж, засаг захиргааны мэдлээс гардаг учраас л улам л хэцүү хүнд болгодог. Ердийн үедээ хууль-дагадаг хүмүүс гэмт хэрэгтэн болж эрүүгийн гэмт хэрэгтнүүдтэй харьцах хэрэгтэй болох бөгөөд хуульзүйн дагуух зах зээлд байдаг чанарын хяналт эсвэл хэрэглэгчийг хамгаалах гэсэн зүйл байдаггүй учраас тэднийг энэ нь аюулд оруулдаг. Үүний хажуугаар хууль сахиулах нөөц бололцоо жинхэнээсээ бусдыг хохироодог үйл ажиллагаанаас энэ тал руу шилжиж түүнээс хөндийрнө.

Гуравдахь гэж болох зорьсноос эсрэг үр нөлөө бий болгодог либерал бус бодлогын олон жишээ бий. Жишээлбэл ажлын байран дахь алагчлах үзлээс сэргийлэх гэсэн оролдлого, мөн гавьяа зүтгэлийг зөв зүйтэй хүлээн зөвшөөрөх явдлыг баталгаатай болгох

6 *Prohibition -Хуурай Хууль гэж ёжилдог, энэхүү Хорио бол АНУ-д 1920-1933 оны хооронд үйлчилж байсан, согтууруулах ундааг үйлдвэрлэх, импортлох, тээвэрлэх, борлуулахыг үндэстний хэмжээнд хориглох үндсэн хуулийн хориг юм*

гэсэн нь гавьяа зүтгэлээс илүүтэй квот[7] гүйцээн хүмүүсийг ажилд авдаг учраас ‘позитив алагчлах үзэл’[8]-д хүргэдэг ажээ. Залуусын ухаан санааг шашны эсвэл улстөрийн бүлэг эзлэн авахаас сэргийлэх гэж бодож гаргасан, төрийн боловсрол эцсийн эцэст ортодокси үзэл бүр монополь болох эсвэл арай бага монополь байдалтай болсон. Үүнтэй адилаар шашны эсвэл улстөрийн хэлмэгдүүлэлт эцэст нь хэлмэгдүүлэгч дарангуйлагчийнхаа эсрэг хүчирхийлэл хэрэглэх явдлаар дэлбэрч гадагшлах үзэн ядах сэтгэлийг зүгээр л өрдөнө. Хамгийн муудаа л хуучны Зөвлөлт Холбоот Улс зэрэг хэт хүчирхэг төрийн тухай идеологийн ягшмал хатуу үзлээр хувь хүн, нийгэм, шинжлэх ухааны хөгжил дэвшлийг хэдэн арван жилээр хорьж саатуулах боломжтой ажээ.

### *Гулсамтгай уруу газар*

Бид төрийн албадлагын эрх мэдлийг бид үл таашаадаг дотоод итгэл[9], зан үйлийг нухчин дарахад хэрэглэвэл тэнд мэдээжээр зогсох цэг гэж байдаггүй. Милл бүр хэрэв хүн бүр тодорхой үзэл бодол эсвэл үйлдлийг дарж зогсоох хэрэгтэй гэж бодож байсан ч ингэж хийх ямар үндэслэл энд байхгүй гэж ‘ноёлж буй үзэл бодлын эзэрхэг дарангуйлал’-ыг эсэргүүцэн тайлбарлаж байжээ. Төр хөндлөнгөөс оролцох боломжгүй үйлдэл болон үзэл бодлын ‘хувийн оронзай’ байх ёстой.

Энэ байдал хүмүүс өөрсдийнхөө төлөө хол хөндий байгаа хууль тогтоогч, албан тушаалтан гаргаж чадахаас илүү сайн шийдвэр гаргах ерөнхий хандлагатай байдаг, эцсийн эцэст тэд нар бодит нөхцөл байдлыг илүү сайн ухаж ойлгосон байдгаас зөвхөн хэсэгчилж шалтгаалдаг ажээ. Өөр нэг шалтгаан нь зүгээр л тэдний талд олон хүн байдаг учраас олонхи хүмүүсийн амьдралд хөндлөнгөөс оролцох эрхтэй эрх гэж төсөөлөхөд хэт хялбар санагддаг явдал юм. Гэвч төрийн албадлагын хэрэгслээр зэвсэглэсэн олонхид иймэрхүү итгэлтэй байдал хүмүүсийн суурь эрх чөлөөнд хөндлөнгөөс

7 *quota*

8 *positive discrimination*

9 *attitudes*

оролцох, түүнийг эзэрхэх явдлаа өргөжүүлэх хэт өргөн боломж олгодог.

Энэ бол гулсамтгай уруу газар билээ. Хүмүүсийн амьдралын нэг хэсэгт хөндлөнгөөс оролцох явдлыг бусад хэсэг рүү нь зэрэгцэн хөндлөнгөөс орох явдлаа зөвтгөхөд ашигладаг. Голдуу төрийн интервенц буюу хөндлөнгөөс оролцох явдал бүтэлгүйдэг эсвэл энэ нь улам ахих хөндлөнгөөс оролцох явдлын гаргалгаа нотолгоо гэж хожим харагдах үзэшгүй муухай үр дүнд хүрэх болно. Хар тамхины бодлогын үр дүнгүй байдал, хүсээгүй үр дагаврыг жишээлбэл бүр хатуугаар тэмцэх шалтгаан болгож ашигладаг бөгөөд энэ нь мансууруулах бодис улам ихээр нийлүүлэх, улам ихээр хэрэглэх эрсдэлийг нэмэгдүүлэх, үр дүнд гарах бэрхшээлийг улам бүр л төвөгтэй болгох болно.

### *Шугам татах*

Тэгвэл бид хаагуур шугам татах вэ? Төрийн интервенцийн хязгаар хил юу байх вэ? Аль үйл ажиллагаа нь хүлцэхүйц байх бэ, аль нь үл хүлцэх үйл ажиллагаа байх вэ? Жишээлбэл эцэг эхийн аль эрх нь өөрийнх нь хүүхдүүдийнхээс дээгүүр байх хэрэгтэй вэ? Эцэг эх хүүхдээ алгадах, түүний хөвчийг таслах үйл хийх, эсвэл эхийн хэвлийд байхад нь согтууруулах ундаа болон мансууруулах бодис хэрэглэх эрхтэй байх уу? Эсвэл илүү ерөнхийдөө хэрэв ийм үйл гэмгүй хүмүүс гэмтэж хохирох боломжтой хүчирхийллийг өрдөх бололцоотой бол элэглэгч жүжигчид[10], хошин шогийн зураач нарт шашныг доромжлох үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний эрх[11] байх хэрэгтэй юу?

Иймэрхүү асуултад тодорхой ойлгомжтой хариулт байдаггүй; өөр өөр хүмүүст ондоо ондоо үзэл бодолтой байх болно. Эдгээрийн хариултыг нарийвчилж тодорхой болгох явдал сонгодог либералчуудын хамгийн чухал даалгавар юм. Тэд төрийн албадлагын эрх мэдлийг жинхэнээсээ аюултай үйлдлийг хориглож

*10 comedians*
*11 free-speech right*

зогсоох, ийм үйлдлийг шийтгэхэд аль болох нарийн тодорхой төвлөрүүлэхийг л хүсдэг. Ийм хязгаар яг хаана байх нь олон нийтийн хэлэлцүүлэг маргааны хэрэг явдал байх ёстой: бид нар үүнийг бидний өмнөөс шийдэхийг нь улстөрийн удирдагч нартаа зөвшөөрөх нь тэнэг хэрэг. Гэвч бусдад зөвхөн багахан тавгүйдэл үүсгэх боломжтой үйлдлийн маш олон нь төрийн төмөр нударгаас илүүтэйгээр гаргалгаа нотолгоо, ятгаж ухуулах ажил хэрэгтэй зүйл байх учиртай.

## Хүлцэхүй, төр

Эртний Герегчүүдэд ийм эргэлзээ байсангүй. Платон (ойр. 427– 347 он, НТӨ) болон Аристотл (384–322 он, НТӨ) нар жишээлбэл хэрэв ямар нэг зүйл сайн зүйл юм бол түүнийг албадан хэрэгжүүлэх ёстой гэж итгэж байжээ. Өнөөдөр ч гэсэн олон хүн бидний ёс суртахуунгүй гэж үздэг зүйлсийг хуулиар хориглох хэрэгтэй гэдэгт итгэдэг.

Милл ёс суртахуунгүй зан үйлийн олон нь бид түүнийг яагаад ёс суртахуунгүй гэж үздэгийн тэр шалтгаанаар магадгүй аюул учруулахуйц байж болно гэдгийг хүлээн зөвшөөрч байв. Гэвч ёс суртахуунгүй гэж нэрлэх боломжтой бусад үйл бусдад хохирол учруулахгүй байж болно: таамаглаж буй  хохирогч нь бүр үүнээс жишээлбэл амиа егүүтгэхдээ бусдаас туслалцаа авч ашиг тус олж авч байх ч боломжтой. Төрийн албадлагын эрх мэдлийг иймэрхүү гэм хоргүй зан үйлд ашиглах нь хүмүүний элбэг дэлбэг байдлыг л зөвхөн бууруулах болно.

Бүх сонгодог либералчууд төрийн эрх мэдэлд сэтгэл дундуур байдаг бөгөөд сонгодог либералчуудын өргөн хүрээний илүү либертарич хязгаарт байдаг хүмүүс төр бидний эрх чөлөөг дэмжиж тэтгэхээсээ илүүтэй түүнийг дарж дарангуйлах магадлалтай гэдэгт итгэцгээдэг. Тиймээс ч Миллийн үл хохироох ёс журам[12] гарчээ: хэрэв бид ил харагдах хохирлын шалтгаан ч болдоггүй, бас хохирол учруулахаар заналхийлдэггүй зүйлсийг хориглож эхэлбэл бид бүх зүйлийг хориглож зогсоосноор л ажил маань дуусах болно. Локк

12 *Mill's no-harm rule:*

эсвэл Жефферсоны хувьд төр иргэдээ хамгаалах, тэдний эрх чөлөөг өргөжүүлэх гэж л зөвхөн оршдог ажээ: хэн нэгний амьдралын хэвмаягийг зааж зааварчлах эсвэл тодорхой шашин эсвэл ёс зүйн код буюу ёсыг дэмжих нь төрийн хэрэг биш. Энэ зүйл Америкийн Үндсэн Хуулийн Нэгдүгээр Нэмэлтээр яагаад шашны хүлцэхүйгээр зөвхөн зогсохгүй шашин шүтэх эрх чөлөөний тухай шаргуу ятгасны учир юм.

*Эрсдэл, хүч хэрэглэх явдал*

Гэвч үйлдэл нэг бүр дор хаяж бусад хүмүүс аюултай хохиролтой байж болох зарим нэг үр дагавартай байдаг, тиймээс тохиолдол бүрд нь байр байдалд нь үндэслэж шийдвэрлэх ёстой гэж интервенционистууд батлан өгүүлдэг. Олон улс оронд жишээлбэл тамхи татахыг ресторан, кинотеатр зэрэг хаалттай орчинд газарт хориглодог. Энэ нь тамхи татагчийг хохироодог гэсэн үндэслэлээр биш харин бусад хүмүүс дам утааг амьсгалсны улсаас муу хортой нөлөөнөөс нь хохирч болно гэсэн үндэслэлд энэ нь тулгуурладаг ажээ. Бүр саяхнаас тамхи татах явдлыг дам-тамхины утаа үл мэдэгдэм байсан ч гэсэн авто зогсоолд хориглодог болсон; гэвч одоо гаргалгаа нотолгоо нь авто зогсоолд хүүхдүүд хүмүүсийг тамхи татахыг харж болно, тэднийг дууриайж үр дүнд нь эрүүл мэндээрээ зовж болно гэсэн санаа болсон байдаг.

Иймэрхүү эрсдэл тэнд нилээд байж болно; гэвч сонгодог либералчууд иймэрхүү эрсдэл түүнээс сэргийлэхийн тулд албадлагын хүч хэрэглэх зөвшөөрөл олгохоор тийм ноцтой эсэх–эсвэл энэ эрсдэл хүч хэрэглэсэн хязгаарлалт (эсвэл торгууль, бусад шийтгэл)-ыг зөвтгөх аргагүй тийм өчүүхэн эсэхэд эргэлздэг. Хэрэв бүр бусдад учрах өчүүхэн ч хамаагүй эрсдэлийг төр хөндлөнгөөс оролцох сайхан шалтгаан гэж үзэж ойлговол энэ байдал эцэст нь хүмүүний бүх үйлдлийн аль нь ч засаг захиргааны дур зоргын интервенц буюу хөндлөнгөөс оролцох явдлаас үл хамгаалагдана. Тэнд ямар ч “хувийн оронзай” байхгүй; хувийн эрх чөлөө, хууль ёс оршихоо болих болно.

Хүлцэхүй ухамсартай үйл байх ёстой. Энэ нь учир шалтгаантай

орших ёстой: нэрлэж хэлбэл бусад хүмүүсийг ёс суртахуунтай бодгаль гэж хүндлэх, мөн тэдний эрх чөлөөг хүндэтгэх бол чөлөөт нийгмийн эв найртай хамтын ажиллагааны үндэс суурь юм. Гэлээ гээд улстөрчид, албаны хүмүүс тэрхүү чухал шугамыг давахдаа байнга шахуу л үүнийг ойлгодоггүй. Олон нийт ч гэсэн мөн л асуудал бэрхшээл учрахад бүр төрийн интервенц буюу хөндлөнгөөс оролцох явдал хувийн эрх чөлөөнд халдах нь үндэслэлтэй биш байсан ч байнга л засгийн газраа “ямар нэг зүйл хий” гэж шаарддаг. Бид нар мөн л хүмүүсийг ‘өөрийнхөө сайн сайхны төлөө’ албадахад бэлэн байдаг – бодит байдал дээр бид тэд нарыг бидний өөрсдийн үнэт зүйл, бодолдоо дагуулах гэж л зөвхөн гэж албадна.

‘Хэдий бид хүмүүсийг оюун санааны сайн сайхны төлөө албадах гэж бодож төсөөлөхөө нэгэнт больсон ч гэсэн’ гэж Английн философич, антропологич Херберт Спенсер (1820–1903 он) бичиж эхлээд ‘тэднийг материаллаг сайн сайхны төлөө нь албадахыг шаардах үедээ ч бид өөрсдийнхөө тухай л бодсоор байдаг: ингэх нь бусдынхаа адилаар зөвшөөрөх аргагүй зүйл гэдгийг ойлгодоггүй’ гэж дуусгажээ. Энэ бол яагаад сонгодог либералчууд төр засагт хязгаар тавихыг шаарддагийн зүгээр л нэг шалтгаан юм.

# ЗУРГААДУГААР БҮЛЭГ:
# Сонгодог Либерал Улстөрийн Ухаан

## Төр засгийн гарал үүсэл, зорилго

Түрүү үеийн сонгодог либералчууд төр засаг зөвхөн хүмүүсийн эрхийг хамгаалах, албадлагын бууруулж, эв найр ноёлох боломж олгон тэдний бололцоо болон эрх чөлөөг өргөжүүлж тэлэх гэж л зөвхөн оршдог гэдэгт итгэдэг байсан. Хэрэв хэн нэгэн хүч хэрэглэх байсан бол тэр нь зөвхөн төр засаг байх ёстой бөгөөд энэ нь зөвхөн эдгээр зорилгоор хүч ашиглах ёстой.

Нөгөө талаас тэдний алсын хараа[1] нь хязгаарлагдмал-эрх мэдэлтэй засгийн газар байсан билээ – ийм төр засаг эрх мэдэл болон ажлын хүрээгээр хязгаарлагдсан, үнэндээ хуульзүйн байдл[2]аараа хязгаарлагдсан байна. Эрх мэдэлтэй холбоотойгоор тэд нар хэрхэн албан ёсны эрх мэдэл эрх чөлөөг аюулд оруулах боломжтойг, тэр эрх мэдлийг хазаарлах шаардлага хэрэгцээг сайтар ухаарч ойлгосон байжээ. Ажлын хүрээний талаар тэд нар хуульзүйн бүрэн эрхтэй төр засаг[3] эзлэн түрэмгийлэл, хүч чадалд тулгуурладаггүй харин хоорондоо ялгаатай хувь хүмүүсийн санал нэгдэх явдалд үндэслэдэг гэдгийг шаргуу ятгаж болж байв – энэ хүмүүсийн түүнийг байгуулсан цор ганц зорилго бол эрх, эрх чөлөө, боломжоо тэтгүүлж дэмжүүлэх явдал байдаг. Хуульзүйн дагуухь байдлын тухайд Локк төр засаг бүрэн эрх[4]ээ өөрийн зан үйлээ иргэний эрхийнхээ төлөө оронд нь барьж хумихыг зөвшөөрсөн хувь хүмүүсээс авдаг гэдгийг тайлбарласан. Тиймээс л засгийн газар буюу төр засгийн бүрэн эрх нь энэ хувь хүмүүсийн түүнд олгосон тэр бүрэн эрхээс давах боломжгүй. Жишээлбэл амьдрах эрх болон эрх чөлөөт байдал зэрэг салшгүй эрхээ биднийг эдлэхийг маань төр

1 *vision*
2 *in legitimacy*
3 *legitimate government*
4 *authority of government*

засаг хориглох боломжгүй.

Засгийн газар буюу төр засгийг хязгаарлах өөр нэг сайн шалтгаан бол хүмүүний байр байдлын сул дорой байдал юм. Засгийн газарт буй хүмүүс зүгээр л хүмүүс билээ; тэд нар хэн нэгнээс илүү ухаалаг ч биш бас хүмүүсээс дутуугүй өөрийн-тусыг боддог. Гэвч тэд нар албадлагын асар их эрх мэдэл, үүн дотроо биднийг торгох, шоронд хорих эрх мэдэл эдэлдэг. Тэд нарыг өөрийн хүссэнээрээ эрх мэдлээ эдлэхээр орхих нь тэнэг хэрэг байх болно; энэ эрх нь хяналттай, хязгаарлагдмал байх ёстой. Сонгодог либералчууд абсолют буюу хэт бүрэн эрхэнд бүр үүнийг хүмүүсийн дийлэнхи олонхи дэмжиж байсан ч гэсэн итгэдэггүй.

## *Төр засгийн фүнкц*

Гэвч энэ чинь засгийн газрын талаархи хэт явцуу үзэл санаа биш гэж үү? Сонгодог либералчууд голдуу лэзе-фэер эсвэл цомхон, хэрэггүй эрхтэн мэт буюу үл мэдрэгдэх *манаачийн-үүрэгтэй төр*[5]д итгэдгээсээ болж шоолуулцгаадаг. Шүүмжлэгч нар нь хэрэв хүн бүр төр засаг юуны төлөө оршиж буй талаар санал нэгтэй байх хэрэгтэй л юм бол тэд энэ талаар ер санал нэгдэхгүй бөгөөд тэд анархи байдал[6]даа шигдэж үлдэнэ гэж хэлдэг.

Орчин үеийн төр засаг түрүү үеийн сонгодог либералчууд түүнд баталгаажуулж өгөхийг хүсэж байсан ажлын хүрээ, эрх мэдлээс бүр илүү их ажлын хүрээтэй, эрх мэдэлтэй болж хөгжжээ. Өнөөдөр бүр сонгодог либералчууд төр засаг Миллийн баримталж асан үл хохироох зарчмаас давсан, иргэний эрх чөлөөг дэмжсэн хэрэгтэй фүнкцтэй байх боломжтой гэдгийг голдуу хүлээн зөвшөөрсөн байдаг. Милтон Фрийдмэн баянаас нь авч ядууст өгч орлогыг дахин хуваарилах *хасах орлогын татвар*[7] болон ядуу гэр бүлд

---

*5 vestigial night-watchman state-эволюцын явцад бүх үндсэн фүнкц нь хэрэгцээгүй болсон эрхтэнийг хэлдэг.*

*6 эмх цэгцгүй, замбараагүй байдал*

*7 negative income tax-тодорхой төвшнөөс дээш гарсан хүмүүс татвар төлөх бол харин энэ төвшнөөс дор буй хүмүүст төр мөнгө өгнө гэсэн үг юм. Түүнийг анх 1940-өөд оны үед Жулиет Рис-Виллиамс гаргажээ. Харин Милтон Фрийдмон алдаршуулав.*

боловсрол эзэмших боломж олгохын тулд төрөөс-санхүүжүүлсэн *боловсролын ваучер буюу эрхийн бичг*ийг тун шаргуу өмгөөлж хамгаалж байв.[8]

Адам Смит өөрөө олон нийтийг батлан хамгаалах тогтолцоо, шүүхийн тогтолцоогоор хамгаалах дээр нэмээд засгийн газар гүүр, боомт зэрэг олон нийтийн ажлаар хангаж, олон нийтийн боловсролд хувь нэмэр оруулах ёстой гэж бодож байсан.

Гэвч хамтаараа илүү хамгийн сайн хийх боломжтой зарим нэг хэрэгтэй зүйлс байж болох ч гэлээ хаагуур нь [үл давах] шугамаа зурах вэ гэдэг нь асуудал болно. Энэ байдалд бодит хохирол яг хэзээ болсон, эсвэл ийм хохирол учруулахаар заналхийлснийг тодорхойлох эсвэл тухайн интервенц буюу хөндлөнгөөс оролцох явдлын үр өгөөж нь чухам юу байх боломжтойг тодорхойлох явдал голдуу төвөгтэй байдаг гэсэн бодит байдал ч тус болдоггүй. Милл жишээлбэл хэдий үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө[9]ний хамгаалагч байсан ч гэсэн үл хохироох зарчмаа үзэл санааны шүүлтүүрийн сайн үндэслэл болох боломжтой бодож байсан байдаг. Тэрбээр мөн шүүхэд гэрчээр оролцох, хүүхдүүдийг тань зохих ёсоор сургуульд явах явдлыг баталгаажуулах зэргээр бусдад туслахын тулд хувь хүмүүст янз бүрийн үүрэг ногдуулахыг өмгөөлж хамгаалж байлаа. Милл худалдаа хийх, ажлын цаг, цалин, ажлын байрны хөнгөлөлтийн дүрэм журамд төр засаг нөлөөлдөг байх хэрэгтэй гэж харж байсан. Тэрбээр ажил эрхлэх боломжтой хүмүүсийг ажлаар хангаж, бусад хүмүүст амьжиргааны хамгийн бага стандартыг өгөх нийгмийн халамжийн хуул[10]ийг өмгөөлж хамгаалж байв. Милл засгийн газар зам харгуй, ариутгах татуургын байгууламж[11] зэрэг дэд бүтцийг барих ёстой гэж бодож байлаа. Тэрбээр шинжлэх ухаан болон урлагт олон нийтийн татаас өгөхийг мөн шаардаж уриалж ч байв. Бүр олон нийтийн багахан ашиг тус ч түүний бодсоноор иймэрхүү интервенц буюу хөндлөнгөөс оролцох

8 *Mill's no harm rule*
9 *free speech*
10 *social welfare laws*
11 *sanitation*

явдлыг зөвтгөх үндэслэл болох ажээ. Олон сонгодог либералчууд энэ бүгдтэй санал нийлдэггүй.

Бүр саяхан бүр төрийн хэтэрхий их эрх мэдлийн тухай ном (*Боолчлогдох Зам*)-доо Ф. А. Хаек мөн л өөрөө төр засаг хуульзүйн дагуу[12] авах боломжтой гэж бодсон л зарим фүнкцийн жагсаалтыг бичсэн нь бий. Тэдгээр фүнкцэд хүмүүст эрүүл мэндээ хамгаалж, ажиллах чадвараа хадгалж үлдэхэд нь хангалттай байх хамгийн бага хэмжээтэй хоол, байр сав, хувцсаар хангах; эрсдэлийн эсрэг даатгуулахад хэцүү зовлонд унасан хүмүүст зориулсан нийгмийн даатгалын өргөн цар хүрээтэй тогтолцоо; хувь хүмүүс дахиад л бэлтгэлтэй бэлэн байж чадахгүй байгалийн гамшгийн дараа тусламж үзүүлэх; бизнесийн мөчлөг, түүнээс бий болох ажилгүйдэлтэй тэмцэх эдийн засгийн бодлого гаргах орсон байдаг.

Олон сонгодог либералчууд иймэрхүү буулт хийх явдал үргэлж [аюул тарих] маш том соёоны нарийн үзүүр байдаг гэдэгт санаа зовдог. Хаек өөрөө гомдоллож байсанчлан 'онцгой байдал үргэлж л хувь хүмүүсийн эрх чөлөөт байдлын хамгаалалтыг устгаж сулруулах урьдач нөхцөл байдаг' билээ – бид төрд онцгой байдлын тусламж үзүүлэх, хоол хүнс, орон байр, хувцсаар хангах, боловсрол, эрүүлмэндийн үйлчилгээг өгвөл цөөнхийн хувьд юу хэрэгцээтэй зүйл нь байх, олны хувьд юу тав тух нь байхын хоорондохь шугамыг гаргаж баримтлах хялбар биш байдаг. Өөрөөр хэлбэл төр засгийн иймэрхүү интервенц буюу хөндлөнгөөс оролцох явдалд ямар ч тод *хязгаар* байдаггүй.

Адам Смит түүний дурдсан жишээлбэл гүүр, боомт барих, боловсролыг дэмжих зэрэг засгийн газрын хөндлөнгөөс оролцох оролцоо бол зөвхөн хүмүүн төрөлхтөнийг нэг нэгэнтэйгээ нийгмийн болон эдийн засгийн хамтын ажиллагаанд орох боломж олгодог дэд бүтэц юм гэж хэлэн энэ хэцүү зүйлийг шийдвэрлэхээр оролджээ. Тиймээс л эдгээр интервенц эрх чөлөөнд заналхийлэхээсээ илүүтэй эрх чөлөөг *тэтгэнэ* гэсэн байдаг. Хаек мөн л төр засгийн түүний дурдсан хөндлөнгөөс оролцох оролцоог хүмүүсийг өөрсдийнхөө

12 *legitimately*

төлөө зогсох боломжтой байлгах гэсэн оролдлого гэж харсан байв; тиймээс дахиад л түүний санаа чөлөөт хүмүүс амьдрах, ажиллах, хамтдаа хамтран ажиллах боломж олгох тэр л зүйлийг зөвхөн өгөх явдал байсан.

Гэлээ гээд засгийн газрын *аливаа үйл ажиллагаа* хэдий хэрэгтэй ашигтай байсан ч хүмүүсийн эрх, эрх чөлөөнд, ялангуяа тэдний өмчийг татвар хэлбэрээр булаан авч төрийн үйл ажиллагааны төлбөр хийх зэргээр зарим нэг байдлаар халдахыг энэ нь шаарддаг. Зарим сонгодог либералчууд өмч бол төр засаг *хамгаалах* гэж л оршин байдаг тэр зүйл юм гэж батлан өгүүлэхдээ үүнийгээ үндэслэлтэй зөв гэж харуулах нь хэцүү болохыг мэднэ. Бусад нь зүгээр л олон нийтийн ашиг тус, хэдий тодорхой байдаг ч хувь хүний эрх, эрх чөлөө рүү халдахад хангалттай их гэдэгт итгэлтэй байхыг л хүсдэг.

Бодит ертөнцөд байдаг аюул бол [төр засгийн] ‘гуйвамтгай ажил[13]’ юм – энэ нь төр засаг илэрхий хамтын хариуцлага байх хэдхэн зүйлээр эхлээд дараагаар нь эрх мэдэл, фүнкцээ ямар ч эцсийн харагдах тодорхой цэггүйгээр өргөжүүлж тэлдэг гэсэн үг билээ. Сонгодог либералчууд магадгүй ихэнхи хүмүүсээс тэд нар хязгаарлагдмал засгийн газрын хэрэгцээг, мөн засгийн газрын эрх мэдлийг өргөжүүлж тэлэхийн аюулыг мэддэг учраас энэхүү хязгаарыг зурахдаа илүү сайн мэргэжсэн байдаг байж болох юм. Тэд хэдий засгийн газар онцгой байдлын тусламж үзүүлэх зэрэг зарим зүйлээр хангах явдлыг бататгахад үүрэг оролцоотой байх боломжтой ч гэсэн засгийн газар эдгээр зүйлийг өөрөө нийлж хангахгүй байх хэрэгтэй гэж үздэг. Сонгодог либералчууд хэдий төр засаг зах зээлийг зохицуулах чадалтай ч бололцоотой ч гэсэн мөн л яагаад зах зээлийн тоглогч биш харин арбитр буюу дундын зуучлагч[14] байдалтай хэвээр үлдээх ёстойг ухаж ойлгосон байдаг; яагаад аюул зовлонд өртсөн тодорхой хүмүүс, бүлэг хүмүүст хүргэх засгийн газрын-удирдсан тусламж урт хугацааны, том хэмжээний орлого дахин хуваарилалт болж өргөжих ёсгүйг нь сайн ухаж

*13 mission creep*
*14 umpire*

ойлгосон байдаг.

## Нийгмийн шударга ёсны тухай худал яриа

Үүнээс ялгаатай нь 'шинэ либералчууд' орлогын дахин хуваарилалт бол засгийн газрын хийх хэрэгтэй яг тэр зүйл юм гэж үзэцгээнэ. Тэд нар тэгш бус байдал, ядуурлыг ажил олгогч болон баячууд үр өгөөж хүртдэг ч ажилчид болон ядууст хохиролтой байдаг хүч тэнцвэргүй эрх мэдэл, өмчийн шударга бус хуулийн үр дагавар гэж харж ойлгодог. 'Нийгмийн шударга ёс'-ыг тэтгэхийн тулд тийм учраас төр засаг заавал хүч чадлын тэнцвэргүй байдлыг засаж, эд баялаг болон орлогыг илүү баян нэгнээс илүү ядуу хүмүүс рүү дахин чиглүүлэх ёстой ажээ.

Сонгодог либералчууд энэхүү "шударга ёс" гэсэн үгийг энд бүдүүлгээр буруу ашигласан гэж боддог. Тэдний хувьд шударга ёс бол харилцааны буюу коммутатив шударга ёс байдаг[15] бөгөөд энэ нь хувь хүмүүсийн хоорондохь зөрчилдөөнийг шийдвэрлэх, халдсан этгээдийг нь шийтгэх замаар хувь хүний эрх, эрх чөлөөг хамгаалдаг явдал ажээ. Энэ нь заналхийлэл, хүчирхийллийг хязгаарлах, албадлагад өртсөн зовлонд унасан хүмүүст хохирлыг нөхөн төлүүлэх явдлыг баталгаажуулах тухай зүйл юм. Энэ нь бидний нэг нэгнээсээ гарах болно гэж бодож буй зан үйл, байдаг гэж боддог эрхийн тухай зүйл ажээ.

Бодит жинхэнэ шударга ёс тийм учраас зөвхөн хүмүүс хэрхэн нэг нэгэндээ хандаж харьцах зан үйл хийхэд анхаарал хандуулна. Хулгайд юмаа алдах, дээрэмдүүлэх нь шударга бус; харин ханиад авах нь азгүйтэл боловч хэн ч шударга бусаар үйл хийгээгүй учраас ханиад тусах нь шударга бус хэрэг биш. Нийгмийн эсвэл хуваарилалтын шударга ёс[16] нөгөө талаас нилээд ондоо зүйл. Энэ бол бүлэг хүмүүсийн ондоо ондоо гишүүдийн дунд эд юмс хуваарилах тухай зүйл юм. Энэ нь бүр хэрэв өмнө нь байсан

---

*15 commutative justice-Бараа бүтээгдэхүүн ижил тэнцүү солилцох, гэрээний үүргээ биелүүлэх талаархи хүмүүсийн харилцаанд тулгуурладаг шударга ёсыг хэлдэг ажээ.*

*16 Social or distributive justice*

хуваарилалт зүгээр л үйл явдлын үр дагавар байдаг, мөн хэн ч муу үйл хөдлөл гаргаагүй эсвэл шударга бус үйлдэл хийхгүй байсан ч, ерөнхийдөө илүү их тэгш байдал руу хандсан тэр хуваарилалтыг л өөрчлөхийг зорьдог.

Хэрэв жишээлбэл, 100 000 хүн алдартай дуучны тоглолт стадионд үзэхээр мөнгө төлсөн бол тэд нар тэр орой барагтай хэмээгээр ядуурсан, харин дуучин нь нилээд баян болсон байх болно. Гэвч хэн ч үүнд буруу зүйл хийгээгүй, хэн ч ямар нэг албадлага хэрэглэсэнгүй. Сонгодог либералчууд тиймээс дараахь зүйлийг асуух болно: үр дүнд нь гарч буй эд хөрөнгөний хуваарилалт *шударга бус* байх байж болох уу? Тэд нар юмс үзэгдлийг тэгш байдал руу буцаан оруулахад *албадлага шаардлагатай* болно, уг дуучнаас шинэ эд баялгийг нь үзэгч нарт нь буцаан өгөх гэж хүчээр авах болно гэдгийг цохон заадаг. Үнэндээ Нозикийн хэлэхээр ирээдүйд тэгш байдлыг сахин хамгаалахын тулд *албадлагыг байнга, үргэлж хийх* хэрэгтэй болох ажээ.

Тэнд бас оновчтой байдлын асуудал бий. Орлогын бүрэн гүйцэт тэгш байдал гэж байх боломжгүй: яагаад хүмүүс хэрэв тэд нар юм хийгээгүй хүмүүстэй адилхан цалин авах бол шаргуу ажиллахаасаа залхах эсвэл бүр ажиллахаа болих ёстой бус уу? Тиймээс ‘нийгмийн шударга ёс” илүүтэй *хэрэгцээ*нийх нь дагуу эсвэл нийгэмд өгч буй хүмүүсийн *үнэ цэн*ийн хувийн дагуу хийх дахин-хуваарилалтад анхаарал хандуулдаг. Гэвч хэнд хэрэгцээ байгаа гэж хэн шийдэх вэ, хэнийх нь үнэ цэнэ хамгийн их байх бэ? Зөвхөн залхуугаасаа болж ядуу болсон хэн нэгэн хүн хуй салхиар гэрээ бизнесээ сүйтгүүлсэн хүнээс илүү “хэрэгцээ”-тэй байх уу? Сувилагч нь хийлчээс илүү нийгэмд хувь нэмэр оруулдаг уу? Үүнийг шүүн цэгнэх обьектив арга зам байдаггүй: шийдвэр нь бүхэлдээ субьектив шинжтэй. Гэлээ гээд иймэрхүү дур зоргын үндэслэлийн тусламжтайгаар “нийгмийн шударга ёс”-ыг өмгөөлж хамгаалагсад хүмүүсийн өмч, эрх чөлөөг булаан авдаг.

Зөвхөн үүгээр зогсохгүй ‘нийгмийн шударга ёс’ л хүмүүст ондоо ондоо ханддаг: хүмүүс хэр баян эсвэл ядуугаас хамаарч өөр өөр хэмжээний татвар төлдөг эсвэл төрийн дэмжлэг ондоо ондоо

хэмжээгээр хүлээн авна. Энэ байдал нь хууль ёсыг зөрчдөг – энэ бол хууль хүмүүст тэгш үйлчлэх ёстой, хэнд ч засаг захиргааны дур зоргын шийдвэрээр туслах, эсвэл хэнийг ч хохироох ёсгүй гэсэн зарчим юм.

Сонгодог либералчууд тиймээс аливаа эд баялаг эсвэл орлогын өргөн цар хүрээтэй дахин-хуваарилалтыг эсэргүүцдэг. Тэд нар төрөөс-зохион байгуулж буй зарим нэг онцгой байдлын тусламжийг өмгөөлж хамгаалж болно; гэвч тэд нар хэн ч урт-хугацааны халамжийн дэмжлэг авах *эрх*тэй байхыг үгүйсгэдэг - учир нь энэ нь бусад хүн хэдийгээр энэ хүмүүс нутаг нэгтнийхээ зовлонт байдалд буруугүй байсан ч гэсэн тэднийг хэрэв шаардлагатай бол хүчээр дэмжих *үүрэг*тэй болно гэсэн үг юм.

Энэ байдал ядуу хүмүүс сонгодог либерал нийгэмд тухгүй байна гэсэн үг биш. Чөлөөт нийгэм улам илүү баян нийгэм болох руу тэмүүлдэг бөгөөд баян улсад ядуу байх нь ядуу улсад ядуу байснаас дээр билээ. Баян улсын хүмүүс мөн л буяны байгууллагаар дамжуулан өглөг өгч, буяны үйлс хийн илүү их зүйл тарааж өгөх хандлагатай байдаг; хэдий тэд нар хэрэгцээтэй байгаа бусдадаа туслах хуульзүйн үүрэг хүлээгүй байсан ч гэсэн тэд эдгээр ядуу улсын өмнө хүлээсэн ёс суртахууныхаа үүргээ биелүүлэх нөөц баялагтай байдаг.

## Олон нийтийн сонголт, хувийн ашиг сонирхол

Сонгодог либералчууд ямар ч тохиолдолд дахин-хуваарилалт зэрэг хэрэг явдлын талаар хэрхэн улстөрийн шийдвэр гарч буйд маш сэжиглэнгүй ханддаг. Эдийн засгийн концепцийг улстөрийн шийдвэр-гаргах үйл явцад хэрэглэсэн, мөн үүнийг нь хүмүүс ихээр хүсэж буйг олж мэдсэн, Олон Нийтийн Сонголтын Сургуул[17]ийн бүтээлд тэдний энэ эргэлзээ сэжиг бат суужээ.

Ноёлж-буй-урсгалын 'халамжийн эдийн засагчид'[18] *зах зээлийн бүтэлгүйтэл*, түүнийг залруулахын тулд засгийн газрын үйлдэл шаардлагатай талаар удаан хугацаанд ярьцгаажээ. Тэдний

*17 Public Choice School*

*18 main-stream*

мартчихсан зүйл бол тэнд ч бас *төр засгийн алдаа* байдаг явдал юм. Улстөрчид, албан тушаалтнууд ариун амьтад биш ээ: хувийн зах зээлд байдаг шиг ардчилсан тогтолцоонд ч бас тийм их өөрийн-тусыг бодох явдал бий .

Сонгууль жишээлбэл олонхи нь юу хийх ёстойг шийддэг өрсөлдөж буй ашиг сонирхлын тэмцэл ажээ. Олонхи нь цөөнхийн том аюул заналхийлэл байдаг – хоёр чоно нэг хонь өдрийн хоолоороо юу идэхээ шийдвэрлэж буй тухай ардчиллын талаархи эртний шог яриа шиг л байна. Энэ байдлыг өөрсдийнхөө маш нягтарч багцлагдсан ашиг сонирхлын төлөө сонгогдогчдын давуу байдлыг олж авах гэж эрчтэй кампанит ажил явуулдаг, лобби хийдэг бүлгүүд л сонгуульд давамгайлдаг гэсэн бодит байдал бүр илүү муутгадаг. Голдуу ашиг сонирхлын бүлэг л сонгогдогчдынхоо барьц[19]ыг улам л их болгох гэж харилцан биесээ дэмжсэн эвслийг байгуулна. Улстөрчид, үүний хажуугаар санал авч ялах гэсэн тооцоотой ашиг сонирхлын эдгээр эвслийн хүслийг тойглоно – энэ бүхний эцэст бүр хамгийн олон нийтийн-төлөө-сэтгэлтэй улстөрч сонгогдохын тулд ямар ч зүйл хийх хэрэгтэй болно. Мэдээжээр ялагдсан хүмүүс бол ‘дуугай олонхи’ юм – энэ хүмүүс бол ашиг сонирхол нь маш ихээр сарниж тархсан ерөнхий олон нийт ажээ.

Бас хууль тогтоох байгууллагын шийдвэр ч тийм ч сайхан зүйл биш. Өөрийн арга хэмжээгээ дэмжүүлэхийн тулд хууль тогтоогч хамтран ажиллагч нартайгаа “чи миний арга хэмжээнд саналаа өг, харин би чиний төлөө саналаа өгөх болно’ гэж эргэх тойргоор хамтран ажиллана. Иймээс хэн нэгэн жинхэнээсээ бодсоноос илүү их хууль гарна тэр хэмжээгээр төлөөлөл байхгүй ерөнхий олон нийт илүү ихээр ашиглагдаж мөлжүүлэх болно. Эдгээр хууль хэрэгжээд эхлэхэд захиргаадалтын бүтэц[20]эд бас дахиад өөрийн ашиг сонирхол, магадгүй өөрийн эзэнт гүрнээ тэлж өргөжүүлэхийн тулд тухайн хөтөлбөрийн хэмжээ болон нийлмэл байдлыг нь нэмэх гэсэн ашиг сонирхол байх болно.

---

*19 electoral leverage*
*20 bureaucracy*

## Сонгодог либерализм ба ардчилал

Сонгодог либералчууд *сэтгэл дундуур ардчилагчид* билээ. Тэд хамтын үйлдэл шаардлагатай багахан хэмжээтэй зарим нэг функц байдаг гэдгийг хүлээн зөвшөөрцгөөнө. Тэд нар хүчирхэг зарим нэг язгууртнууд буюу элитүүд биш харин ерөнхий олон нийт эдгээр функц нь ямар зүйл байх, түүнийг яаж хэрэгжүүлэх талаар өргөн хүрээтэй шийдвэр гаргах ёстой гэдэгт итгэдэг. Тэд төлөөллийн засгийн газар бол магадгүй эдгээр шийдвэрийг гаргуулах, хэрэгжүүлэх хамгийн сайн арга зам байж болох юм гэж таамаглана.

Гэвч тэд нар ардчилсан үйл явц төгс гэхэд дэндүү болхи болохыг нь мэддэг. Энэ бол *өөр өөр ашиг сонирхлыг* (зах зээл хийдэг шиг) *эвлэрүүлдэг* биш харин *хоорондоо зөрчилдсөн ашиг сонирхлуудаас бидний сонгосон* нэг нь, зөвхөн нэг тал нь ялах боломжтой сонголт юм. Ардчилал нь сонгогчид, төлөөлөгчид, албан тушаалтны сувдаг тооцоотой өөрийн-тусыг бодох үйлдлээс гүн шарх олсон; үүнээс маш эрүүл бус иррационал үр дүн гарна; бүгдийг нь “ардчилал”-ын нэрээр хэт олон удаа цөөнхийн бүлгийг ашиглаж мөлжинө, тэдний эрх чөлөөт байдлыг хумина хязгаарлана.

Эдгээр шалтгааны улмаас ардчилсан шийдвэр-гаргах үйл явцыг тодорхой ёс журмаар хязгаарлах хэрэгтэй, мөн үүнийг аливаа өөр арга замаар шийдвэрлэх боломжгүй тэдгээр асуудалд л маш нарийн төвлөрч хэрэглэх ёстой гэдгийг сахин хамгаалдаг. Төлөөллийн ардчилал бол олон хүн (магадгүй эрх мэдэлд хүрсэн бараг бүх хүмүүс) улам бүр олон зүйлийг ардчилсан үйл явцаар шийдвэр хэрэгтэй гэж батлан өгүүлэхэд хүргэсэн, мэдээжээр магадгүй хараахан бодож олсон төр засгийн хамгийн сайн хэлбэр биз ээ. Гэвч энэ нь эдгээр асуудлыг *улстөрийн үйл явц*аар шийдвэрлэнэ гэсэн үг юм; улстөрийн явц үргэлж сайн үйлс бүтээдэг хүч байдаггүй. Улстөрөөр шийддэг асуудал улам олон болбол хувь хүний эрх болон эрх чөлөөт байдал тэр хэрээр ганхах сулрах бөгөөд цөөнхийн бүлгийг төрийн албадлагын эрх мэдэл эдлэгч мөлжинө ашиглана эсвэл дарж дарангуйлах болно.

Сонгодог либералчуудын хувьд үүнээс ялгаатай нь эрх, эрх чөлөө

хүн бүрийнх байдаг: эдгээр нь тоо толгой, олонхийн хэрэг явдал биш ажээ. Жинхэнэ төлөөллийн ардчилал сонгогдсон дарангуйлалтай адилхан зүйл биш бөгөөд түүнийг ийм зүйл болж мутацад орохыг нь зөвшөөрөх ёсгүй. Сонгуулийн үйл явц ялсан олонхид бусдыг өөрсдийн хүссэнээрээ заналхийлэх зөвшөөрөл олгодоггүй.

Ардчилсан, улстөрийн үйл явцыг хамтаараа шийдэх ёстой, зөвхөн тэгж шийдэх боломжтой зүйлийг шийдвэрлэхээр л хязгаарладгийн адилаар сонгодог либералчууд мөн л бүх хувь хүмүүсийн эрх, эрх чөлөөг энэхүү үйл явц хэрхэх явагдах, хэрхэн ийм шийдвэр гаргах тухай хязгаарлалт тавих замаар хамгаалахыг хичээдэг.

## *Үндсэн хууль, эрх чөлөө*

Үндсэн хууль бол эдгээр хязгаарлалтыг тогтоож гаргадаг, тэдгээр хязгаарлалтдаа олонхи болсон, эрх мэдэлд байгаа хүмүүс хялбархан дийлж үл чадах хүч чадал өгөх нэг арга зам юм. Энэ нь үргэлж бүтээд байдаггүй: бүр харагдах байдлаараа хүчирхэг либерал үндсэн хуультай улсууд ч гэсэн төр засгийн хэмжээ хурдтай өсөхөөс, мөн хувь хүний эрх, эрх чөлөөт байдлыг олон ганхуулж, сулруулах явдлаас дархлаажсан байдаггүй. Үндсэн хуулийн эрх чөлөөг хэрэв ерөнхий олон нийт тэдгээрийн ач холбогдлыг, мөн эдгээр нь тэднийг хамгаалах болно гэдгийг ухаарч ойлгохоо болиход хамгаалахад хэцүү болно.

Гэвч сонгодог либералчууд үндсэн хуулийн хязгаарлалт тогтоох нь бидэнд хувь хүний эрх, эрх чөлөөг хамгаалах боломж өгдөг гэдэгт ерөнхийдөө итгэдэг.

Эрх мэдэл зааглаж хуваах[21], биесээ хянах болон эрх мэдэл тэнцвэржүүлэх[22] зэрэг ёс журмаар, жишээлбэл, олон танхимт төр

21 *separation of powers -манайхан үүнийг эрх мэдлийн хуваарьлалт гэж distribution гэдэгтэй андуурахаар орчуулсан. Энэ бол буруу, бас буруу сэтгэгдэл санаа төрүүлдэг. Эрх мэдлийг хуваарьладаггүй харин зааглаж хуваадаг билээ.*

22 *checks and balances on government power -орос. система сдержек и противовесов*

засаг[23], холбооны тогтолцоо[24], шүүхийн хяналт[25] зэргээр бид тооцоотой сувдаг ашиг сонирхлын бүлэг[26] аливаа шийдвэр гаргах үйл явцыг бүхэлд нь булаан авахаас сэргийлэх гэж оролддог.

Сонгодог либерал үндсэн хууль зөвхөн төр засгийн эрх мэдлийг хязгаарлах, түүнийг хуваах явдлыг баталгаажуулж бататгадаг. Үндсэн хууль хуулийг бүх бүрд тэгш хэрэглэх, ямар ч тодорхой ашиг сонирхлын бүлэгт, үүн дотроо улстөрчид, засгийн газрын албан тушаалтанд өөрсдөд нь онцгой хандах боломжгүй гэдгийг баталгаатай зүйл болгодог.

Иймэрхүү үндсэн хуулиар мөн төрийн эрх мэдлийн хил заагийг хувь хүмүүсийн суурь эрхийг ямар ч албан тушаалтан засаг захиргаа давж гарахгүй гэж тогтоож өгөх зам (түүнийг байгуулсан иргэд нь бусдын эрхийг хохироох бүрэн эрхийг төрд ийм зүйл иргэд нь байхгүй тул шилжүүлж өгөх боломжгүй)-аар зааглах боломжтой. Гэвч иймэрхүү *Эрхийн тухай Билл[27]* нь хүн бүрийн амьд явах[28], эрх чөлөөт байдал, өмч, гэрээний эрх чөлөө, үзэл бодлоо илэрхийлэх болон үг хэлэх эрх чөлөө[29] зэрэг үндсэн эрхийг тус болохуйцаар сануулж хэлэхэд хэрэгтэй зүйл байж болох бол түүнд эрх, эрх чөлөө нэг бүрийг жагсаан дурдах боломжгүй. Хоббэсийн хэлсэнчлэн 'хууль чимээгүй байх[30]' хүрээн дотор бид аливаа зүйлийг хийх нь чөлөөтэй байх хэрэгтэй боловч харин бидний *хийх боломжгүй* хэдэн зүйлийг жагсаан бичихээс илүүтэй бидний *хийх боломжтой* бүгдийг жагсаан бичих гэж оролдсон хуульзүйн тогтолцоо нуршуу урт, нийлмэл нарийн, хийдэл гажигтай, зовлонтой хязгаарласан шинжтэй байх болно.

Үүнээс илүү хүмүүс өөрийн зорилгодоо эв найртай аливаа

---

*23 multi-cameral government*
*24 federal system*
*25 juridicial review*
*26 vested interest groups*
*27 Bill of Rights -Эрхийн Тухай Цааз ч гэж болох юм.*
*28 life*
*29 freedom thought and speech*
*30 silence of the law*

арга хэрэгсэл ашиглаж хүрэхээр хуульд тогтоосон цөөн хэдхэн ялгаварлаж заасан зүйлийг мөрдөж тэмүүлэх нь чөлөөтэй байна гэсэн ерөнхий төсөөлөл байх хэрэгтэй. Ихэнхи нь эрх чөлөөний ерөнхий төсөөллөөс илэрхий байдаг олон тооны эрх чөлөөгөө ширхэгчлэн дурдаж бичих хэрэгцээ байхгүй.

## Төр засгийн хуульзүйн бүрэн эрхэт байдал

Швейцар-Францын зохиолч, улстөрч Бенжамин Констант (1767–1830 он) үндсэн хууль бидний удирдагчдыг хүч чадалтай болгох гэж оршдоггүй харин тэднийг хязгаарлах гэж оршдог гэж тэмдэглэн хэлжээ. Бидний хэнд нь ч бусдыг захирах эрх дарх байхгүй; санал нэгдэх л хэрэг явдал бидний дунд байх ёстой. Хэрэв засгийн газар олон нийтийн итгэсэн санал[31]ыг алдвал нийт эрх дархаа алдаж, албадлагын эрх мэдэл нь хуульзүйн бүрэн эрхгүй болдог.

Франк Найт бидэнд сануулсанчлан төр засгийг өөрийг нь хязгаарлагдмал байлгах хэрэгтэй: бид хэзээ ч эрх мэдэл их хэмжээгээр нэг дор цугларахыг зөвшөөрч болохгүй ажээ. Гэвч төр засаг Локк болон Пэйне нилээд зөв оножхэлснээр мөн л [тэдний эсрэг босох] бослого тэмцэл гарах заналхийллээр бас хязгаарлагдана.

Гэлээ гээд тэдний мэдэлд өгсөн албадлагын хүчээр бүр хамгийн шударга бус төр засаг ч маш урт хугацаанд тэсэж эрх барьсаар байдаг. Сонгууль бол бүх алдаа дутагдлынх нь төлөө засгийн газрыг зайлуулах илүү эв найртай арга зам юм. Үндсэн Хуулийн адилаар сонгууль удирдагчаа сонгох гэж биш харин тэднийг хязгаарлаж хазаарлах л гэж оршдог. Энэ бол маш чухал аюулгүйн цорго юм: сонгодог либералчууд шаргуу ятгадагчлан хувь хүмүүс бусдын, бүр олонд маш таалагддаг төр засгийн дур зоргын шийдвэрт захирагдах ёсгүй ажээ.

31 *consent of the public*

# ДОЛООДУГААР БҮЛЭГ:
# Сонгодог Либерал Нийгэм

Нэгэнт сонгодог либералчууд засгийн газрын эрх мэдэлд сэжиглэнгүй ханддаг тул тэднээс нийгмийг хэрхэн зохион байгуулах хэрэгтэй гэж асуух нь шударга зүйл болно. Үнэндээ тэдэнд нийгэм хэрхэн өөрийгөө төвийн захиргааны хэрэгцээгүйгээр өөрийгөө зохион байгуулдаг тухай нэгдмэл цул тайлбар, дурдаж нэрлэвэл өөрөө-тогтдог дэг журмын тухай үзэл бий.

## Өөрөө-тогтдог дэг журам

*Өөрөө-тогтдог дэг журам* бол эртний үзэл санаа юм. Энэ мэдээжээр өөрийн-тусыг боддог хувь хүмүүс хэрхэн зориогүй байж бүх нийтэд ашиг тустай нийгмийн дэг журам үүсгэх боломжтой болохыг тайлбарласан Франц философич Монтескю (1689–1755 он) рүү ч хүрч очих болно; Шотландын Гэгээрлийн эриний эрдэмтэн Адам Фергүсон (1723–1816 он) нийгмийн институцийг 'хүмүүний төлөвлөсөн бодлын биш харин хүмүүний үйлдлийн үр дагавар' гэж ярьж байжээ – энэ үзэл санаа бол Адам Смитийн дүрсэлж тайлбарласан 'үл үзэгдэх гар'-ын санаа юм.

Саяхан Хаек энэхүү үзэл санааг илүү сайжруулжээ. Тэрбээр бид нар ертөнцийг *байгалийн* болон *хиймэл* гэж, *байгалийн* зүйлийг зэрлэг, иррационал, бүтэцгүй, эмх цэгцгүй харин *хиймэл* зүйлсийг төлөвлөсөн, рационал, дотоод бүтэцтэй, аргазүйжсэн гэж төсөөлөн хуваах ерөнхий хандлагатай гэж, мөн сүүлд дурдсаныг нь илүү хүсүүштэй зүйл гэж зүгээр л таамагладаг гэдгийг тэмдэглэн хэлсэн байдаг.

Гэвч Хаекийн хэлснээр төлөвлөөгүй эсвэл албадмал байдлаар үүсгээгүй ч дэг журамжсан байдаг юмсын өөр нэг төрөл буюу категори байдаг ажээ. Жишээ нь V-хэлбэр бүхий хошуу жагсаал үүсгэж нүүж яваа нугаснууд эсвэл зөгий эсвэл термит[1]ийн нарийн

1 *termites*

нийлмэл бүл байна. Эдгээр бүлийн бүтэц түүнд оролцож буй амьтдын ухамсартайгаар зохиомжлоогүй зүйл боловч эдгээр нь энэ амьтдын хувь хувийнх нь зан араншны дэг журамжсан үр дагавар байдаг.

Иймэрхүү өөрөө-тогтдог дэг журам хүмүүний нийгмээс бас л олддог байна. Жишээлбэл бидний *хэл яриа* билээ: бидний нарийн нийлмэл хэл, хэлний дүрмийг хэзээ ч хэн нэгэн албадмал байдлаар зохиомжилсонгүй ээ, энэ нь зүгээр л хэрэгтэй байсан учраас ургаж гарсан. (Пан Европын хэл гэж зориудаар зохиосон Эсперанто хэл олонд алдартай хэзээ ч болоогүй байхад Европын бусад өөрөө-үүссэн хэл одоо ч хөгжсөөр байгаа нь сонирхолтой.)

Үүнтэй адилаар *нийтийн хуул*[2]ийг Наполеоны хуульзүйн код[3] адилаар зорилготойгоор хэзээ ч бүтээгээгүй; энэ нь мянга мянга хувь тохиолдлыг шийдсэн шийдвэрээс зүгээр л үүсэж гарчээ. *Зах зээл*, *үнэ*, *мөнгө* мөн л тэдгээрийг хэн нэгэн хүн ухамсартайгаар зохион бүтээгээгүй харин эдгээр нь ашигтай байсан учраас л үүсэж хөгжсөн.

Үүнээс гарах дүгнэлт бол нийгмийн дэг журам ажилладаг, үр ашигтай, эсвэл бүр рационал буюу ухаалаг байхын тулд түүнд засгийн газар, эсвэл төлөвлөлт хэрэггүй гэх санаа юм. Ийм дэг журам нэг бүр нь өөрийн зорилгодоо хүрэхээр тэмүүлдэг ч бусдын эрх, эрх чөлөөг дээдэлдэг, хувь хүмүүсийн чөлөөт харилцаанаас үүсэж гардаг. Үнэндээ засгийн газрын интервенц буюу хөндлөнгөөс оролцох оролцоо л энэ дэг журмыг үймээн самуун болгож хувиргадаг.

### *Өөрөө-тогтдог дэг журмын хувьсал хөгжил*

Өөрөө-тогтдог дэг журам *хувьсаж хөгждөг*. Хэл, нийтийн хууль,

---

*2 common law*

*3 legal code of Napoleon-1804 оны 3-р сарын 21-нд хэрэгжиж эхлэсэн, Францын Иргэний Багц Хуулиар Ромын эриний хойш хуулийг дахин-зохион байгуулалтад оруулсан явдал байжээ. Энэ хуулийг 1807 онд Напеолоны Багц Хууль өөрчилж нэрлэсэн бөгөөд түүнд голчлон өмч, гэр бүлд анхаарал хандуулсан байв. Гэвч энэ хууль хүмүүсийн амьдралд маш ихээр нөлөөлсөн.*

ёс суртахуун, уламжлал, зах зээл бүгдээрээ л өөрчлөгдөж, тухайн цагийн үеийнхээ хэрэгцээнд нийцэж таарна. Иймэрхүү дэг журмыг өөрийгөө-зохион байгуулдаг, ерөнхийдөө өөрийгөө-зохицуулдаг гэдэг – тэдгээрийг сайн ажилладаг байлгахын тулд хэдхэн өргөн хүрээтэй ерөнхий ёс журам л шаардлагатай боловч түүнийг хэн нэгэн хүн төлөвлөж бодох, бас төлөвлөх хэрэгцээ байхгүй.

Өөрөө-тогтдог эдгээр дэг журмыг бүх цаг үед төгс байдлаар хүлээн зөвшөөрдөггүй байдаг байж болох ч гэлээ сайнаар хүлээн авч өөриймшүүлсэн нэгэн нь л тэсэж үлдэж, бусдаасаа илүү хөгжиж цэцэглэх болно. Энэхүү алдаа-оноотой хувьсал хөгжлийн үйл явц зөвхөн засаг захиргааны санаа л давамгайлдаг байхаас илүүтэй хувь хүмүүс санаагаа олноор нь гаргадаг байхад хамаагүй хурдан байх болно.

Жишээлбэл өөр өөр галт тэрэг, ондоо ондоо гарах хаалга, олон олон орох хаалга руу бүгд яарсан, чөлөөт завгүй галт тэрэгний буудал дахь хүмүүст анхаарал хандуулцгаая. Ямар нэг байдлаар л хүн бүр зорьсон газартаа нэг нэгэнтэйгээ мөргөлдөхгүйгээр хүрэх болно. Энэ байдал хүн бүр л явах чиглэлээ бусад хүн ч бас өөрийн замаар явж гэдгийг тооцоолон тохируулж яваа учраас л гарч байгаа билээ. Орох хаалгаас галт тэрэг хүртэлхи тэд нарын гаргаж болох замнал шулуун зурааснаас хамаагүй өөр байж болох ч ерөнхийдөө тэд хүрэх газраа хурдан саадгүй очдог. Үүний өөр нэг хувилбар болох энэ мянга мянган хүнээс тэдний очих газрыг нь асууж чиглүүлэх, дараагаар нь тухайн буудлын дундуур явах хамгийн үр ашигтай гэсэн замналыг нь гаргаж өгөх явдал бол менежментийн хар дарсан зүүд байх болно. Гэвч энэ хүндрэл бэрхшээл аз болоход өөрөө нилээд өөрөө-тогтсон байдлаар шийдвэрлэгддэг билээ.

## *Ёс журам ба Дэг журам*

Дээр дүрсэлж тайлбарласан асуудал бид бусад хүмүүстэй, галт тэрэгний буудлын жишээнд мөргөлдөхөөс сэргийлэхийн тулд бид чиглэж яваа чигээ чимээгүйхэн илэрхийлж, бас бусад хүмүүсийн илэрхийлсэн чиг өөрсдийгөө нийцүүлэхийг оролдож урьдаас таамаглахуйц байдлаар зохицдог учраас өөрөө шийдвэрлэгддэг.

Иймэрхүү зан араншний зүй тогтол[4], эсвэл ‘зан үйлийн ёс журм[5]аас өөрөө-тогтдог, үр өгөөжтэй үр дүн бий болно. Хэрэв үүнийг эсрэгээр бид бүгдээрээ урьдаас таамаглах аргагүй зан авир үйл хөдлөл хийвэл үүнээс зөвхөн үл ойлголцол, зөрчилдөөн л бий болох болно.

Бодит ертөнцийн өөрөө-тогтдог дэг журамд эдгээр ‘ёс журм’-ыг бичгээр буулгаа ч үгүй, мөн тэдгээр нь маш нарийн нийлмэл байж ч болно. Жишээлбэл зөгийд бичиг үсэг эсвэл тушаал дамжуулах бүтэц байхгүй ч гэлээ тэдгээр зөгий 50 000-уулаа эсвэл зүгээр л хувь зөгий бүрийн ажлаар л бүтэцжсэн бүлээрээ сүрэглэн амьдардаг.

Хүмүүний дэг журмын хувьд сургуулийн хүүхдүүд ч гэсэн хэдий бид зөнгөөрөө л өдөр бүр ярьдаг ч тухайн хэл тогтдог хэлзүйн дүрм[6]ийг дүрсэлж тайлбарлах маш хэцүү зүйл болохыг ухаарцгаах болно. Үүнтэй адил зүйл шударга ёсны ёс журам[7], эсвэл шударга өрсөлдөөн[8], эсвэл ёс суртахуунт байдалд бий; бид хэдийгээр бүр хууль гэж юу болохыг үргэлж тайлбарлаж чадахгүй ч гэсэн ёс журам зөрчихдөө хуулийг биеэрээ мэдрэх боломжтой.

Гэвч эдгээр дэг журмыг-дэмжимтгий ёс журам бид түүнийг ухамсартайгаар зохиомжилж гаргасан учраас биш харин эдгээр нь хэрэгтэй, [бидний хэрэгцээнд] нийцэж таарамтгай байсан учраас л хувьсаж хөгждөг. Тэдгээр ёс журам бидний үйлдэлд сайн дурын хязгаарлалт тавьдаг, бидний үйлдлийг илүү таамаглахуйц болгон, ингэхдээ нийгмийн амьдралыг хялбар болгоно. Өмчийн эрх, уламжлал, заншил, ёс суртахуун, шударга байдал, хүндлэл, дадал зуршил зэрэг ёс журам бол хувь эрх чөлөөний цучил бүхий зуух ажээ. Хэн ч тэдгээрийг *зохион бүтээгээгүй* боловч тэдгээр ёс журам нийгмийн жигд тогтуун харилцааг дэмжихийн тулд хэрхэн үйл хийж авирлах талаархи далд ухамсарын “цэцэн ухаан”-ыг агуулдаг.

---

4 *behavioural regularities*
5 *rules of conduct*
6 *rules of grammar*
7 *the rules of justice*
8 *fair play*

## Шударга ёс, хууль ёс

Өөрөө-тогтдог дэг журам тэгвэл хувь хүний урьдаас таамаглах боломжтой зан төлөвд тулгуурлах бөгөөд энэ нь ийм зан төлөв байхгүй бол орших боломжгүй. Бидний нийгмийн болон улстөрийн дэг журмын үндэс суурь сонгодог либералчуудын хэлэхээр *шударга ёсны ёс журам*[9] ажээ.

Хэл зүйл дүрэм адилаар шударга ёсны ёс журмыг ухамсартайгаар зохиомжилж гаргаагүй ч гэлээ хэрэгтэй учраас л хувьсаж хөгжиж иржээ; хэдий бүр бид энэ нь юу болох талаар нарийн тодорхой үргэлж тайлбарлаж чаддаггүй ч гэлээ илүү өргөн хүрээнд тэдгээр ёс журмыг дагаж мөрддөг. Мэдээжээр бид тэдгээрийг бичиж буулгахыг, хуулийн номд эдгээрийг зүйтогтолтой хууль болгож эмхлэх[10]ийг оролддог. Гэвч энэ байдал нь бид шударга ёсны ёс журмыг *бүтээж байгаа* явдал биш; энэ бол тэдгээр ёс журам чухам юу болохыг нь *олж мэдэх* гэж бид оролдож буй нь тэр юм.

Хууль тогтоогч ‘хууль’ батлах боломжтой ч гэсэн тэр нь зүгээр хууль ч биш байж болно. Жишээлбэл эдгээр нь *буцаан хэрэглэх шинжтэй* (тухайн цагаа гэмт хэрэг биш байсан үйлдэлд нь хүмүүсийг шийтгэх), эсвэл *хэрэгжих аргагүй* (дагаж мөрдөх боломжгүй), эсвэл ойлгомжгүй (дотоод зөрчилтэй эсвэл ухаарч ойлгоход хэт нарийн), эсвэл тэдгээрийг *шударга бусаар албадан хэрэгжүүлдэг*[11] байж болно – энэ бүгд нь бидэнтэй хамт үүсэж хөгждөг шударга ёсны үзлийг, эсвэл зарим нэг сонгодог либералчуудын хэлдэг *жам ёсны хуул*ийг гутааж доромжилдог зүйл юм. Иймэрхүү хууль тогтоох явцын тогтоол шийдвэрийн зүйлд тиймээс “хууль” гэсэн нэр зохихгүй.

### *Хууль ёс*

Сонгодог либералчууд өөрөө-тогтдог, хамтран ажиллууламтгай, урьдаас таамаглахуйц, хүчирхийлэл үгүй, тогтвортой, нийгмийн

9 *rule of justice*
10 *codify-зүй тогтолтой багц хууль болгож эмхлэх*
11 *unfairly enforced*

шударга дэг журам зөвхөн *нийтээрээ-дагадаг*[12] (өргөн олныг ялгаварлаж хохироодоггүй), *универсал*[13] (хүнд бүрд хэрэглэдэг), *тогтвортой* (хүмүүс аль нь юу болохыг мэдэхгүй төөрч будлихаар байнга өөрчлөгддөггүй) ёс журмыг дагаж мөрдсөнөөр бий болдог гэдэгт итгэдэг.

Нэгэнт бидний ихэнхи нийгмийн амьдралын ёс журмыг ойлгох нь битгий хэл хэлзүйн дүрм[14]ийг тайлбарлаж чадахгүй тул аливаа зүйлийг энгийн байлгах нь дээр билээ. *Нийтээр-дагадаг*, *тогтвортой* ёс журамтай байх явдал нь хүн бүр л түүнээс юу хүлээхийг мэддэг болж, бидний үйлдлийг улам л таамаглахуйц болгож, нилээд итгэлтэйгээр төлөвлөгөө гаргах боломж бидэнд олгоно гэсэн үг юм. Тиймээс л *универсал буюу хүн бүрд хэрэглэдэг* ёс журам тодорхой хүмүүс эсвэл бүлэг хүмүүст таатай хандах эсвэл тэднийг мөлжиж ашиглах явдлыг боломжгүй болгож улам л маш чухал давуу талтай байдаг.

Энэ бол засаг захиргаанаас гаргадаг дур зоргын ёс журмаас ялгаатай *хууль ёс* юм[15]. Сонгодог либералчууд хууль ёс улстөрчид, цагдаа, шүүх, бусад албан тушаалтан албадлагынхаа эрх мэдлийг буруугаар ашиглахаас сэргийлдэг гэдгийг хэлдэг. Хууль ёс биднийг дараахь олон гай зовлонгоос хамгаалж авардаг. Үүнд: дур зоргын баривчилгаа, шүүхийн шийдвэргүйгээр шоронд хорих, давхар яллаж шийтгэхээр оролдох[16] (нэг гэмт хэрэгт олон удаа шүүх), шударга бус шүүх, урьдаас тогтчихсон бодлоор шүүх, дүр эсгэсэн сонгууль, шударга бусаар хууль тогтоох зэргээс сэргийлэх багтана.

## *Хууль ёсыг хамгаалах*

Хэдийгээр сонгодог либералчууд *хязгаарлагдмал-эрх мэдэлтэй* засгийн газарт итгэдэг ч тэд нар хууль ёсыг сахин хамгаалах

---

*12 general*

*13 universal-*

*14 Б. Ринчен гуай үг бүтэх ёсоо дагаж хэлний-зүйн гэж бичвэл дээр гэсэн байдаг.*

*15 This is the rule of law, in contrast to the arbitrary rule of those in authority.*

*16 double jeopardy*

явдлыг ач холбогдол *багатай* гэж үздэггүй. Хууль ёс сонгууль болон томилгоо нээлттэй, шударга байх, шүүгч бие даасан байдалтай байх, мөн хуулийг нийтээр-дагадаг байдал, хүн бүрд хэрэглэдэг байдлыг нарийн чанд баталгаажуулах механизмтай байхыг шаарддаг. Түүнд нь шүүх тогтолцоонд зориулсан нөөц баялаг шаардлагатай: жишээлбэл хэрэв шүүхийн захиргаадалтын явц[17] хэт ачаалартайгаас болж хэргийг шүүхээр оруулахад хэдэн жил болж байгаа бол, эсвэл цагдаа болон шүүгч оронд нь авилга авахад л найдахаас аргагүй маш муу цалинтай бол шударга ёс хангагдахгүй.

*Үндсэн хууль* энэхүү жам ёсны шударга ёс[18]ыг хамгаалахад туслах боломжтой: эрх тэгш хандах явдлыг баталгаажуулахын тулд үндсэн хуульд хуульзүйн тогтолцооны зохистой арга ажиллагаа[19]г зааж суулгах боломжтой; үндсэн хуульд *хувийн оронзай*г хууль тогтоох явцын тогтоол шийдвэр болон албан тушаалтан хэзээ ч дайрч орж чадахгүй байхаар тогтоож өгөх боломжтой. *Нийтийн хуул*ийн уламжлал бол эрх чөлөөний өөр нэг цайз ажээ: хувь хэрэг тохиолдол бүрийг нийтэд дамжуулж, шүүхээр авч үздэг бөгөөд үүнээс нь бид шударга ёсны ёс журам юу болох талаар ухаарац мэдлэгтэй болдог. Гуравдахь хамгаалалт нь *үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө*[20] юм: хэрэв хүмүүс хууль тогтоох явц эсвэл тогтоол шийдвэр, шүүхийн захиргааг нээлттэй шүүмжилдэг бол илүү их бодол санаа хууль тогтоох явц руу орж, хүмүүс ч шударга бус тогтоол шийдвэр, хуульзүйн шударга бус үйл ажиллагааг идэвхитэй эсэргүүцэж няцаах боломжтой байна.

## *Хууль ёсонд учрах аюул занал*

Энэ байдал бүгдээрээ өнөөдрийн олон хууль тогтоогчдын бодлоос хамаагүй хол зүйл ажээ. Тэд нар өөрсдийнх нь хэлэхээр шүүгчдийг бодвол олон нийтийн асуудлыг илүү өөртөө ойр хүлээж авдаг, сонгогдсон олонхид шүүхийг захируулахыг хүсдэг. Тэд нар үндсэн

*17 court bureaucracy*
*18 natural justice*
*19 due process*
*20 free speech-свобода слова*

хуулийн хязгаарлалтыг өөрсдийгөө үндсэн хуулийг хэдэн арван жил эсвэл хэдэн зуун жилийн өмнө бичигсдээс илүү сайнаар өнөөдрийн нөхцөлийг ухаж ойлгож байна батлан өгүүлж үл хэрэгсэнэ. Тэд нар эрхийг жам ёсны, салшгүй зүйл гэж харж ойлгодоггүй харин хууль тогтоох байгууллага давуу эрх байдлаар бидэнд баталгаажуулж олгосон гэж зүйл гэж ойлгодог. Тэд нар хууль тогтоох явцаар эсвэл тогтоол шийдвэр[21]ээр "олон нийтийн сайн сайхан"-ыг бүр хувь хүний эрх чөлөөт байдлыг золиослоод ч гэсэн дэмжих ёстой гэдэгт итгэдэг.

Гэвч бараг бүх аливаа тогтоол шийдвэрийг хэдий шударга бус, албадсан шинжтэй байсан ч "нийтийн сайн сайхан"-ы үндэслэлээр өршөөж дагах боломжтой байдаг – энэ "сайн сайхан"-ыг гарцаагүй хууль тогтоогчид өөрсдөө тодорхойлно. Бүр мэдэхийн дээдээр сонгодог либералчууд шүүхийг хууль тогтоогчдын богино-хугацаанд гарах ашиг болон тооцоот шунахай ашиг сонирхл[22]ыг шалгаж нягталж, мөн шударга бус тогтоол шийдвэрийг эсэргүүцэж няцаан, харин шударга хуулийг бүр эрх мэдэлд байгаа хүн ч гэсэн дагаж мөрдөх явдлыг баталгаажуулагч, хувь хүний эрх, эрх чөлөө амин чухал хамгаалагч гэж хардаг ойлгодог.

Энэхүү учир шалтгааны улмаас Хаек шүүх дээр маргааныг мэтгэлцэж нотлох замаар ургаж хөгжсөн нийтийн хууль улстөрчдийн баталсан хуулийг бодвол шударга ёсны илүү сайн хамгаалагч гэж түүний төлөө хүчтэй маргалдаж мэтгэлцэж байсан – бараг бүх сонгодог либералчууд үүнтэй санал нийлэх болно. Тэд нар хуульзүйн ёс журм[23]ыг шударгаар, хүн бүрд нэгэн ижил хэрэг ёстой гэдгийг шаарддаг. Нийтийн хууль ерөнхийдөө энэхүү тайлбар тодорхойлолтод нийцдэг бол харин улстөрчдийн гаргасан хуулийг дэндүү их тодорхой бүлэг хүнд таатай (эсвэл таатай бус)-

---

21 *legislation-энэ үг хоёр гурван янзаар монгол хэлэнд буух боломжтой бөгөөд энд хууль тогтоох явц, тогтоол шийдвэр гэсэн утгаар буулгаж болох тул ийн хоёр янзаар зарим газарт бичлээ.*

22 *checking the short-termism and vested interests of the legislators*

23 *legal rules-би эрхзүй гэдгийг оросын правоведение гэсэн үгнээс гарсан буруу орчуулга гэж боддог. Оросууд үүнийгээ английн rights гэдгээс орчуулсан болов уу.*

гаар зохиомжилсон байдаг – энэ байдал бол яагаад сонгодог либералчууд иймэрхүү тогтоол шийдвэрийг маш сэжиглэж түүнд таагүй ханддагийн нэг шалтгаан юм.

## Жам ёсны дэг журмын рационал байдал

Хэдий олон хүн төвийн удирдлага зааваргүй нийгэм зэрлэг балмад, иррационал буюу ухаалаг бус байна гэж төсөөлдөг ч гэлээ сонгодог либералчууд өөрөө-тогтдог дэг журам үнэндээ хамаагүй илүү рационал буюу ухаалаг зүйл гэдэгт итгэцгээдэг. Эдгээр дэг журам төвлөрсөн удирдлагатай нийгмийг бодвол мэдээлэл боловсруулах, илүү сайн ашиглах боломжтой байдаг нь илүү сайн шийдвэр гаргах, өөрчлөгдөж буй нөхцөл байдал хурдан зохицож тохирох, илүү хурдан хөгжиж цэцэглэх явдалд хөтлөн хүргэнэ. (Жишээ болгож хуучны, төвлөрсөн байдлаар удирддаг байсан Зөвлөлтийн Блок[24]ийн эдийн засгийн хоцрогдлыг арай бага төвлөрсөн байдалтай байгаа Өрнөдийн хөршүүдтэй нь харьцуулж эргэн санацгаая.)

Үүний учир шалтгаан бодол санааны энэ чиг шугамыг нарийвчлан гаргасан Ф. А. Хаекийнхаар бол нийгмийн хөгжил дэвшил хамаардаг мэдлэгийн ихэнхи нь *сарниж тархсан мэдлэг*[25] байдаг явдал ажээ. Энэ мэдлэг хэсэг газарт тархамтгай, хэсэгчилж хуваагдсан, хэсэг хэсгээрээ л байдаг бөгөөд түүнийг төвлөрүүлэх боломжгүй.

Жирийн хүмүүс төвийн засаг захиргаа буюу эрх мэдэлтний чадахаас ч хамаагүй сайн өөрийнхөө нөхцөл байдлыг ухаж ойлгодог. Тэд нар мөн мэргэжилтний ур чадвартай, өөрийнхөө зах зээл, үйлчлүүлэгчдийнхээ хэрэгцээ, үнэ цэнийн талаар илүү хувийн шинжтэй ухаарац мэдлэгтэй байдаг ажээ. Зах зээлийн өөрчлөгдөж буй мэдээллийн ихэнхи нь бүр түүнийг төвийн төлөвлөлтийн зарим нэг байгууллага руу дамжуулж амжихаас ч өмнө хуучирчихдаг.

Зарим нь Үббер[26] зэрэг програм болон орчин үеийн сүперкомпьютер тодорхой цаг хугацаа, газрын байршил дахь таксины савлаж буй эрэлт болон бэлэн яваа таксины тоо зэрэг

---

*24 Soviet bloc,*

*25 dispersed knowledge*

*26 Ubber*

зах зээлийн хурдтай өөрчлөгдөж буй өгөгдлийг цуглуулах боловсруулах явдлыг боломжой болгосон гэж батлан өгүүлж болох юм. Мэдээллийг үр дүнтэй цуглуулах, ашиглах хэмжих хуваарь хугацаанаас хамаарч, хэрэглээ хэрэглээнд өөрчлөгдөх болно гэдэг нь үнэн билээ. Гэвч өрсөлдөөний үйл явц л өгөгдсөн бэлэн байгаа технологийг ашиглаж мэдээлэл цуглуулах, тайлж тайлбарлах, хэрэглэх хамгийн сайн арга замыг олж нээхэд шаардлагатай. Энэхүү мэдээллийг энэ үйл явцын гинжин хэлхээнд, өөр өөр арга замаар ондоо ондоо хүн, Үббер эсвэл такси компани, жолооч, үйлчлүүлэгч боловсруулж ашигладаг. Төвлөрсөн төлөвлөлт зүгээр л үүнийг давтаж ч дуурайж ч эс чадна.

Аливаа үйл явдлын асуудал нь *тооцоолох явдал*д бус харин *ухаж ойлгох л явдал*д бий. Энэ өгөгдлийг мэдээжээр засгийн газрын төвийн засаг захиргаа илүү сайн боловсруулна гэж байхгүй. Ямар ч засгийн газрын захиргааны байгууллага таксины хэрэглэгчийн хэрэгцээг урьдаас таамаглах боломжгүй (энэ нь гэр бүлд нь гарсан чухал ажил, цаг агаар эсвэл олон нийтийн тээврийн хэрэгсэл хугацаанаас хоцрох зэргээс болж байнга өөрчлөгдөж байдаг). Бас төвийн төлөвлөгч таксины жолоочийн л адил орон нутгийн цаг агаар, автозам түр хаагдсан газар, түүнийг тойрох зам, олон хүн цуглуулах орон нутгийн шинжтэй үйл явдал, уг зах зээл нөлөөлөх боломжтой тоо томшгүй олон хүч зүйлийн талаар тэр хэрийн мэдлэгтэй байдаг гэж бодож байж болох юм.

Мөн орон нутгийн нийлүүлэгчид төвийн төлөвлөгчөөс илүү орон нутгийнхаа эрэлтэд дасан зохицох хамаагүй илүү шуурхай сонирхолтой байдаг. Тэд нарын сэдэл л хөгжил дэвшлийг хөдөлгөнө: мянга мянган нийлүүлэгч бүгдээрээ бизнесийнхээ төлөө өрсөлдөхөд гарах шинэчлэл нь түүнийг төвийн нэг байгууллагад хариуцуулснаас илүү хурдан байх болно. Шинэчлэлийг хувь хүмүүс хийх нь илүү дээр байдаг: хэрэв тэд нарын шинэчлэл ажиллахгүй бол тэд зөвхөн дунд зэргийн, хэсэгхэн л алдагдалд орох болно; төвийн төвлөрсөн төлөвлөлтийн агентлагийн үндэстэн дамнасан шинэчлэл нь нийт эдийн засгийг сүйрүүлэх эрсдэлтэй байдаг.

Энэ байдал бол өөрөө-тогтдог нийгэм төлөвлөлтгүй гэсэн үг

биш юм: үүнээс ялгаатай нь ийм нийгэм төлөвлөлтийн зарим нэг ганц байгууллагад биш харин хүн бүр нь өөрийн гэсэн мэргэжилтний мэдлэгтэй байдаг, сая сая хувь хүний төлөвлөгөөнд тулгуурладаг. Асар их хэмжээний сарниж тархсан, салангид тусдаа мэдлэгт үндэслэсэн ийм нийгэм ямар ч төвлөрсөн ухаан хэзээ нэгтээ ойлгож ухаарч чадахаас ч хамаагүй нийлмэл зүйл байдаг. Энэ байдал зарим талаар сонгодог либералчуудын төр засгийн эрх мэдэлд, ялангуяа нийгмийг бүхэлд нь дахин зохиомжлох гэсэн оролдлогод сэжиглэнгүй ханддагийг тайлбар болно. Хэрэв нийгмийнхээ институцийг бүрэн гүйцэт ухаж ойлгож чадахгүй тул бид тэдгээрийг ямар нэг байдлаар амжилттай дахин зохиомжилж чадахгүй нь илэрхий зүйл юм.

## Иргэний нийгэм

Сонгодог либералчууд өөрөө-тогтдог нийгмийг бүрдүүлж буй хүмүүсийг тусгаарлагдмал ганцаардсан, *ганц нэгээрээ амьдардаг* хувь хүмүүс[27] (хэдий энэ байдлын талаархи сэжүүр нийгмийн гэрээний эртний онолчдын дунд байсан, мөн харьцангуй саяхан эдийн засагчдын рационал хүлээлт, мөн рационал, өөрийн-тусыг бодсон хомо экономикус[28]ийн талаархи төсөөлөлд гарсан ч гэсэн) гэж төсөөлж боддоггүй. Тэд нар бодит ертөнцийн хүмүүсийг хоорондоо салчихсан, механик эд биш гэдгийг мэддэг.

Үүнээс илүүтэйгээр хийсэн сонголт эсвэл төрсөн орчноосоо болоод хувь хүмүүс өөр өөр гэр бүл, ёс суртахуун, шашин, соёл, үнэнч байх бусад хамааралтай өөр өөр, хоорондоо давхацдаг бүлгийн гишүүн байдаг. Тэдний үнэт зүйл эдгээр үнэнч байх хамааралтай байдл[29]ын нөлөөнд автсан байдаг бөгөөд тэд нар нутаг нэгтэн буюу хамаарал бүхий гишүүдийнхээ харилцан үнэнч байдалд итгэж найдна. Тэд нар улстөрийн үйл явцаар гэхээсээ илүүтэй *иргэний нийгм*ийн эдгээр институцээр дамжуулан алсын бодлоо хөөж явдаг

27 *atomistic individuals*
28 *homo economicus*
29 *allegiances*

– эдгээр институц нь буяны байгууллага[30], холбоо, өөртөө-туслах бүлгэм, кампанит ажил, шашин, бусад бүлгэм байна.

Коммунистууд болон фашистууд иргэний нийгэм хүмүүсийн үнэнч байдлыг төрөөс холдуулдаг гэж хардаг учраас иргэний нийгэмд хамгийн их шүүмжлэлтэй ханддаг. Сонгодог либералчууд үүнтэй яг адилхан учир шалтгаанаар иргэний нийгмийн санааг таашаан дэмждэг ажээ. Тэдний хувьд иргэний нийгэм нь хувь хүнийг өөрийн зорилгодоо хүчирхэг, төвлөрсөн улстөрийн засаг захиргаанд захирагдахгүйгээр зорьж тэмүүлэх боломж олгодог. Үнэндээ өөр өөр хүмүүс олонхийн зарим нэг үзэл санаанд зориулж алсын бодл[31]оо золиослохгүйгээр харилцан зөрчилдсөн зорилгод хүрэхээр тэмүүлэх боломжтой. Цаашилбал хэрэв иргэний нийгэм нь хүчтэй бол төр засаг нэмэлт эрх мэдэл авах явдлыг бага л өршөөх болно. Идэвхитэй буяны хандив өргөдөг сектор жишээлбэл төрийн халамжийн тогтолцоог бий болгох хэрэгцээг бага л гаргана гэсэн үг юм – сонгодог либералчууд төвлөрсөн эрх мэдэл өснө, түүнийг буруугаар ашиглах болно гэж айдаг эмээдэг учраас энэ нь тэдний сэтгэлийг амраадаг. Аливаа ажлыг орон нутаг буюу тухайн газар нь янз бүрийн арга замаар хийх нь алс холын, төвлөрсөн засаг захиргаа хийхээс илүү ухаалаг буюу рационал зүйл билээ.

Зарим нэг сонгодог либералчууд бидний хэтэрсэн төвлөрсөн байдлын аюулаар зөвхөн тогтохгүй бас хэтэрсэн индивидуализмийн аюулаас хамгаалах гэж иргэний нийгмийг таашаацгаадаг. Жишээлбэл Францын улстөрийн сэтгэгч, түүхч Алекс де Токвилл (1805–59 он) Америкийн индивидуализмийг төрийн эрх мэдлээр хамгаалуулсан, өргөн олны эзэрхэг байдал гарах боломж үүсгэж, иргэний сайн үйлс, биеэ барьж тэвчих явдл[32]ыг боомилж байна гэж шүүмжилж байжээ.

## Өөрөө-тогтдог дэг журам, жам ёсны эрх

Өөрөө-тогтдог дэг журам болон жам ёсны эрхийн тухай үзлийн

*30 charities*
*31 ambition*
*32 civic virtue and restraint*

зөрчлийг тэмдэглэж хэлэх нь хэрэгтэй зүйл байж болох юм. Хэрэв нийгэм өөрөө-тогтох байдлаар үүсэж хөгждөг юм бол түүнийг тайлбарлахад тусгаарлагдмал ганцаардсан, чөлөөт хувь хүмүүсийн хооронд ямар ч нийгмийн гэрээ хэрэгцээгүй гэх болно. Өөрөө-тогтдог нийгэм рационал хэлэлцээрийн үр дагавар биш ч харин нэг нэгнийхээ үйлдлийг хүлээн зөвшөөрч буй хувь хүмүүсийн бүхэлдээ зориогүй, эволюцийн шинжтэй үр дагавар байдаг.

Сонгодог либералчуудын олных нь хувьд өөртөө-тогтдог дэг журам нь нийгмийн асуудалд хандах жам ёсны эрхийн хандлагыг бодвол арай бага радикал буюу арай аядуу, илүү консерватив хандлага санал болгодог байна. Жам ёсны эрхийн үзэл санааны шүүмжлэлийн нэг бол нэгэнт жам ёсны эрхээ харамлаж хамгаалж буй, тусдаа ялгарах хувь хүмүүс ерөөсөө төр засагт үнэндээ ямар үүрэг ногдуулахаар санал нэгдэхгүй нь бараг үнэн тул үүнээс бараг анархи байдалд дөхсөн ямар нэг зүйл үүсэх боломжтой гэсэн санаа юм. Өөрөө-тогтдог дэг журмын хандлага үүнээс ялгаатай нь бид хэрэв бүр бидний санал нэгдэх явдал ухамсартай бус, түүнийг нь ховорхон л ухаарч мэддэг байсан ч асар олон зүйлийн талаар санал нэгдэх боломжтой, санал нэгддэг гэдгийг сануулдаг.

# НАЙМДУГААР БҮЛЭГ: Сонгодог Либерал Эдийн Засгийн Ухаан

## Зах зээлийн өөрөө-тогтдог дэг журам

Нийгэм болон улстөрийн эрх чөлөөний хамтаар сонгодог либералчууд мөн эдийн засгийн эрх чөлөөг өмгөөлж хамгаалдаг ажээ. Тэд хүмүүс чөлөөтэй юм зохион бүтээх, бүтээж хийх, хадгалж хураах, хөрөнгө хуримтлуулах, бусадтай сайн дураараа эд зүйлээ солилцох ёстой гэдэгт итгэцгээдэг.

Гэвч тэд нар мөн эдийн засгийн эрх чөлөө бол нийт олныг хөгжүүлж дэвжүүлэх хамгийн сайн арга зам юм гэдэгт итгэнэ. Эдийн засгийн эрх чөлөө хөгжил дэвшилд үнэ цэнэ бүтээн, тархаан хүмүүст нэг нэгнийхээ хэрэгцээнд өөрөө-тогтдог байдлаар зохицож таарах, харилцан ашигтайгаар хамтран ажиллах боломж олгодог учраас тэр ажээ.

Энэхүү тодорхой өөрөө-тогтдог дэг журмыг бий болгодог ёс журам бол өмч, гэрээ, шударга байдал[1], шударга ёс[2] юм. Тэдгээрийн дундаас аливаа ухамсартай бүтэц ойлгож чадахаас ч хамаагүй том, илүү нийлмэл, бүх дэлхийг хамарсан ухаарахын аргагүй хэмжээтэй, нарийн нийлмэл эдийн засгийн дэг журам бий болно.

## Үнийн өөрөө-тогтдог шинжтэй ‘гайхамшиг’

Олон сая хүмүүсийн эдийн засгийн үйл ажиллагааг ийм байдлаар жигд тогтуун гайхалтай тохируулж тааруулдаг зүйл бол Хаекийн үнийн тогтолцооны “гайхамшиг” гэж нэрлэсэн тэр зүйл юм. Бид энэ байдлыг зохион бүтээгээгүй-энэ нь өөрөө-тогтох байдлаар үүсэж гарсан ч гэлээ үнэ цэнийг бүтээж, хөгжил цэцэглэлтийг бүх дэлхийгээр, хүмүүний хүрээлэлд хаа сайгүй түгээх явдлыг өдөөдөг.

1 *honesty*
2 *justice*

Үнэ бол зүгээр л хүмүүс зарим зүйлээ бусад хүмүүстэй солилцохоор хүсэж буй *ханшийн хэмжээ*[3] юм. Ихэвчлэн үнийг мөнгөөр илэрхийлдэг – мөнгө нь бусад зүйлээр солилцох боломжтой хэрэгтэй бараа бүтээгдэхүүн[4] байдлаар үүсэж гарсан учраас тэр ажээ. Милтон Фрийдмэний үгээр бол мөнгө өлсгөлөн үсчин үс засуулах хэрэгтэй байгаа талхчин эрж хайх явдлыг үгүй хийдэг, солилцоог хамаагүй хялбар болгодог байна.

Үнэ нь *үнэ цэн*ийг хэмждэггүй гэдгийг анзаараарай. Гоо сайхны адилаар үнэ цэнэ аливаа зүйлийн эзэмшигчийн ухаанд л оршдог бөгөөд хүмүүс нэг ижил зүйлд өөр өөр үнэ цэнэ өгдөг. Энэ байдал бол яагаад тэд арилжаа хийдэг шалтгаан юм. Өлссөн үсчин талхыг талхчин түүнийгээ зарах үнээс илүү ихээр үнэлдэг бол харин талхчин нь уг талхнаас илүү бэлэн мөнгийг илүү үнэлнэ. Нэг л үнээр солилцоо хийдэг ч солилцоо хийсэн хоёр хүн тус бүрдээ эд зүйлийг өөр өөр үнэлэх бөгөөд хоёулаа л энэ арилжаанаас өөрсдийгөө ашигтай гарсан гэж үзэцгээдэг.

## *Үнэ бол харилцаа холбоо юм*

Гэвч үнэ юм ховордсон байдлыг ил гаргана. Илүү их үнэ хаана эд юмсын эрэлт нийлүүлэлтээ давж буйг, хэрэглэгч илүү их үнэ төлөхөд бэлэн байгааг харуулах боломжтой. Үнэ нь нийлүүлэгчийг тухайн эрэлтийг оронд нь ирэх илүү ашиг олж авахын тулд үйлдвэрлэлээ өсгөж оролцох замаар хангахад өдөөдөг. Буурч буй үнэ үүнтэй адилаар эрэлт сул байгааг, нийлүүлэгч үйлдвэрлэлээ хумьж багасгах хэрэгтэй гэдгийг илэрхийлэх боломжтой. Ийм байдлаар үнэ хаана нөөц баялаг хамгийн их үнэ цэнэ бий болгох боломжтойг илэрхийлж, түүнийг тэр зүг рүү татаж, хэрэгцээгүй, бага үнэ цэнэтэй хэрэглээнээс холдуулна.

Эдгээр ашиг тустай тохируулга нэг зах зээлээс нөгөө зах зээл рүү тэлж тархдаг ажээ. Хаекийн жишээг авахыг тулд аж үйлдвэр эрхлэгч нар цагаантугалганы шинэ хэрэглээг олжээ гэж төсөөлцгөөе. Тэд нар

*3 rate*

*4 medium Мизэс гэсэн байдаг нь бүр оновчтой ажээ*

тэр үед илүү их цагаантугалга шаардах бөгөөд тэд нар ч түүнийг олж авахын тулд илүү их үнэ төлөхөд бэлэн байх болно. Эдгээр их үнэ нь уул уурхайн пүүсийг илүү их цагаантугалга үйлдвэрлэхэд, бөөний худалдаачид үүний ихээр нийлүүлэхэд өдөөдөг. Гэвч ижил тэнцүү байдлаар цагаантугалганы өмнө нь байсан хэрэглэгч одоо арай бага өртөгтэй орлуулах хэрэглэгдэхүүн хайж сурч эхэлнэ. Энэ байдал тэдгээр орлуулах хэрэглэгдэхүүний үнийг өсгөнө – энэ нь эргээд эдгээр орлуулагч бодисын хэрэглэгчийг өөр нэг орлуулагчийг эрж хайхад хүргэнэ. Тохируулгын бүхэл бүтэн гинжин хэлхээ цөөрөм дэх долгио адилаар тэлж тархдаг – бүгдээрээ хүмүүст тэдний хүчин чармайлт болон нөөц баялагийг хаана хэрэглэвэл хамгийн их ашиг гарахыг байнга харуулдаг, Хаекийн үнийн 'өргөн хүрээтэй харилцаа холбооны тогтолцоо' гэж хэлсэн зүйлд талархах болно.

## Тушаал заавargүй зах зээл

Сурах бичгийн зах зээл байнгын тэнцвэрт оршиж байдаг гэж харуулдаг 'тэнцвэрт байдал'-ын диаграмтай адилгүй нь сонгодог либералчууд зах зээлийг уулын гол мэт хэзээ ч нэг байрандаа тогтдоггүй, динамик буюу хөдөлгөөнтэй амьд *үйл явц* гэж хардаг. "Эдийн засаг"-ийг абстракт, механик *тогтолцоо* гэж төсөөлөхийн оронд сонгодог либералчууд зах зээлийн үзэгдлийг хүн бүр нь *өөрийн* гэсэн зорилго, үнэт зүйлтэй хүмүүн төрөлтний сая сая хувь хүмүүсийн байнгын харилцан нийцэж тохирсон үйлдлийн төлөвлөөгүй, урьдаас таамаглаагүй *үр дүн* гэж ойлгодог ажээ.

Эдийн засгийн энэхүү өөрөө-тогтдог дэг журам бусдынхаа адилаар түүнийг бүрдүүлж буй хувь хүмүүсийн дундахь үйл хөдлөл[5]ийн урьдаас таамаглахуйц ёс журмын үр дагавар байна. Энэ үйл хөдлөл өөрийн-тусыг бодох болон олох ашиг тусаар өдөөгддөг боловч түүнийг өрсөлдөөн, гэрээ, өмч, өмчийн эрх, шударга ёс зэрэг хүчин зүйлээр зохицуулдаг – эдгээрийг сонгодог либералчууд төр зах зээлийн дэг журмыг үр өгөөжтэй ажиллуулсаар байхын тулд дэмжих ёстой зарчим гэдэгт итгэдэг.

*5 behaviour*

## Ёс журам ба өмч

Өмчийн эрх энэхүү ашиг тустай дэг журмын ажиллагаанд үндсэн үүрэгтэй байдаг. Баталгаатай өмчлөх эрх бүхий хүмүүс өөрийн өмчийнхөө зүйлсийг илүү их үнэ цэнэ хэлсэн бусадтай солилцох боломжтой – энэ нь хоёр талдаа өгөөжтэй ажээ. Бүр илүү нарийвчилж хэлбэл баталгаатай өмчлөх эрх гэдэг нь хүмүүс үйлдвэрлэж бүтээхдээ сайн зүйл үйлдвэрлээд, бусадтай тэдний хийж бүтээхдээ сайн зүйлээр солилцох боломжтой гэсэн үг юм. Энэ нарийн мэргэжих явдал, эсвэл *хөдөлмөрийн хуваарь буюу хөдөлмөрийн төрөлжилт* бид бүгдийг бүх зүйлийг сонирхогчийн хэмжээнд хийх гэж оролдох явдлаас хамаагүй илүү үр бүтээлч хүмүүс болгодог.

Баталгаатай өмчлөх эрх мөн л хүмүүсийг улам их, илүү хурдан, илүү сайнаар юм үйлдвэрлэх боломжтой багаж тоног төхөөрөмжид хөрөнгө оруулах, *хөрөнгө хурааж хуримтлуулах* бололцоо нээнэ. Өмчлөлийн эрх[6] хүмүүст улстөрийн олонхи тэднийг ашиглаж мөлжих явдлыг эсэргүүцэх боломж олгодог; үнэндээ өмчлөлийн эрх хүмүүст төр засгийн эсрэг ихэмсэг бардам зогсох тэмцэх нөөц баялагийг өгдөг билээ.

### *Өмчийн ёс журам*

Өмчийн эрх[7] хүмүүст өмчөө өөртөө байлгах, хэрэглэх, бусад хүмүүст түүнийгээ хэрэглүүлэхээс татгалзах, түүнээсээ орлого олох (жишээлбэл түүнийгээ түрээсэлж), үүнийгээ бусдад зарах эсвэл бэлэглэх замаар шилжүүлэх боломж олгодог. Энэ эрхийг шүүхийн тогтолцоо албадан хэрэгжүүлнэ.

Гэвч хэн нэгний өмчлөх байдал хуульзүйн дагуу байх[8]ын тулд тухайн өмчийг албадлага хэрэглэлгүйгээр олж авсан байх ёстой. Түүнийг арилжаа эсвэл бэлэг байдлаар олж авсан байх боломжтой. Эсвэл магадгүй өөр хэн ч өмчилдөггүй эсвэл өмчлөхийг хүсдэггүй

---

6 *ownership right*
7 *property right*
8 *legitimate*

хэрэгцээгүй газар зэрэг ямар нэг зүйлийг олж авах замаар авсан байж болно – энэ үйл явц бол бүр шинэ өмчлөгч нь түүнийг ашиглах нь ашигтай болохыг олж мэдсэн байсан ч гэсэн хэнийг хохироодоггүй.

Өмч зөвхөн газар биш байшин, хөдлөх хөрөнгө байдаг. Түүнд хувьцаа, бонд зэрэг нарийн нийлмэл хөдлөх хөрөнгө[9] эсвэл патенталсан хийц загвар, зохиогчийн эрхтэй ая дуу зэрэг оюуны өмч орох боломжтой – үнэндээ өмч бол бид бүгдийн амьдралд байдаг зүйл, эрх чөлөө юм. Өмчийг хувь хүн, байгууллага, засгийн газар өөртөө байлгах боломжтой эсвэл хэн ч (жишээлбэл далайн загас) өмчилдөггүй байх боломжтой - хэдий тийм ч сонгодог либералчууд хувийн өмчийн эзэн засгийн газрын эзэмшигчээс ерөнхийдөө өмчөө илүү сайн удирдаж залдаг гэдэгт, мөн өмчлөгч болохынхоо хувьд өмчөө хэмнэж хадгалж үлддэг гэдэг шиг тийм ашиг сонирхол байдаггүй учраас нөөц баялагийг хэт ихээр хэрэглэдэг "дундын зүйлийн гачлант тавилан"[10] ийм өмчид тохиох эрсдэл байхгүй гэдэгт итгэдэг.

Өмчийн ёс журам нийлмэл байж болох ч тэдгээр нь тоо томшгүй олон хүмүүс нарийн мэргэжих явдал, сайн дурын солилцоогоор дамжуулан эв найртай хамтран ажиллах боломж олгоно. Эдгээр ёс журам үр ашигтай хамтын ажиллагаа байх боломж олгодог учраас л хувьсаж хөгждөг ажээ.

Хүмүүст ойлгомжтой, албан хэрэгжүүлэхүйц өмчлөх эрх байхад тэд нар өмчөө өөртөө хадгалж үлдэн, өмчөөс бүрдсэн нөөц баялаг руу хөрөнгө оруулах, түүнийгээ үр бүтээлтэй ашиглах явдлыг сахин хамгаалах магадлалтай байдаг. Энэ бол өмчийн эзэнд үр өгөөж өгдөг зүйл юм; гэвч үүнээс нь бас хүн бүр ашиг тусыг хүртдэг. Энэ

---

*9 complex intangibles*

*10 tragedy of the commons-орос. трагедия общих ресурсов — Энэ талаар Британийн эдийн засагч 1833 онд Виллиам Форстер Ллойдын бичсэн эссэнээс энэ концепц гарчээ. Түүнд энэ эрхэм нийтийн газарт дүрэм журамгүйгээр мал бэлчээх явдлын төсөөлсөн нөлөөг өгүүлжээ. Мөн Аристотл "Маш олон хүний дундын зүйлийг хамгийн бага анхаардаг. Хүмүүс өөрийн гэсэн зүйлээ л ихээр анхаарч үздэг: тэд нийтийн гэх зүйлд бага анхаарал тавьдаг" гэж байжээ.*

хөрөнгө оруулалтын үр жимсийг зарж борлуулах боломжтой гэсэн үг юм. Энэ л арилжаа эргээд нарийн мэргэжих, үнэ цэнийг тархааж түгээх явдлыг тэтгэнэ. Энэ байдал дайнд идэгдсэн эсвэл хуульгүй улсад буй тариачин дээрэмдэгч тонуулчин эсвэл арми ирээд хулгайлаад, эсвэл устгаад алдчих ургац авахын тулд үр тариа тарьж ургуулах ямар ч утга учир харагддаггүй тэр байдлаас ондоо зүйл ажээ.

## Эдийн засгийн эрх чөлөөг дэмждэг гаргалгаа нотолгоо

Эдийн засгийн уламжлалт хандлагатай адилгүй нь сонгодог либералчууд эдийн засгийн үзэгдлийг тайлбарлах бүхнийг хамруулсан аливаа *загвар* байгуулдаггүй. Тэдний хувьд үнэ зэрэг эдийн засгийн үзэгдэл сая сая хувь хүмүүсийн нарийн нийлмэл харилцан нийцэж тохирох явдлын урьдаас таамаглаагүй *үр дүн* байдаг ажээ. Гэвч энэ байдал энэ нь санамсаргүй, иррационал гэсэн үг биш юм. Үүний эсрэгээр зах зээлийн үйл явц алдах онох явдлаар маш урт хугацаанд хуримтлуулсан “сэцэн ухаан”-ыг ихээр агуулна.

### *Хувийн болон сарниж тархсан мэдээлэл*

Үнэндээ чөлөөт эдийн засгийн дэг журам хүмүүст нөлөөлөх маш их, илүү *тохиромжтой* мэдээлэлтэй байдаг учраас энэ нь аливаа албадмал байдлаар зохиомжилж бодож гаргасан, төлөвлөсөн эдийн засагт байдгаас *илүү их* сэцэн ухаан, төлөвлөлтийг агуулдаг.

Энэ бүх сая сая хувь хүн хол хөндий байгаа эдийн засгийн төлөвлөлтийн аливаа бүтэц хэзээ нэгтээ мэдэж чадах мэдлэгийг бодвол тухайн газрынхаа нөхцөл байдал, өөрсдийн үнэ цэнэ, хэрэглэгчид болон нийлүүлэгчийн чухалчилдаг зүйлийн талаар хамаагүй сайн мэдлэгтэй байдаг ажээ.

Мөн төлөвлөгч энэ мэдээллийг бүр цуглуулах ч боломжгүй. Энэ нь зөвхөн хэмжээгээрээ асар их, сарниж тархсан, хэсэгчилсэн байдалтай байдаг учраас биш мөн *хувийн шинжтэй* байдаг учраас тэр ажээ. Ур чадвар, туршлага, зах зээлийн ухаарац ойлголт, хэрэглэгчийнхээ хүслийг мэдрэх сэтгэл зэрэг эдгээр зүйл эдийн

засгийн амьдралыг хөдөлгөдөг амин чухал мэдлэг боловч эдгээр мэдлэг бол төвийн төлөвлөгчид дамжих боломжгүй мэдээлэл юм. Бид тос эсвэл дарс үйлдвэрлэх хэрэгтэй юу? Энэ нь арифметик тооцооллын хэрэг явдал биш. Биднийг эд зүйл үйлдвэрлэх гэсэн чармайлт руу хөтөлдөг цор ганц учир шалтгаан бол тэдгээрийг нь хэрэглэх явдал байдаг бол хүмүүс юу хэрэглэхийг хүсэж байгаа нь тэдний хэрэгцээ болон үнэ цэнээс хамаардаг– энэ үнэ цэнэ бол нийлбэрийг нь гаргах, эсвэл хасах боломжгүй, маш субьектив шинжтэй, өөр өөр цаг мөчид тоо томшгүй олон урьдаас таамаглах аргагүй хүчин зүйлээс хамаардаг мэдрэмж юм.

Гэвч өөрөө-тогтдог эдийн засгийн дэг журам *төлөвлөгдөөгүй зүйл* ажээ. Үүний эсрэгээр энэ нь хүн бүр сарниж тархсан, хэсэгчилсэн, хувийн мэдлэгээ бусад хүмүүсийн хүсэл хэрэгцээг ухаж ойлгох, мөн тэдний хүслийг биелүүлэх рүү хэрхэн нөөц баялагаа чиглүүлэхээ төлөвлөдөг, сая сая хувь хүний *тасралтгүй үргэлжилдэг төлөвлөлт*ийн үр дүн байдаг.

## *Өрсөлдөөн*

Эдийн засгийн эрх чөлөө бусдын хэрэгцээ, ашиг сонирхлыг биелүүлэх өөрийн-тусыг бодох[11] сэдлийг маань дэмждэг цор ганц арга зам байдаг учраас албадлага байхгүй үед л ажилладаг. Сонгодог либералчууд бүхэнд нээлттэй өрсөлдөөнийг хэрэглэгчдэд дундаас сонгох нийлүүлэгчид, бараа бүтээгдэхүүний сонголт байлгадаг, мөн үйлдвэрлэгчид тэдний хэрэгцээг чадахынхаа хэрээр үр ашигтайгаар буюу зардал багатайгаар хангаж үйлчлэхээр өрсөлддөг учраас үүний гол хөдөлгөгч хүч гэж ойлгодог. Жинхэнэ өрсөлдөөн бол 'төгс' адилхан нийлүүлэгчид, бараа бүтээгдэхүүнүүд, хэрэглэгчдийн тухай өгүүлсэн сурах бичгийн амьгүй загвар биш юм. Ийм өрсөлдөөн янз бүрийн үйлдвэрлэгчид зүсэн зүйлийн хэрэглэгчдийг олон янзын таашаадаг зүйлээр нь өөртөө татахаар санал болгож буй зүйлсээ янз бүр болгохоор чармайдаг динамик буюу хөдөлгөөнтэй амьд, хүмүүний үйл явц байдаг.

---

*11 self-interest*

Эдгээр ‘төгс бус байдал’ зах зээлд динамизм өгч, шинэчлэл, үр ашигтай байдал, аливааг сайжруулах явдлыг сэдэлжүүлж нөхцөлдүүлдэг ажээ. Энэ бол өсөж буй үнээр илэрдэг, үйлдвэрлэгчид түүнийг нь хангах гэж орж ирэх сэдэл төрүүлдэг, *хомсдол*, биелээгүй хүсэл юм. Энэ бол үйлдвэрлэгчид үйлдвэрлэлд хэрэглэдэг нөөц баялагийг хэрэгцээгүй гарлагадаж байгааг хэлдэг илүүдэл ажээ. Энэ нь хэрэглэгчийн янз бүрийн таашаал сонирхол, бүр зөрчилдөөнтэй таашаал сонирхлыг ч биелүүлэхээр санал болгож буй бараа бүтээгдэхүүний олон төрөл зүйл билээ.

### *Олон нийтийн ашиг тус*

Чөлөөт эдийн засаг өөр өөр үнэ цэнэтэй хүмүүсийг эвтэй байлгадаг. Худалдагч болон худалдан авагч тэд нар тодорхой бараа бүтээгдэхүүн эсвэл үйлчилгээг хэрхэн үнэлдгээрээ ялгаатай байдаг учраас л  нэг нэгтэйгээ чөлөөтэй хамтран ажиллах бололцоотой болно. Мөнгөний зуучлалаар дамжуулан бид бүр дэлхийн өөр өнцөгт буй, үнэт зүйл, шашин, ёс суртахуун, ертөнцийг үзэх үзэл нь биднийхээс бүхэлдээ эрс өөр байж болох хүмүүстэй ч арилжаа хийх боломжтой. Иймэрхүү өөр өөр үзэл санаатай хүмүүсийн даян дэлхийн эдийн засгийн харилцан хамаарал бол магадгүй хүмүүний түүх дэх эв найртай байх явдлын хамгийн хүчирхэг хүч байж болох юм.

Хувь хүмүүсийг өөрийн-тусыг бодох явдал өдөөдөг байж болох ч харин өмч, нарийн мэргэжих явдал, зах зээл, солилцоогоор дамжуулан энэ өөрийн-тусыг бодох явдлыг нийт олны ашиг тусын төлөө ашигладаг ажээ. Ингэснээр эд зүйлийг илүү үр ашигтайгаар үйлдвэрлэдэг; чанар дээшлэх, үнэ буурах дарамтаас болж хэрэглэгчид сайн үйлчилгээ авдаг; шинэ өмч бий болж, үнэ цэнэ нь өсдөг; хүсэл биелдэг; сонголтын хүрээ нэмэгддэг; хүмүүний олон янз байдал, хувийн өвөрмөц чанар[12]ыг таашаан магтдаг.

Бүр хэрэв хувь хүмүүс филантропи буюу буяны үйлс хийхээр тэмүүлдэг байсан ч тэд нар өөрсдийн бүтээж, бусдад түгээж чадах

*12 human diversity and individuality*

зүйлийн үнэ цэнийг хамгийн их байлгах боломжийг тэдэнд олгодог тэр л тогтолцоог хадгалж үлдэх гэсэн нэг ижил ашиг сонирхолтой байдаг.

## Төр засгийн тогтворгүй болгодог үр нөлөө

Эдийн засгийн эрх чөлөө бидэнд чухал бөгөөд энэ нь эдийн засгийн үйл ажиллагаа бидний сэрүүн цаг хугацааны ихэнхийг эзэлдэг учраас зөвхөн болдоггүй. Энэ нь мөн бидний нийгэм улстөрийн эрх чөлөөнд суурь шинжтэй байдаг. Жишээлбэл үг хэлэх эрх чөлөө[13] хэрэв эрх мэдэлд байгаа хүмүүс сонин хэвлэл, зурагт радио, онлайн хэвлэлийг хянадаг бол хавчигдах болно. Эвлэлдэн нэгдэх эрх чөлөө[14] хэрэв улстөрийн засаг захиргаа уулзалтын бүх танхимыг өмчилдөг эзэмшдэг бол аюул ордог. Хэрэв төр бидний албан байр, үйлдвэрийг удирдаж захирдаг бол бид өөрийн хөдөлмөрийнхөө үр шимийг таашааж эдэлж чадахгүй. Тийм учраас л сонгодог либералчууд эдийн засгийн эрх чөлөө болон өмч өмчлөх хувийн эрх[15]ийг төрийн хэтэрсэн их эрх мэдлийн эсрэг зогсдог амин чухал цайз гэж хардаг ажээ.

НХУ[16], АНУ зэрэг улсууд баян болох үед төр засгууд нь өнөөдрийнхөөс хамаагүй бага байсан. Одоо бараг бүх улс тэжээхийн тулд нь татвар их байх шаардлагатай, төр засгийн том хэмжээтэй албан байгууллагын бүтэц[17]тэй болжээ. Сонгодог либералчууд үүнийг өмчийн эрх рүү халдаж буй явдал гэж ойлгодог. Дунд зэргийн татвар батлан хамгаалах, шүүх зэрэг засгийн газрын үндсэн чухал функцийг явуулахад гарцаагүй хэрэгтэй байж болно. Гэвч их татвар ажиллах эрмэлзлийг бөхөөж, хадгалж хураах явдлыг зогсоож, зах зээлийн бүтээлч динамизмийг унтрааж, нөөц баялгийг ихээр үнэлэгдэж буй хэрэглээнээс холдуулж (голдуу төлөөллийн бус байдаг[18]) улстөрийн засаг захиргаа буюу эрх мэдэлтний сонгосон

*13 freedom of speech*
*14 Free association*
*15 private ownership*
*16 UK*
*17 government establishments*
*18 often unrepresentative*

хэрэглээ рүү зүглүүлдэг.

Зохицуулалт мөн зах зээлийг чөлөөтэй байлгах, мөн чөлөөт өрсөлдөөнийг хамгаалах, мөлжлөгтэй тэмцэхэд хэрэгтэй байж болно. Гэвч дахиад л арилжааны гэрээг хязгаарлах замаар зохицуулах нь сайн дурын солилцоогоор бүтээдэг үнэ цэнийг бууруулах боломжтой. Аль ч тохиолдолд тогтоол шийдвэрийн хэт их зохицуулалтыг нийт олонд зориулж биш харин улстөрийн болон шунахай ашиг сонирхолд үйлчлүүлэх гэж бий болгодог.

Сонгодог либералчууд эдийн засгийн амьдралд төр засаг хөндлөнгөөс оролцох явдлыг үргэлж сүйрэл дагуулах болно гэж дүгнэдэг. Нэгэнт татварлах явдал олонд таалагддаггүй тул засгийн газар ирээдүй үеийнхнийхээс мөнгийг нь тэдний зөвшөөрөлгүйгээр авч зээлдэг. Тэд нар үнэ цэнэ нь багассан мөнгөөр өөрсдийн өрөө буцаан төлөх боломжтой болох гэж улсынхаа валютын үнэ цэнэ суларч ганхахыг зөвшөөрдөг; гэвч инфляц буюу үнийн хөөрөгдөл үнийн тогтолцоог тогтворгүй болгож, ерөнхийдөө өсөж буй үнийн үймээн дунд өөрчлөгдөж буй харьцангуй үнийн дохиог живүүлэн дарж, хүмүүс тэдний хүчин чармайлт болон нөөц баялаг хаана хамгийн их үнэ цэнэтэйгээр хэрэглэх боломжтойг харж мэдэх явдлыг хэцүү хүнд болгоно. Засгийн газар эдийн засгийн огцом өсөлтийг идэвхижүүлнэ гэж найдан мөнгө болон хүүний хэмжээг байнга л удирдан залахаар шунан тэмүүлдэг – энэ бол гарцаагүй сүйрэл, ажилгүйдэл, хямралаар дуусдаг, зах зээлийн бодит байдлаас гажсан үйлдэл юм. Сонгодог либералчууд сүйрэл дагуулсан эдгээр интервенц буюу хөндлөнгөөс оролцох оролцоог хориглохыг нилээд чухалчилж үздэг.

## *Төрөөс ангид эрүүлмэнд, боловсрол, халамж*

Сонгодог либералчууд хөгжингүй улсуудын төр засгийн төсвийн ихэнхийг зарцуулдаг, эрүүлмэнд, боловсрол, халамж зэрэг үйлчилгээнд засгийн газар оролцох явдалд мөн л сэтгэл дундуур ханддаг ажээ.

Жишээлбэл халамжаар ядуурлыг устгахыг зорьдог боловч

үүнийхээ эсрэг зүйлийг магадгүй хийн, (тэтгэмж авдаг) ажилгүйдэл болон (татварлуулдаг) ажил эрхлэлтийн хоорондохь тэнцвэрийг эрс хазайлгадаг. Ихэнхи гарамгай сонгодог либерал сэтгэгч нар дор хаяж хамгийн бага халамжийг төрөөс хангахын төлөө маргаж мэтгэлцдэг ч тэд нар иймэрхүү дэмжлэгийг зах зээлийн механизм хамгийн сайн гүйцэтгэх болно гэдэгт итгэдэг. Жишээлбэл тэд нар хүмүүс хүнд хэцүү тохиолдолд төрийн оролцоо [энэ талбарт] буурч татрахад дахин идэвхижсэн буяны байгууллагын тусламжтайгаар эсвэл төр иим төлбөрийн чадваргүй нэгэнд гэрээний шимтгэлийг нь төлөх тэр л тусламжаар өөрсдийгөө ажилгүйдэл, өвчин, хөдөлмөрийн чадвараа алдахын эсрэг даатгуулах явдлыг илүүд үзэх болно. Энэ байдал бол тэдний хэлэхээр хамаагүй бага зардалтай байх болно. Энэ нь (тэтгэмж авагсдын дунд ч, бас энэ тогтолцоог удирдаж захирдаг захиргаадалтын хүмүүсийн дунд ч) хамааралтай болох явдлыг тэтгэдэг, өнөөдрийн төрийн халамжийн тогтолцоог бодвол илүү эерэг санаачилга, цөөн муу сэдэл төрүүлэх болно.

Эрүүлмэндийн салбарыг мөн л голдуу төр засаг хариуцдаг эсвэл түүнийг тогтоол шийдвэрээр маш их зохицуулсан байдаг нь хүмүүст даатгагч эсвэл иим үйлчилгээ үзүүлэгчдээс сонгох бололцоогүй болгодог. Нэгэнт өрсөлдөөн бусад зах зээлд сайн ажилладаг тул сонгодог либералчууд яагаад энэ өрсөлдөөн зардлыг бууруулж, чанарыг сайжруулж, үүнээс нь өнөө үед эрүүлмэндийн үйлчилгээ авах төлбөрийн чадваргүй эсвэл авч чадахгүй байгаа ядуус хамгийн их тус хүртэн, эмнэлгүүдэд ч мөн ажиллах боломжтой биш үү гэж асуудаг. Жинхэнээсээ өрсөлдөөнтэй даатгал л төрөөс айлгаж сүрдүүлсэн авир гаргах шаардлагагүйгээр эрүүл бус амьдралын хэвмаягаас гарч болох төлөөсийг хүмүүст ухамсарлуулж ойлгуулах болно.

Боловсрол бол үйлчилгээ үзүүлэгч өөр бусад ханган нийлүүлэгчдийг, үнэндээ чөлөөт гэж үзэж болох нийгэмд л зөвхөн хор уршигтай байж болох өөр бусад үзлийг шахан зайлуулдаг, голдуу төрийнх байдаг өөр нэг монополь байдал юм. Тиймээс л сонгодог либералчууд “чанаргүй” сургуульд гацсан ядууст дахиад хамгийн их тус болох, сургуулиар боловсрол олгоход өрсөлдөөн байхын

төлөө маргаж мэтгэлцдэг. Милл зэрэг зарим сонгодог либералчууд суурь боловсрол албан журмын байсаар байх хэрэгтэй гэдэг бол бусад нь нэгэнт эцэг эхийн хувьд хүүхдээ сургууль суралцуулах нь хамгийн чухал зүйлсийн нэг байдаг учраас ингэх хэрэгцээ байхгүй гэж шаргуу ятгадаг; буяны үйл ажиллагаа[19] дахиад энд тулгарах хүнд хэцүү тохиолдлыг шийдвэрлэх болно.

## Арилжаа ба Протекционизм

Сонгодог либералчууд олон улсын арилжаа[20] дотоодын наймаа арилжаа шиг чөлөөт байх ёстой гэдгийг сахин хамгаалдаг. Энэ байдал улс орнуудыг хамгийн сайн хийдэг зүйлээрээ нарийн төрөлжүүлэх болно; энэ нь хэрэглэгчид дэлхий дэхний бараа бүтээгдэхүүнийг таашааж эдлэх боломж олгоно. Түүхээс харвал арилжаа чөлөөтэй байсан улсууд жишээлбэл Хонконг маш хурдан хөгжиж томорсон байдаг; саяхан Хятад болон Энэтхэг зэрэг улс арилжаанд нээлттэй болсноор тэрбум тэрбум хүн үгээгүй ядуугийн хүлээснээс ангижирчээ.

Олон улсын арилжаа худалдаа, сонгодог либералчуудын батлан өгүүлснээр олон-улсын хамтын ажиллагааг тэлж, хүлцэн тэвчихүйг өргөжүүлж, санаа бодлыг тархаадаг ажээ. Гэлээ гээд улстөрөөр сэдэлжсэн, хэт олон үндэстэн импортын квот болон тарифаар өөрийн үйлдвэрлэгчдээ хамгаалахыг оролддог. Энэ байдал байж болох импортлогчид өөрийнхөө хөдөлмөрийн үр шимээ хүртэх явдлыг хорих бөгөөд энэ нь хэрэглэгчид сонголт бага болох, нарийн мэргэжих явдал багасах, нөөц баялагийг бага үр ашигтай ашиглах, үнэ цэнэ буурах болно гэсэн үг юм. Энэ нь мөн шүдийг-шүдээр гэсэн өширхөл, худалдааны дайн, олон улсын түгшүүртэй байдал руу хүргэдэг. Гэвч энэ байдал засгийн газар эдийн засгийн чөлөөт үйл ажиллагаанд хэт шулуун хутгалддаг учраас л зөвхөн тохиолддог ажээ.

---

*19 charities*

*20 international trade-энэ нь trade of many countries гэдгээс ялгаатай тул Б. Ренчин гуайн хэлснээр олон-улсын арилжаа гэвэл утга нь тодорч өмнө нь хэлсэн хэллэгтэй андуурагдахгүй.Энэ нь хүчилтөрөгч, бараабологч гэсэн үгнээс ялгаагүй нэр томьёо билээ.*

# ЕСДҮГЭЭР БҮЛЭГ:
# Өнөөдрийн Сонгодог Либерализм

## Унтарсан нь, бас сэргэн мандсан нь

### *Сонгодог либерализмийн уналт*

Сонгодог либерализм арвандолоо болон арваннаймдугаар зуунд цэцэглэж байлаа; арванесдүгээр зууны чөлөөт худалдаа болон эдийн засгийн өсөлтийн аугаа эриний маш их хэсэг нь энэ хөгжил цэцэглэлтэй холбоотой. Гэвч арванесдүгээр зууны сүүлээр бусад санаа бодол хүчээ авсан. Эдийн засгийн эрх чөлөөний нэг үр дүн болох аж үйлдвэржилтээс нийгмийн бэрхшээл бий болжээ – гэр бүл үймэх, хот руу чиглэсэн эрчтэй нүүдэл, тэгш бус байдлыг улам бүр мэдрэх явдал хүмүүс хамтдаа ойр амьдарч эхлэхэд сая гарах болов.

Хорьдугаар зуун гэхэд аж үйлдвэрийн нийгэм социализм, коммунизм, дараагаар нь төвлөрүүлэх идеологи рүү хүрэх милитаризмийн хамтаар үндэсний социализмд уруу татагдах хөрс болсон билээ. Гэвч энэхүү зайлах аргагүй гарсан зөрчилдөөний дараагаар центризм буюу төвлөрүүлэх үзлийг эсэргүүцэж түүнээс татгалзахаасаа илүүтэйгээр дайны-дараахь ялагчид өөрсдийнх нь төвлөрүүлсэн тушаалын бүтэц ‘дайныг ялсан’ шигээр тэдэнд “эв найртай цаг үед ялалт авчрах”-ад нь туслах болно гэж дүгнэсэн.

Тэр цаг үед эдийн засгийн энэ ухаарац ойлголтдоо асар их итгэлтэй бас байлаа. Эдийн засагчид ажил эрхлэлт, бүтээмжийг хянах мэдлэг, арга хэрэгсэлтэй, мөн төвлөрсөн төлөвлөлт зах зээлийн төсөөлж таамагласан “иррационал байдал”-аас илүү сайн гэдгийг ядах юмгүй батлах болно гэдэгтээ итгэлтэй байв.

### *Төөрөлдөж будлисны үр дагавар*

Хэдий энэ нь тэр үедээ нас бие гүйцсэн гэж харагдаж [давамгайлж] асан энэ үзэл санаа өөрөө өөрийгөө найдваргүй зүйл гэдгээ

харуулахад их ч хугацаа орсонгүй ээ. Аялал жуулчлал, харилцаа холбоо сайжрахад коммунист эвслийн эдийн засаг, нийгэм улстөрийн хоцрогдлыг харуулав. Баруун Германд Лүдвиг Эрхард 1948 оны нэгэн бүтэнсайны өглөө 'хяналт шатаах түүдэг'[1]ийг өрдсөний дараагаар цэцэглэн огцом хөгжсөн бол харин Зүүн Германд алдартай Берлиний Хананы нөгөө талд аажмаар тогтуухнаар улам бүр дүнсгэр болжээ. Үүнтэй адил зүйл хойг нь нэгэнтээ чөлөөт болон коммунист хэсэг болж хуваагдахад хоёр Солонгост тохиолдсон. Дэлхийн хүн ам илүү боловсролтой, гэгээрч ухаажих тусам милитаризмийг хамгаалалтаа гэж харж ойлгохоо больж харин түүнийг эдийн засгийн улам өсөж буй харилцан хамааралтай болох явдлын дайсан гэж харах болсон.

Дайны дараахь эдийн засгийн бодлого мөн л түгжигнээнтэй байв. Британийн эдийн засагч Жон Мэйнэрд Кэйнс (1883–1946 он)-ийн хямралын үед зориулж зохиомжилж гаргасан тэлэлтийг-дэмжсэн бодлого[2] тайван цагийн хувь хуримтлал[3]ыг төр засгийн нэмэгдэж буй тэлэлт, огцом өсөж буй инфляц болгож хувиргажээ - үүнийг нь Кэйнсчүүдийн хувьд ойлгомжгүй зүйл байсан ажилгүйдэл, эдийн засгийн агшилт бас дагалдав.

## Сонгодог либерализм дахин төрсөн нь

Сонгодог либералчуудын хувьд энэ бүх зүйл ойлгохын аргагүй зүйл биш байлаа. Хаекийн тайлбарласанчлан энэ нь нийгэм эдийн засгийн амьдралын өөрөө-тогтдог дэг журмыг өөрийн тааллаараа бид удирдаж залж чадна гэж төсөөлж бодсон 'үхэлд хүргэх бардамнал'-ыг ил болгов.

---

1 *"bonfire of controls" - Энэ бол Харалд Вилсон гэх Британий Засгийн Газрын хамгийн залуу сайд асан, Худалдааны Зөвлөлийн Ерөнхийлөгч байсан энэ хүн дайны цагийн хүнснийг зөвшөөрсөн хэмжээгээр олгох явдлыг бууруулах тэргүүн зорилго тавьж үүнийгээ "хяналт шатаах түүдэг" гэж нэрлэж байжээ. Вилсон дайны цагийн асар их хяналт энх цагийн хөгжил цэцэглэлтийг хорьж саатуулж байна гэж үзсэн ба тэдгээр аль болох түргэн үгүй хийхийг оролдож байв.*

2 *expansionist policies*

3 *peace dividend-нэг зардал буурахад гарч ирсэн, бусад зорилгод ашиглах боломжтой олон нийтийн мөнгөний дүн хэмжээг мөн хэлнэ.*

Хэдий оюун ухааны эзгүй хээр газар цөлөгдсөн ч гэсэн сонгодог либералчууд дүгнэлт хийж, үзэл санаагаа тунгааж бодож, орчин үеийн эринд нийцтэй болгохоор дахин нэгдсэн байдаг. Энэхүү сөрөг дайралт Хаек Европ болон Америкийн сонгодог либерал сэтгэгчид болох цөөн хүмүүсийг Женев Нуур[4]ын дээр орших ууланд, хожмоо Мон Пелерин Нийгэмлэг болох анхны уулзалт болгож хуралдуулахад 1947 оны 4-р сард эхэлжээ. Гишүүд нь Эдийн Засгийн Хэрэг Явдлын Хүрээлэн зэрэг сонгодог либерал тинк танк буюу судалгааны төвийг үүсгэн байгуулж үйл хэргийг нь үргэлжлүүлэх бөгөөд түүнээс нь олон өөр хүмүүс салбарлан гарчээ.

Хэд хэдэн гишүүн нь үүн дотор өөрөө Хаек ороод сонгодог либерал эдийн засгийг ухааныг дахин амилуулахад оруулсан хувь нэмрийнхээ төлөө Нобелийн шагнал хожмоо хүртэх болно: Нобелийн шагналтан Жорж Стиглер (1911–91 он), Милтон Фрийдмэн (1912–2006 он), Гари Беккер (1930–2014 он) нар баталгаажсан мөнгө[5], хязгаарлагдмал засгийн газар, зах зээлийн эрх чөлөөнд анхаарал хандуулдаг Эдийн Засгийн Ухааны Чикагогийн Сургуулийн замчлах гэрэл болох болно; энэ үеэр тэдний хамтрагч Нобелийн шагналт Жэймс М. Бачэнэн (1919–2013 он) төр засгийн шийдвэр гаргах явдлын төсөөлсөн рационал байдлыг шүүмжилж дайрдаг Олон Нийтийн Сонголтын Сургуулиа удирдах болно. Хорьдугаар зууны төгсгөл гэхэд тэдний үзэл санаа дэлхийн тэргүүлэх засгийн газруудыг өдөөж тэдгээрт урам өгсөөр л ирэв.

### *Сонгодог либерализмийн утга учир*

Орчин үеийн сонгодог либералчуудын алдсан нэг зүйл бол өөрсдөдөө сайн нэр олж өгч чадаагүй байдаг явдал юм. “Сонгодог” гэсэн шалгуур нь Локк болон Смитийн цаг үеийг буцаан сануулдаг:

4 *Өрнөдийн бичгийн хэлэнд, ялангуяа Англи хэлэнд газрын усны нэрийг бичихдээ Женев Нуур, Хөвсгөл Нуур, Хадсон Мөрөн гэх зэргээр томоор бичдэг ажээ.*

5 *sound money-Энэ бол алтаар баталгаажсан мөнгийг хэлнэ. Харин үүний эсрэг мөнгийг нь fiat money гэх ба үүнийг үл баталгаажсан мөнгө эсвэл үл хөрвөх мөнгө гэж 2 янзаар орчуулсан ч эхнийх нь арай дээр ойлгомжтой ажээ.*

тэдний үзэл санаанд маш их сэцэн ухаан байсан ч гэсэн дэлхий өөрчлөгдсөн орчин үеийн сонгодог либералчууд тэдний сэтгэлгээг өнөөгийн нөхцөл байдал, гаргалгаа нотолгоог судлах шинэ арга замаар хөгжүүлсэн билээ.

Тэдний хувьд харамсалтай нь хэдий "либерал" гэсэн ойлгомжтой жирийн хэллэгийг нь (хэдий энэ будлиан эндээс эхтэй тархсан ч дор хаяж) эдийн засгийн эрх чөлөө болон хувийн өмчид сэжиглэнгүй ханддаг, зөв зүйл нь буруугаа давахад, мөн тэгш байдлыг тэтгэхэд төр гол үүрэгтэй байдаг гэдэгт итгэдэг, иргэний эрх, улстөрийн эрх чөлөөний шаргуу дэмжигчид булаан авчихжээ. "Шинэ либерал' болон 'орчин үеийн либерал' гэсэн хэллэгийг бас бусдад булаалгав.

"Нео-либерал" гэдэг үг үүнийг орчин үеийн сонгодог либерализмийг шүүмжлэхдээ доромжлох утгаар хэрэглээгүй байх тул түүнийг ашиглаж болох юм. Энэ үг Баруун Германы дайны дараахь "нийгмийн зах зээлийн эдийн засаг"-ийг дэмжигч "Ордо-Либерал"[6]-чуудын дундаас үүсэж гарчээ. Гэвч бүр саяхнаас сонгодог либералчуудыг нийгмийн ямар ч ухамсаргүй эсвэл ядуу дорой нэгнийг боддоггүй, хэрэв боддог бол бизнесийн аливаа үйлдлийг хамгаалдаг, лэзе фэер болон харуулын төрийг шаарддаг, эдийн засгийн нэг л зүйл рүү зорьсон явцуу зорилготой, улайрсан хамгаалагч гэж харагдахаар шоолж цоллохдоо ашигласан байдаг. Ийм сүрэл мануухай бол бидний ойлгож байгаачлан дайрч давшлахад маш амар хүн боловч энэ бүх байдал сонгодог либералчуудын жинхэнээсээ итгэдэг зүйлээс маш хол зүйл ажээ.

## *Сонгодог либерализмийн хамрах хүрээ*

Гэвч сонгодог либерализм бол бүрдэл идеологи[7] биш юм; бидний харж ойлгодогчлон энэ нь илүүтэйгээр нийгэм, эдийн засаг,

---

*6 'Ordo-liberal'- Эдийн засгийн либерализмийн Герман хувилбарыг Ордолиберализм гэдэг. Халамжийн төрийг дэмждэггүй ч төр засгаас чөлөөт зах зээл бүрэн боломжоороо ажиллах явдлыг баталгааж өгөх явдлын ач холбогдлыг өргөж харуулдаг.*

*7 set ideology*

улсторийн эрх чөлөөний асуудлыг судалдаг хандлагын өргөн хүрээ[8] билээ. Нэг хязгаарт нь ерөөсөө төрийн институцийн хэрэгцээ байхгүй гэж үздэг анархистууд (болон зарим нэг либертаричууд) байна. Нөгөө нэг хязгаарт нь төр үндсэн эрхийг хамгаалахаар зөвхөн зогсохгүй мөн тодорхой ёс суртахуун эсвэл улсторийн үнэт зүйлийг хадгалж үлдэхэд хүчирхэг үүрэг нөлөөтэй гэдэгт итгэдэг консервативчууд байдаг.

Сонгодог либералчууд либертаричуудыг бодвол соёл, төлөөллийн төр засаг буюу засгийн газар, өөрөө-тогтдог эдийн засгийн болон нийгмийн дэг журмын суурь болсон дэг журамд илүү их анхаарал хандуулдаг; гэлээ гээд тэд хэдий тэдний олон нь нийгмийн нэгдмэл байдал чухал гэдгийг илэрхийлдэг ч гэлээ нийгмийн ашиг тусын төлөө эрх чөлөөг золиослохыг консервативүүдийгээ бодвол бага хүсэцгээнэ.

Гэвч дахиад л өөр өөр сонгодог либералчууд ондоо ондоо цөм зарчмаар сэдэлжсэн байдаг. Жишээлбэл зарим нэгнийх нь хувьд Фрийдмэний адилаар эрх чөлөө чухал боловч эрх чөлөөний үр дагаврыг жинхэнээсээ чухалчилж үзнэ; тэд нар эрх чөлөөг нэмэгдүүлэх гэж биш бас эдгээрээс гардаг нийгмийн үр өгөөжтэй үр дагавраас нь болж зохицуулалт журмыг багасгах явдал, хувьчлал, бага татварыг таашаан дэмждэг. Бусад нь Хаекийн адилаар тодорхой ёс суртахуун болон хуульзүйн ёс журмаар хязгаарласан чөлөөт үйлдлийг өөрөө-тогтдог дэг журмын амин чухал суурь үндэс гэж үздэг. Гэлээ гээд бусад нь Нозикийн адилаар хүмүүн төрөлтөн бүгдээрээ шударга бус байдлыг засахаас өөр хуульзүйн дагуухь эрх төрд барагтай бол үлдээдэггүй, үл гажих жам ёсны эрхтэй гэж шаргуу ятгадаг.

Гэвч үзэл санаа нь олон янз байдаг ч гэсэн сонгодог либералчууд үндсэн зарчмууд дээрээ санал нэгдэцгээнэ. Тэд төрийн гол зорилго бол бидний амьдрах эрх, эрх чөлөөт байдал, өмч, аз жаргалдаа зорьж тэмүүлэх явдлыг хамгаалах гэдэгт итгэдэг. Нэгэнт л эдгээр нь ийм чухал фүнкц юм бол төрийг маш цомхон болгох аргагүй ч гэлээ

8 *spectrum*

хэрэв бид нар эрх чөлөөгөө төрийн эрх мэдлийг буруугаа ашиглах явдлаас хамгаалах гэж байгаа бол төрийг ажлын хүрээгээр нь хязгаарлах хэрэгтэй. Сонгодог либералчууд сайн дурын солилцоо бол үнэ цэнэ нэмэх, тархаах, бидний бүтээлч сэтгэлийг суллаж тавих, бидний олон янз байдал болон өөрийгөө илэрхийлэх байдлыг таашаан дэмжих хамгийн сайн арга зам юм гэдэгт итгэдэг. Тэд нар улстөр, эдийн засаг, нийгмийн амьдралын абсолютизм[9]-ын талаар маш гүнзгий сөрөг сэтгэгдэл[10]тэй байдаг ч гэсэн бидэнд зарим нэг ёс суртахуун болон хуульзүйн ёс журам өөрөө-тогтдог нийгэм болон эдийн засгийн дэг журмын жигд тогтуун ажиллагааг хадгалж үлдэхийн тулд хэрэгтэй гэдгийг сахин хамгаална. Тэд хувь хүмүүс өөрсдийнхөө үйлдлийн хариуцлагыг хүлээх ёстой гэдэгт итгэдэг: бид бусдад туслах, үүнийг хийх нь чөлөөтэй боловч хэн ч бусад өөр нэгнээс дэмжлэг шаардах эрхгүй гэнэ. Гэвч тэд нар бүх хүмүүн, бүх хувь хүмүүс ижил ёс суртахууны статустай байх, хуулийн дор ижил тэгш харьцах явдлыг баталгаажуулж өгдөг.

## Сонгодог либерализмийн интернационализм

Сонгодог либералчууд нийт хүмүүн төрөлхтөнийг нэг ижил суурь эрх, эрх чөлөөтэй байдаг гэсэн итгэл үнэмшлээрээ бол интернационалистууд[11] ажээ. Гэвч тэд нар дэлхийн засгийн газрын Утопи үзэл санааг эсвэл бүр дэлхийн иргэний нийгмийн үзэл санааг ч бөөцийлж хамгаалдаггүй. Тэд нар иргэд үндэстнийхээ төртэй маш нягт холбоотой гэдгийг бодитойгоор хүлээн зөвшөөрдөг; тэд зөвхөн тэр хүмүүст боловсрол олгож мэдлэг түгээх, эдгээр төрт улсын хоорондохь зөрчлийг намжаахыг эрэлхийлдэг. Энэ байдал бол олон улсын аялал жуулчлал, эдийн засгийн харилцан хамааралтай байдал үзэл санаа, бололцоо, сонголт, үүний хажуугаар эрх чөлөө түгэн тархахад асар ихээр тус дэм болдог тийм нэг зүйл юм.

Сонгодог либералчууд аливаа үндэстэнд хэрэглэдэг эрх чөлөөний зарчим олон-улсын хэмжээнд арилжааны эрх чөлөө,

*9 absolutism-үнэмлэхүй эрх мэдэлтэй байх*
*10 antipathy*
*11 internationalist-тайлбарлах*

хөрөнгө болон шилжилт хөдөлгөөн хил дамнан шилжих боломжтой байх, гадаадын иргэд эсвэл тэдний бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ, өмчийг алагчлахгүй байх зарчмаар хоорондоо таарч байх ёстой гэдэгт итгэдэг. Гэвч Германы Ордо-либерал Вилхэлм Рёпке (1899–1966 он) хэлсэнчлэн интернационализм өөрийн гэрээс буюу нутаг орноос эхэлдэг билээ. Хэрэв бид шударга хууль, эрх чөлөө, хууль ёсыг өөрийн улс дотроо сахин хамгаалбал тэр үед дор хаяж нэг ижил зарчмаас бидний олон-улсын харилцаа болон институцэд салхи орох зарим нэг боломж гарч ирдэг. Сонгодог либералчуудад үзэл санаандаа зориулсан ямар ч импералист алсын бодол байдаггүй: эзэнт гүрэн хэдий энэ нь байнга л бодол санааг нь дарж дарангуйлдаг ч гэсэн хүмүүсийн ухааныг эзэмдэх боломжгүй. Сонгодог либералчууд соёл болон улс орнуудын хоорондохь олон янз байдлыг хүмүүсийн хүрээлэл, гэр бүл, хувь хүмүүсийн дундахь олон янз байдлыг дэмждэгийнхээ адилаар талархан дэмждэг.

### *Либерал бус бүлэг хүнтэй харьцах*

Сонгодог либералчуудад сонирхолтой байдаг нэг асуудал бол харин маш *либерал бус* санаатай бүлэг хүн болон үндэстэнтэй хэрхэн харилцах хэрэгтэй бэ гэдэг зүйл юм. Энэ асуудал улам бүр л чухал зүйл болжээ. Улстөр, нийгэм, эдийн засгийн эрх чөлөөний үзэл санааг эсэргүүцдэг, хэрэв хүсэж чаддаг сан бол бидний эрх чөлөөг баяртайгаар үгүй хийх, шашин болон улстөрийн мугуйд үзэлтнүүд[12] үргэлж байж ирсэн. Гэвч одоо аялж зорчих нь хэт хялбар болсон, сүйтгэх устгах технологи маш олдоцтой болсон үед, байж болох аюул занал илүү хөнөөлтэй болсон байна.

Сонгодог либералчууд ерөнхийдөө хүмүүсийн өөрийгөө-тодорхойлох эрх[13]ийг зөрчдөг гэж хардаг интервенцээс илүүтэй хүлцэн тэвчих явдал[14]д таатай ханддаг. Гэвч хэрэв бусад бүлэг хүмүүс эсвэл төрт улс эрх чөлөө болон хүлцэхүйг өөрийг нь устгах зорилго тавивал сонгодог либералчууд хэр зэрэг их хүлцэн тэвчих

---

*12 fundamentalists*
*13 rights of self-determination*
*14 toleration over intervention*

боломжтой вэ гэдэг асуудал гарна. Милл арванесдүгээр зууны бүтээлдээ нэгэнт зөвхөн 'иргэншсэн' төрт улс л бидэнтэй дүйх ёс суртахууны төвшинтэй байдаг тул бид "иргэншсэн" төрт улс руу биш харин "зэрлэг балмад" төрт улс руу гаднаас оролцох бүрэн эрхтэй гэж батлан өгүүлсэн; ямар ч тохиолдолд "иргэншсэн" төрт улсын хэрэг явдалд хөндлөнгөөс оролцох нь тэднийг өөрчлөх боломжгүй. Бүр саяхан Жон Рөүлс үүнтэй адилхан бид "сайн санаатай" улсыг хүлцэн тэвчих ч харин "хуульгүй" улсыг тэгэх боломжгүй гэсэн гаргалгаа нотолгоо ашигласан байдаг.

Үүнтэй адилхан байдлаар сонгодог либералчууд иймэрхүү асуудал, өөрийгөө-тодорхойлох байдлаар илэрхийлэх зарим нэг байдал, чөлөөт нийгэм либерал бус дайралтад тэсвэртэй байх байдал, хүмүүсийн шашны итгэл үнэмшлийг өөрчлөхийг оролдох явдлын утгагүй байдлын талаар янз бүрийн үзэл санааг сахин хамгаалдаг; бусад нь бид өөрийгөө батлан хамгаалахын тулд бусад улс руу хөндлөнгөөс оролцох хэрэгтэй батлан өгүүлцгээдэг. Сүүлд дурдсан хүмүүсийн стратегиэс өөр нэг асуудал бэрхшээл, хэрхэн хэзээ бүлэг хүн эсвэл үндэстэн жинхэнээсээ либерал бус болсныг, тэр нь хэр их аюул занал болохыг ялгаж таних вэ гэсэн асуудал гарч ирдэг. Жишээлбэл Хятад улстөрийн эрх чөлөөгүй, эдийн засгийн багахан эрх чөлөөтэй байдаг ч эдийн засгийн эрх чөлөөний шударга арга хэмжээ явуулдаг; гэвч эдийн засгийн болон цэргийн хүч нь олон хүний сэтгэлийг тавьгүйтүүлнэ. Энэ байдал сонгодог либерал үндэстнүүдэд аюул занал болж байна уу?

### *Нутагт нь байх эс либерализм*

Үүнтэй адилхан асуудал гэрт нь буюу нутагт нь буй либерал бус бүлэгтэй хэрхэн харьцах вэ гэдэг дээр ургаж гардаг. Сонгодог либералчууд интервенц буюу хөндлөнгөөс оролцох явдал (тодорхой шашин эсвэл улстөрийн бүлгийг хориглох зэрэг) өөрсдийнх нь цөм зарчимтай зөрчилддөг, мөн бусад хүмүүсийн бие даасан байдал болон өөрийгөө-тодорхойлох явдл[15]ыг ганхуулах болно гэдэгт

*15 self-expression*

санаа зовцгоодог. Тэд нар хэдий зарим тохиолдолд (жишээлбэл Германд үндэсний социализм өндийн босох мэт) байхгүй байгаасай хүсэж байж болох ч голдуу л шашин болон улстөрийн бүлгийг хүлцэн тэвчих хандлагатай байдаг.

Нөгөө талаас олон сонгодог либералчууд жишээлбэл охидуудад боловсрол олгохоос татгалзах эсвэл охидын бэлэг эрхтнийг хөндөх, тэдний хүчээр гэрлүүлэх явдлаас сэргийлэхийн тулд хөндлөнгөөс оролцох явдлыг зөв гэж бодож болох юм. Эдгээрийг бүх хүмүүн төрөлхтөн таашааж эдэлж буй эрх, эрх чөлөөг зөрчсөн явдал гэж харж ойлгодог.

Сонгодог либералчуудад иймэрхүү асуудалд хариулах урьдаас тогтоосон хариулт байдаггүй. Гэвч ерөнхийдөө тэд төрийн үйлдлийг хамгийн бага хэмжээтэй байх хэрэгтэй гэсэн үзэл санааг барьдаг. Зарим нь бид плюралистч буюу олон ургалч үзлийн цаг үе[16]д амьдарч байна, бид янз бүрийн зан авир болон уламжлалыг хүлцэх тэвчихээр хангалттай хөгжиж боловсорсон тул интервенц буюу хөндлөнгөөс оролцох явдлыг ингэхэд хүргэх зарим нэг анзаарахгүй байхын аргагүй “олон нийтийн” тохиолдол байхгүй л бол ерөнхийдөө зөвтгөх аргагүй байдаг гэсэн үзэл санааг баримтална. Бусад нь урт хугацаандаа хүмүүсийн ухаан сэтгэлийг өөрчлөхөд ятгалга, маргаан мэтгэлцээн л илүү үр өгөөжтэй байдаг гэдгийг цохож хэлнэ. Жишээлбэл охидын бэлэг эрхтнийг хөндөх[17]ийн эсрэг хууль магадгүй иймзүйлийг туулж гарсан, өөрийн хүүхдүүддээ үүнийг хийлгэхгүй гэж чөлөөтэй шийдэх эмэгтэйчүүдийг бодвол энэ дадлыг зогсооход үр ашиг багатай байх боломжтой. Энэ эрх чөлөө бол хуулийн хамгаалах ёстой тэр зүйл байх ёстой.

Дахин нэг удаа асуухад хэрэв либерал бус бүлэг өндийн босож тэнхээ сууж, тэд улстөрийн эрх мэдлээ хүмүүсийн эрх, эрх чөлөөг үгүй хийх гэж ашиглах болбол сонгодог либералчууд юу хийх бол? Заримынх нь хувьд Пэйнегийн адилаар энэ байдал бол тэмцэлд босож, төр засгаа авч хаяхад хангалттай үндэслэл байх ажээ. Гэвч бодит байдал дээр сонгодог либералчууд үүнтэй адилхан ямар нэг

*16 pluralist age*

*17 female genital mutilation*

зүйл болохын өмнө юмс үзэгдэл маш харамсмаар төлөвтэй болох болно гэдгийг мэддэг.

## Сонгодог либерал алсын хараа

Сонгодог либералчуудад дэлхийн талаар ямар ч хоосон төсөөлөл гэх зүйл байдаггүй. Хүмүүн төрөлхтөн төгс биш; хүмүүний ертөнцийг цэвэр зарчмаар тайлбарлах аргагүй, бас жирийн томьёогоор удирдаж залах боломжгүй. Аливаа үйл явдал голдуу зан төлөв нь ухаалаг буюу ухаалаг гэхэд хэцүү, сайхан сэтгэлгүй хүмүүс болох хүмүүн төрөлтний зорьсон зорилгын үр дагавар үргэлжид байдаггүй харин үйлдлийн урьдаас таамаглаагүй үр дагавар ихэвчлэн байдаг. Бидний хамгийн сайн бодлого бол энэ бүгдийг хүлээн зөвшөөрөх явдал бөгөөд хүмүүний сул талыг чөлөөт зах зээлийн адилаар хүмүүний ашиг тусыг дэмжиж тэтгэхэд ашиглах явдал билээ.

Сонгодог либерализм эхнээсээ л ойлгогдож ирсэн шигээ хүмүүнлэг үзэл билээ. Түүнд хоорондоо ялгаатай хүмүүн төрөлтнийг байгаагаар нь л хүлээн зөвшөөрдөг. Энэ үзэл санаа хүмүүс өөрсдийнхөө өөр өөр зорилгодоо хүрэхээр тэмүүлэх оронзай, боломжоог нь хамгийн их байлгахыг эрэлхийлдэг. Сонгодог либерализм ийм маш олон янз байх ертөнцийн иргэд хоорондоо эв найртайгаар хамтран ажиллах боломжтой арга замыг хайдаг.

Сонгодог либералчууд хамгийн бага албадлага (тэрийг нь хуульзүйн эрх дархтай, төлөөллийн төр засаг л зөвхөн ашигладаг)-тай тайван сайхан дэлхийг хүснэ. Тэд нар чөлөөт эдийн засгийн дэг журмын хүрээнд сайн дурын солилцоогоор үүсэж гарсан хөгжил цэцэглэлт дэлгэрсэн дэлхий, мөн бүх хүмүүн төрөлхтөний эрхийг хамгаалдаг, тэднийг нэг нэгнийхээ алсын бодолтой хамтран ажиллан, нийцэж зохицох боломж олгох хуульзүйн тогтолцоог хүснэ.

Тэд нар төр засгийн хүч чадлыг олон улсын зөрчилдөөн, дотоодын хэлмэгдүүлэлтийн шалтгаан гэж ойлгож эрх мэдлийг хязгаарлахыг хүсдэг. Тэд нар дур зоргын эрх мэдлийг хумьж, өөрсдийнхөө удирдагчдаа бусад хүн дагаж мөрддөгийн адилаар хуульд захирагддаг болгодог хууль ёсыг шаарддаг. Тэд нар үйл

явдлын үеэр бусад хүмүүст аюул тарьж хохирол учруулаагүй нөхцөлд хүн бүрийн бодож сэтгэх, ярьж хэлэх, ажиллах, өөрийн зорилгодоо хүрэхээр тэмүүлэх эрх чөлөөг дэмждэг бөгөөд мөн тэд нар тухайн дэг журмыг сахин хамгаалахад бие даасан шүүхийн тогтолцооны ач холбогдлын тухай ярьж хэлдэг. Тэд бүр хэрэв энэ нь өөрийгөө-устгах үгүй хийх байсан ч өөрийн зам мөрөөрөө өөрийн зорилгодоо хүрэхээр тэмүүлэх хүмүүсийн эрх чөлөөг дэмждэг бөгөөд хэн нэгэн ямар нэг зүйл хийхийнхээ өмнө зарим засаг захиргаанаас зөвшөөрөл хүсдэг байхыг хүсдэггүй. Хамгийн гол нь тэд нар улстөрийн эрх мэдэлтэн буюу засаг захиргаа ерөөсөө бидний эрхэд хөндлөнгөөс халддаг эрхгүй байх хувийн оронзайг зааж тогтоохыг хүсдэг.

Сонгодог либералчууд эдийн засгийн чөлөөт дэг журамд бат итгэлтэй байдаг. Тэд нар ийм дэг журам дэлхий даяар аажмаар тархаж өргөжих нь илүү сайн боловсрол олгох, дундаж наслалт илүү уртсах, өндөр наслах, өвчин зовлонгүй амьдрах, илүү боломж ялангуяа ядууст олгох болно гэдгийг сахин хамгаалдаг. Эдгээр зүйл социализм болон интервенционизм өргөн хүрээнд тархахаас хамаагүй өмнө болоод эхэлчихсэн бөгөөд одоо хаа газрын хүмүүст хөдөлмөрийнхөө үр шимээ алс холын зах зээлд зарах боломж олгож, мөн өөр өөр улс дахь үйлдвэрлэгчдийг нарийн мэргэжих явдлыг хурдасгаж, үр ашгийг нь дээшлүүлж, бас үнэ цэнэ бүтээж түүнийг тархааж түгээн хамгийн сүүлд зах зээлийн үзэл болон олон-улсын арилжаанд нээлттэй болж буй хамгийн ядуу хэсгийн улс орнуудад руу тэлж тархаж байна гэдгийг нь харах боломжтой. Хүмүүсийг хангагдаагүй хүсэл хэрэгцээг гүйцээх биелүүлэх ажилд шавдуулдаг үнийн тогтолцоотой байхад эдийн засгийн өсөлт болон хүмүүний хөгжил цэцэглэлтэд логик буюу учирзүйн хязгаар гэж байхгүй гэдэгт сонгодог либералчууд итгэдэг. Шинэчлэл шинэ санаа, юмсыг сайжруулах үйлдэл, хүн бүрийн илүү сайн нөхцөлд хүрэх гэсэн хүчин чармайлт хууль тогтоогчид болон зохицуулагчид үүнийг зөвшөөрчихвөл нэгэн жигд, тогтвортой, үл саатсан хэвээр байсаар байх болно.

## *Сонгодог либерал ертөнц байх уу?*

Бид аль хэдийнээ ийм ертөнцөд амьдарч байна уу? Үгүй л болов уу: төвөгтэй байдал, тодорхойгүй байдал, савлагаатай байдал, олон янз байдалтай эрин үед олон хүн одоо ч хамгаалалт болон эдийн засгийн аюулгүй байдал хүсэж төр засгаа харсаар л байна. Төр засаг буюу засгийн газар өсөж томрохын хэрээр олон нийтийн сонголтын асуудал улам бүр л томордог. Засгийн газрын хяналтад улам л их нөөц баялаг байх тусам ашиг сонирхлын бүлэг тэднээс ашиг тус шаардах нь ойлгомжтой бөгөөд улстөрчид ч тэдгээр бүлгийг хүслийг нь биелүүлж тайтгаруулах нь бүр ч чухал болно.

Эцэст нь улс орнууд олон нийтийн өмчлөлийн бүтэлгүйтл[18]ийг олж мэдэн, төрийн үйлдвэрүүдээ хувьчилдаг байж болох юм; гэвч шууд өмчлөл[19]ийг нь өсөн нэмэгдэж буй зохицуулалт журмаар л сольсон байдаг. Улстөрчид одоо Патрицчууд[20] байхаа больсон ч тэд нар үүнээс дутуугүй биднийг өөрсдөөс минь хамгаалж байна гэж амьдралын хэвмаягийн тухай хууль баталж биднийг өмгөөлөлдөө авахаар тэмүүлсээр байна.

Сонгодог либералчууд эрх мэдэлтэй байгаа тэр хүмүүст тэдний хуульзүйн эрх дарх[21]ны хязгаарыг нь ойлгуулж ухааруулж чадаагүй л байсаар байна; яагаад хүчтэйчүүд нь өөрсдийгөө хязгаарлахыг хүснэ гэж? Гэвч эдийн засаг, улстөр, нийгмийн эрх чөлөөний дэмжлэг дэлхий даяар тархан тэлж буй гэдэгт эргэлзэх хэрэггүй бөгөөд үүнд аялал жуулчлал, харилцаан холбоо сайжирсан нь ихээхэн тус болсон билээ. Сонгодог либерализм Локкийн өвд тулгуурласаар байж болох ч гэлээ энэ үзлийн дуртай зүйлийн нэг бол хүмүүн төрөлхтөнийг ямар нэг үхмэл загварт тааруулах гэж оролддоггүй явдал юм; үүнээс илүүтэйгээр сонгодог либерализм хязгааргүй өөдрөг үзэл, ертөнцийн дасан зохицомтгой байдлыг нээх, харуулахыг зорьдог ажээ.

---

*18 he failures of public ownership*

*19 outright ownership*

*20 The patricians -(from Latin: patricius) -Эртний Ром байсан төр засаг барьж байсан гэр бүлүүдийн бүлгийн нэр ажээ.*

*21 legitimate authority*

# АРАВДУГААР БҮЛЭГ:
# Сонгодог Либерал Гол Сэтгэгчид

## Жон Локк (1632–1704 он),
## Англи философич

Олон хүн Локкийг сонгодог либерализмийг үндэслэгч гэж үздэг. Стюартын хаанчлалд дайсагнасан учраас Францад цөллөгт байсныхаа дараа тэрбээр II Жэймсийг хаан ширээнээс буулгасныг үндэслэлтэй болгож, хаад вангуудын "бурхнаас авсан эрх"-ийг жигжин зэвүүцэж, хуульзүйн дагуух төр засаг "хүч чадал болон хүчирхийлэл"-д тулгуурладаггүй харин хүмүүстэй хийсэн гэрээнд үндэслэдэг гэдгийг баталсан *Иргэний Төр Засгийн Хоёр Номлол*[1] (1690 он)-оо бичсэн байдаг. Жам ёсны төлөв[2]д хүмүүс амь нас, эрүүл мэнд, мөн байгалийн баялагтай "өөрийн хөдөлмөрөө нэгтгэж" олж авдаг өмчөө бусдын гадны халдлагаас хамгаалах бүхий л эрхтэй гэж тэрбээр санал болгожээ. Эдгээр жам ёсны эрх[3]ийг эв найртайгаар хамгаалж үлдээх гэж тэд нар төр засаг үүсгэж байгуулах гэрээ хийсэн. Тиймээс төр засаг захирагдагсдынхаа саналаар л хуульзүйн бүрэн эрх[4]ээ олж авдаг; хэрэв төр засаг тэдний эрхийг хамгаалахдаа бүтэлгүйтвэл тэд нар түүнийг түлхэн унагаах нь үндэстэй. Эдгээр үзэл санаа Америк болон Францын хувьсгалд, мөн Томас Жефферсон (1743–1826 он) зэрэг үндсэн хуулийн сэтгэгч нарт нөлөөлсөн билээ.

## Бернард Мандевилле (1670–1733 он),
## Англи–Голландын шог зохиолч

Мандевиллийн ёгт яруу найраг *Дүнгэнэлдсэн Зөгий* (1705 он),

1 *Two Treatises of Civil Government (1690)*
2 *state of nature -улстөрийн нэгдлийн өмнөх эсвэл ийм зүйл байхгүй үеийн хүмүүсийн амьдралын нөхцөлийг хэлнэ.*
3 *natural rights*
4 *legitimacy*

*Зөгийн Түүх* (1714 он) гэсэн нэрээр дахин хэвлэгдсэн энэ бүтээл уншигчдадаа өөрийн-тусыг бодох нь үйлдвэрлэл, худалдаа арилжаа, хөгжил цэцэглэлт, нийгмийн хэмнэл зохирлыг өдөөдөг гэж хэлэн алмайруулжээ. Түүний төсөөллийн зөгийнүүд зөвхөн өөрсдөдөө л санаа тавьдаг боловч өөрсдийнхөө хүслийг хангах гэхдээ тэд нар бусдад зориулсан ажлын байр бүтээдэг; тэд нар үрж зарцуулахдаа зөвхөн өөрийгөө баясуулах[5]ад үүнийгээ зориулдаг бөгөөд тэд нар зориудаар биш ч бусдыгаа баяжуулж хүрээлэл даяараа эд баялаг түгээдэг. Өөрийн-тусыг бодоход үндэслэсэн, эдийн засгийн өөрөө-тогтдог дэг журмын тухай энэхүү санаа үзэл Адам Смит (1723–90 он)-ийн "үл үзэгдэх гар"-ын загварын үндэс болсон бөгөөд хожим нь Фрийдрих Хаек (1899–1992 он) үүнийг нь хөгжүүлсэн билээ.

## Волтэйр [Франсуа-Марий Аруэ] (1694–1778 он), Франц зохиолч

Язгууртны хуулиар Францаас хөөгдөж цөлөгдсөн Волтэйр Англи явж, тэндхийн иргэний эрх чөлөөт байдал, үндсэн хуулийн төр засаг, сонгодог либерал сэтгэлгээнд сэтгэл татагджээ. Тэрбээр өөрийн амьдралаа суурь эрх чөлөө, хүлцэхүй, үг хэлэх эрх чөлөө, чөлөөт худалдаанд зориулахаар шийдэв. *Английн тухай Философийн Захидал* (1734 он)-даа тэрбээр Францын эс либерализм[6]ийг шүүмжилсэн байдаг; тэрбээр язгууртны эрх мэдлийг түлхэн унагаахыг уриалж, Сүм Хийдийн үл хүлцэхүйг шүүмжилж байв. Бастил[7]д хоригдож байсан ч гэсэн тэрбээр эхгазрын Европд тэр үе тархсан байсан хэлмэгдүүлэлтийг эсэргүүцсээр л байжээ.

## Адам Фергүсон (1723–1816 он), Шотландын нийгмийн онолч

Фергүсон аз жаргалдаа хүрэхээр тэмүүлэхдээ хүмүүс бүтээлч олон янз байдалтай, хөдөлмөрийн хуваарь байдлаар хэлбэржсэн үр өгөөжтэй, хөгжил дэвшлийг урагшлуулагч шинэчлэл хийдэг шинэ

5 *self-gratification*
6 *illiberalism*
7 *Bastile-шоронгийн нэр*

санаа бүхий ертөнцийг бүтээсэн гэж батлан өгүүлж байлаа. Тэрбээр нийгмийн институцийн өөрөө-тогтдог байр байдлыг дараахь байдлаар: ‘улс үндэстнүүд үнэндээ хүмүүний ямар нэг төлөвлөсөн бодлыг биелүүлснээс үүсээгүй харин хүмүүний үйлдлийн үр дагавар байдаг байгууламж[8]тай учирчээ[9]’ гэж бичин тайлбарласан. Эдгээр санаа нь түүний чацуутан Адам Смит (1723–90 он)-д урам зориг өгчээ.

## Адам Смит (1723–1790 он), Шотландын философич, эдийн засагч

Адам Смит ‘үл үзэгдэх гар’-аа зөвхөн нэг удаа л *Үндэстний Баялаг* (1776 он)-даа дурдсан боловч энэхүү хүчирхэг санаа уг номоор дүүрэн байдаг. Чацуутан Адам Фергүсон (1723–1816 он)-ы адилаар хүмүүний институц хэн нэгний зориудын санаагүйгээр ургаж гарч болох юм байна гэдгийг ажиглажээ. Смит бусад хүмүүсийн байгалиасаа л амиа хичээсэн эсвэл муухай ааштай бусдыг үл хүндэлдэг[10] гэж бодолгүй харин бусад хүмүүс өөрийнх нь тухай сайнаар бодоход дуртай байдаг гэж үзсэн; гэвч тэд нар өөрийн ашиг тусын төлөө хүчтэй (боловч хуульзүйн эрхтэй[11]) ашиг сонирхолтой байж өөрийн-тусыг боддог байсан байдаг. Албадлага байхгүй үед л тэд бусдын ашиг сонирхолд л зөвхөн үйлчлэх өөрийн-тусыг бодох явдлаа хэрэгжүүлэх боломжтой; иймээс л өөрсдөдөө туслахдаа тэд нар мөн л бусдад тусалдаг ажээ. Иймэрхүү сайн дурын солилцоо Смитийн харуулснаар хоёр талд хоёуланд нь үнэ цэнэ үүсгэнэ; тэд нар ийм биш бол худалдаа арилжаа хоорондоо хийхгүй. Тэрбээр солилцооны үйл явцаар үүсэх боломжтой болсон нарийн мэргэжих, хөдөлмөрийн хуваарь буюу хөдөлмөрийн төрөлжилтийг улс доторхи болон улс хоорондохь үр ашигт байдал болон хөгжил цэцэглэлтийн гол хөдөлгөгч хүч гэж зааж хэлсэн: нөлөөтэй энэ гаргалгаа нотолгоо нь арванесдүгээр зууны чөлөөт

*8 establishments*
*9 stumble upon*
*10 disobliging*
*11 legitimate*

худалдааны аугаа эринийг бий болгожээ. Тэрбээр крони буюу амин найзуудын капитализм, том засгийн газарт эргэлзэж сэжиглэнгүй хандаж байсан байдаг. Тэрбээр 'тогтолцооны хүн[12]' (эсвэл нийгмийн төлөвлөгч) хүн төрөлхтөний олон янз байдалтай сэдлийг хянах ямар ч боломжгүй бөгөөд "жам ёсны эрх чөлөөт байдлын ойлгомжтой, жирийн тогтолцоо'[13] нийгмийн хувьд илүү бат суурь байсан гэдгийг ч мэдэрч байжээ.

## Томас Жефферсон (1743–1826 он), Америкийн хувьсгалын удирдагч

Жефферсон Бурхан бидэнд бүх жам ёсны болон "салшгүй" эрхийг, үүн дотроо "амьд явах, эрх чөлөөт байдал, аз жаргалдаа хүрэхээр тэмүүлэх" эрхийг өгсөн гэдэгт итгэж байлаа. Тэрбээр хүмүүс бусдынхаа ижил эрх чөлөөг хохироохгүй гэсэн нөхцөлд жам ёсоор бол хүссэнээр чөлөөтэй үйл хийдэг байсан гэдэгт итгэдэг байв. Жон Локк (1632–1704 он)-ийн санааны нөлөөнд автсан тэрбээр засгийн газрын хуульзүйн бүрэн эрх[14] хүмүүс болон тэдний сонгосон төлөөлөгчдийн хоорондохь гэрээнд үндэслэдэг гэдгийг сахин хамгаалдаг байжээ. Тэрбээр эрх мэдлийн их төвлөрөлд энэ нь засгийн газар эсвэл бизнест ч байсан түүнд итгэдэггүй байсан. Тэрбээр шашны хүлцэхүйг улстөрийн абсолютизмыг эсэргүүцдэг байсан шигээрээ хүчтэй эсэргүүцдэг байв.

## Фредерик Бастиа (1801–50 он), Франц, улстөрийн онолч

Наполеоны 'Эхгазрын Тогтолцоо'[15]-гоор худалдаа арилжаа хязгаарлагдахад Бастиа хувийн эрх чөлөөт байдал, чөлөөт худалдааны төлөө маргаж мэтгэлцэж байв. Тэрбээр засгийн газрыг итгэл даахгүй, үр ашиггүй, үйлдвэрлэгчдийн ашиг сонирхолд хялбар автамхай байдаг гээд түүнийг ашиглаж 'хүн бүр л бусдын хүч

---

12 *man of system*
13 *'obvious and simple system of natural liberty*
14 *the legitimacy of government*
15 *Continental System*

хөдөлмөрөөр амьдрахыг чармайхдаа бүтээсэн аугаа зохиомол зүйл' болгодог гэж үзэж байжээ. Тэрбээр уран цэцнээр протекционизмыг Нарнаас болж тэдэнд учирч буй өрсөлдөөний эсрэг засгийн газраа үйлдэл хийхийг шаардсан, лаа үйлдвэрлэгчдийн хийсвэр гомдлоор элэглэсэн билээ. Засгийн газар түүний итгэж байснаар эрх чөлөөт байдал, өмчийг хамгаалах л гэж оршдог – эдгээр эрх нь төр засаг үүсэх урьдач нөхцөл ажээ. Ф. А. Хаек (1899–1992 он) зэрэг Австрийн Сургуулийн эдийн засагчид ойлгож байсанчлан, тэрбээр хувийн-тусыг бодох явдлаар хөдөлдөг зах зээл эдийн засгийн үйл ажиллагааг уялдуулж зохицуулан, хамгийн үнэ цэнэтэй хэрэглээ рүү нь нөөц баялагийг залж хүргэдэг гэж батлан мэтгэж байв.

## Ричард Кобден (1804–1865 он), Английн үйлдвэрийн эзэн, улстөрч

Жон Брайт (1811–89 он)-ын хамтаар Кобден нь Адам Смит (1723–90)-ийг даган чөлөөт худалдаа амин чухал бараа бүтээгдэхүүнийг бүх хүнд олдоцтой болгож, илүү шударга нийгмийг бүтээнэ гэдгийг сахин хамгаалдаг байсан, Манчестерийн Сургуулийн удирдагч байжээ. 1838 онд тэд нар Тарианы-Хуулийн-Эсрэг Нэгдл[16]ийг байгуулж, талхны үнийг өсгөж, байнгын хомсдолын шалтгаан болсон, импортолсон улаан буудайн эсрэг протекционист тарифыг (амжилттай) үгүй хийхийн төлөө маргаж мэтгэлцэж байв. Тэд нар мөн чөлөөт худалдаа дэмждэг гэж итгэдэг байсан, үндэстнүүд хоорондоо илүү сайн ойлголцох, тэдгээрийн хоорондохь эв нэгдлийг магтан ухуулж байв. Төрийн зүтгэлтэн болохынхоо хувьд Кобден Британи болон Францын хоорондохь худалдаа арилжааг асар их нэмэгдүүлэхэд тус болжээ.

## Жон Стюарт Милл (1806–73 он), Английн философич, шинэчлэгч

Миллийн *Эрх Чөлөөт Байдлын тухай* (1859 он) гэсэн бүтээлийг хэдий эрх чөлөөт байдлыг хамгаалдаг түүний хамгаалалт жам

*16 Anti-Corn-Law League*

ёсны эрхийн абстракт онол биш харин түүний үр ашигтай үр дүнд нь үндэслэсэн байдаг ч гэсэн сонгодог либертари ном гэж үздэг. Хэдий данхар төр засгийг шүүмжлэгч байсан ч гэсэн тэрбээр бас зөвхөн эрх чөлөөг хамгаалах үүргээр зогсохгүй мөн олон талбар дахь төрийн оролцооны төлөө маргаж мэтгэлцдэг байв. Өөрийн утилитарич оюун-санааны багш Жереми Бентам (1748–1832 он)-ыг даган Милл хэдий мөн дээд таашаал[17] доод зэрэгтэй таашаалаа үргэлж давдаг гэдэгт итгэдэг байсан ч асар олон хүнийг хамгийн их аз жаргалтай болгодог зүйлийг л сайн зүйл гэж бодож байжээ. Хувь хүмүүс үйлдлээрээ бусдыг хохироохгүй байх хүртлээ л өөрсдийн хүслээ чөлөөтэй дагадаг байх хэрэгтэй. Төр засгийн эрх мэдлийг хэрэглэх цор ганц хуульзүйн дагуухь хэрэглээ бол бодит аюул оруулах эсвэл аюулд өртүүлэхээр заналхийлэхээс сэргийлэх л явдал байсан бөгөөд бидний бусдын үйлдэлтэй эсвэл 'биет болон ёс суртахууны тэдний зөв гэж үздэг зүйл"-тэй санал үл нийлэх явдал тэдгээрийг хязгаарлах "хангалтгүй үндэслэл биш' ажээ. Милл дуугүй болгож хорьсон үзэл бодол зөв байх боломжтой, бүр буруу байсан ч давамгайлж буй үзэл бодолд хэрэгтэй сорилт агуулж байж болно гэж хэлэн үг хэлэх эрх чөлөөний төлөө хүчтэй маргаж мэтгэлцдэг байлаа.

## Хербэрт Спенсер (1820–1903 он), Английн антропологич, философич

Спенсер хувьсгалын онолыг нийгэм, улстөрийн хэрэг явдалд хэрэглэхийг эрэлхийлж байжээ. Тэрбээр анхнаасаа энгийн, цэрэгжсэн байсан хүмүүний хүрээлэл дээд зэргийн тогтвортой байдал болон хөгжил цэцэглэлтээсээ болж өргөжиж тэлдэг нарийн нийлмэл аж үйлдвэржсэн нийгэм болж хувьсаж хөгжсөн гэдэгт итгэж байв. "Социал Дарвинист" гэж шошготой ч гэсэн тэрбээр хүмүүн төрөлхтөн илүү сайн санаатай бодгаль болж хувьсаж хөгжиж ирсэн гэж бодож байжээ. Тэрбээр 'хүн бүрийн эрх чөлөөт байдал түүнтэй адилхан бүх хүмүүсийн эрх чөлөөт байдлаар хязгаарлагддаг' гэж маргаж мэтгэлцэн, цомхон засгийн газар, лэзе

*17 higher pleasures*

фэер, гэрээний эрх чөлөөг өмгөөлж хамгаалж, худалдаа арилжааны зохицуулалтын эсрэг байсан. Тэрбээр олон янз байдал болон шинэ санаа шинэчлэлээр тэтгэгдсэн эрх чөлөө нийгэмд илүү хурдан, илүү үр ашигтай хувьсаж хөгжих боломж олгох болно гэдгийг мэдэрч байсан байдаг.

## Фрийдрих А. Хаек (1899–1992 он), Англи –Австрийн улстөрийн онолч

Өөрийн оюун-санааны багш Лүдвиг фон Мизэсийн хамтаар судалж байсан, Хаек 1930-аад оны эдийн засгийн бүтээлдээ хэрхэн огцом өсөлт болон хямралын мөчлөг төр засаг зээлийг хортойгоор удирдаж залснаас үүсэж гарсан гэдгийг харуулсан байдаг; тэрбээр хамтач үзэл, төвлөрсөн төлөвлөлт, Жон Мэйнэрд (1883–1946 он) Кэйнсийн тэлэлтийн интервенционизм[18]ийн тэргүүлэх шүүмжлэгч болсон бөгөөд сүүлд дурдсан зүйл инфляц, эдийн засгийн тогтворгүй байдалд хүргэх болно гэж батлан өгүүлж байлаа. Дэлхийн II Дайн түүнийг өөрийн анхаарлаа улстөрийн ухаан руу эргүүлэхэд хүргэсэн бөгөөд хамгийн сайн зарагддаг *Боолчлогдох Зам* (1944 он)[19] гэсэн номдоо тэрбээр тоталиризмын үндэс шалтгааныг мөшгөн явж, үр бүтээлгүй төвлөрсөн төлөвлөлт нь түүнийг сахин хамгаалахад улам бүр их албадлага хэрэглэхийг шаарддаг гэж батлан өгүүлсэн. *Эрх чөлөөт байдлын Үндсэн Хууль* (1960 он)-даа тэрбээр чөлөөт нийгэм, эдийн засгийн дэг журмын төлөөх санаагаа гаргажээ. Тэрбээр өөрийгөө-зохицуулдаг, өөрөө-тогтдог нийгмийн дэг журмын тухай сонгодог либерал үзлийг хэрхэн энэ нь хувь хүмүүсийн дагаж мөрддөг байнгын зан төлөв (эсвэл ёс журам)-өөс үүсэж гардгийг харуулан сайжруулсан. Хаек ийм дэг журам хэдий төлөвлөөгүй ч хувь хүмүүс эзэмшдэг ч сарниж тархсан, хэсэг хэсгээрээ байдаг, хувийн шинжтэй, голдуу богино хугацааны мэдлэг, мөн төлөвлөлтийн аливаа байгууллага боловсруулж хэрэглэж чадахаас илүү их мэдлэгийг асар их хэмжээгээр боловсруулах боломжтой гэж батлан өгүүлсэн байдаг.

18 *expansionist interventionism*

19 *Монголоор орчуулж гарсан.*

*Үхэлд хүргэх Бардамнал* (1988 он)-даа тэрбээр бид иймэрхүү нийлмэл дэг журмыг физикийн ухааны арга хэрэгслийг ашиглаж хэлбэржүүлэх боломжтой гэдэг бол төөрөгдөл юм, түүнийг зохиомжлох гэсэн оролдлого нийгэм эдийн засгийн сүйрэлд хүргэх болно гэж батлан өгүүлэв. Хаек мөн сонгодог либерал сэтгэлгээнд зориулсан олон-улсын хүчирхэг хэлэлцүүлгийн талбар болсон Мон Пелерин Нийгэмлэгийг үндэслэжээ.

## Айн Рэнд (1905–82 он),
## Орос–Америкийн зохиолч, моралист

Сонгодог либерал өргөн хүрээний либеритарич хязгаарын талаар голдуу романаар дамжуулан сайтар илэрхийлсэн Рэнд радикал индивидуализмыг өмгөөлж хамгаалж байв. Тэрбээр амьдрах, өөрийгөө-идэвхжүүлэхийг ёс суртахууны стандарт гэж ойлгодог байсан. Үүний суурь болох саруул ухаан бидний бүх үйлдлийг замчлах ёстой бөгөөд хүмүүс урт-хугацааны, рационал байдлаар өөрийн-тусыг бодохдоо анхаарлаа хандуулах хэрэгтэй ажээ. Хувь хүмүүс үйлдлийнхээ үр шимийг хүртэх эрхтэй[20]; хүчээр тэд нараас юуг нь ч авах ёсгүй бөгөөд энэ нь саруул ухаан буюу рационал ухаанд хэрэггүй зүйл ажээ. Гэвч рационал байдлаар өөрийн-тусыг боддог хувь хүмүүс дунд үнэндээ тэд бусдын эрхийг хүндлэхийн өөрсдөд нь ирэх үнэ цэнийг харах учраас зөрчил байхгүй байх болно, өөрийгөө золиослох хэрэгцээ байхгүй байна. Хэрэв төр засагт үүрэг байвал, мөн зах зээлийн үйл ажиллагааны ёс журамд үүрэг байвал тэр нь чухам зөвхөн эдгээр эрхийг хамгаалах явдал байна гэж үзэж байв.

## Исайя Берлин (1909–97 он),
## Латви–Британийн философич

Берлин хорьдугаар зууны плюрализм болон хүлцэхүйн философийн тэргүүлэх хамгаалагч байлаа. Ямар ч цор ганц загвар түүний батлан өгүүлснээр хүмүүний бодол, үнэт зүйл, түүхийн асар олон янз

*20 entitled*

байдал, динамизмыг бүрхэж хучиж чадахгүй ажээ. Үйлдлийг шүүж цэгнэх боломжтой ёс суртахууны ямар ч цор ганц үнэн зарчим, ямар ч тогтсон стандарт байдаггүй: амьдрал бол өөр өөр, голдуу хоорондоо зөрчилтэй, жишээлбэл эрх чөлөө болон тэгш байдал мэт үнэт зүйлсийн хооронд байнга буулт хийх явдал ажээ. Тэрбээр мөн эрх чөлөөт байдлын хоёр төрлийг хоорондн нь ялгасан. Жон Стюарт Милл (1806–73 он)-ийн бүтээлдээ жишээлж харуулсан негатив эрх чөлөөт байдал[21] хүмүүсийн үйл хийх эрхийг ямар ч хязгааргүйгээр өмгөөлж дэмждэг. Харин позитив эрх чөлөөт байдал[22] бол өөрийн тавилангаа бүтээж, өөрийгөө-идэвхжүүлэх чадахгүй л бол чөлөөт биш байх боломжтой гэсэн үг юм гэж батлан өгүүлжээ. Энэ хоёр концепц хоёулаа гавьяатай ч гэсэн Берлин позитив эрх чөлөөний санааг сонгодог либерализмийн тулгын чулуу болсоор буй негатив эрх чөлөөг дэмжих биш харин устгах идеологид ашиглагдах бий гэдгээс эмээж айж байсан.

## Милтон Фрийдмэн (1912–2006 он), Америк эдийн засагч

*Мөнгөний Тоо Хэмжээний Онол* (1956 он) гэсэн судалгаандаа Фрийдмэн төр засагт валютынхаа үнэ цэнийг тогтвортой байлгах үүрэгтэй гэсэн санааг дахин амилуулсан. Тэрбээр инфляц өсөхийг зөвшөөрөн ажил эрхлэлтийг дэмжих нь инфляц болон ажилгүйдлийн шалтгаан болох болно гэж батлан өгүүлжээ. Инфляц бол мансууруулах бодистой адилхан, богино хугацаанд сэргээдэг ч удаан хугацааны асуудал тарьдаг байна. Тийм учраас тэрбээр инфляцаас сэргийлэх ‘мөнгөний дүрэм[23]’, алдагдал санхүүжүүлэх явдлыг зогсоохын төлөө кампанит ажил явуулж байв. Эхнэр Рөүз Д. Фрийдмэн (1910–2009 он)-ийн хамтаар тэрбээр чөлөөт зах зээлийн тэр-үедээ радикал байсан үзэл, валют солилцооны хөвөгч ханш, орлогын сөрөг татвар[24], боловсролын эрхийн бичиг,

*21 Negative liberty-хөндлөнгөөс үл заадаг эрх чөлөө*
*22 positive liberty-хөндлөнгөөс заадаг эрх чөлөө*
*23 monetary rule*
*24 a negative income tax*

төрийн тэтгэврийг хувьчлахын төлөө маргаж мэтгэлцсэн, хамгийн их борлуулалттай, *Капитализм, Эрх Чөлөө* (1962 он)-гөө бичсэн. Тэрбээр мэргэжлийг төр зохицуулах явдлаас хэрэглэгчид биш зөвхөн тухайн мэргэжилтэй улс л хождог гэдэгт итгэж байжээ. Тэрбээр иймэрхүү амьдралын хэвмаягийг зохицуулах нь хувийн эрх чөлөөт байдлыг ганхуулах болно гэж мансууруулах бодисыг эрүүжүүлэхийг эсэргүүцдэг байсан. Өөрийн *Сонгох Эрх Чөлөө* (1980 он) гэсэн нэртэй ном болон зурагтын цуврал нэвтрүүлэгтээ гаргалгаа нотолгоогоо бүр өргөн хүрээний уншигч үзэгчдэд хүргэсэн байна. Түүндээ тэрбээр: 'Эрх чөлөөнд тулгуурладаг хүмүүс өөрийн амьдралаа өөрийн үнэт зүйлийнхээ дагуу хянах нь аугаа нийгмийн бүрэн боломжийг нээх хамгийн зөв арга зам юм' гэж бичжээ.

## Жэймс М. Бачэнэн (1919–2013 он),
## Америкийн эдийн засагч

Жэймс Бачэнэн, Гордон Таллок (1922–2014 он) хоёр Олон Нийтийн Сонголтын Сургуулийн тэргүүлэх зүтгэлтнүүд байсан. Тэд *Санал Нэгдэх Явдлын Тооцоо*[25] (1962 он)-г хамтран бичив. Тэр хоёр тодорхой сонгогчдын ашиг сонирхол, ашиг сонирхлын бүлэг, улстөрчид, албан тушаалтнууд үйл явцыг бүгдээрээ гажуудуулдаг гэдгийг цохон зааж ардчилсан шийдвэрийн рационал байдал буюу ухаалаг байдал руу эргэлзээ сэжиг овоолжээ. 'Халамжийн' эдийн засагчид *зах зээлийн бүтэлгүйтл*ийг цохон зааж байхад бодит байдал дээр тэнд бас *төр засгийн алдаа* байсан байдаг. Тодорхой анхаарал хандуулж байсан зүйл нь цөөнхийг хүмүүсийн тодорхой бүлгээс татвар хураах замаар мөлжиж ашиглахын тулд төрийн эрх ашиглах олонхийн эсвэл бүр ашиг сонирхлын жижиг бүлгүүдийн эвслийн боломж чадал байжээ. Бачэнэн үүнтэй тэмцэх хамгийн сайн арга улстөрийн зохих шийдвэр гаргуулах ёс журмыг тогтоодог үндсэн хуулийн зохицуулалт[26] байсан гэдэгт итгэдэг байв. Хэн ч олонхийн дарангуйлалд өртөхгүй байхаар үндсэн хуулийн иймэрхүү ёс журмыг, дараагаар нь хууль болон дүрэм журмын талаар гарах

25 *Calculus of Consent*
26 *constitutional settlement*

шийдвэрийг санал нэгтэй шийдэх ёстой байвал маш сайн ажээ.

## Роберт Нозик (1938–2002 он), Америк философич

Нозикийн *Анархи, Төр, Утопи үзэл* (1974 он)-д эрх чөлөөт байдлын нарийн дэлгэрэнгүй ёс суртахууны хамгаалалтыг дурджээ. Энэ нь бид бусадтай тэднийг бидний зорилгын арга хэрэгсэл гэж биш харин өөрийн зорилготой хүмүүс гэж харьцах ёстой гэсэн Иммануэл Кант (1724–1804 он)-ийн 'категорийн императив[27]'-ээр эхэлдэг; тийм учраас л бид зөвхөн универсал буюу хүн бүр баримталдаг зарчим болгож хувиргах боломжтой арга замаар үйл хийх ёстой ажээ. Хүмүүн төрөлхтөн Нозикийн батлан хэлснээр хэн ч хүчээр булаах эрхгүйгээр өөрийн бие, авьяас, хөдөлмөрөө өмчилдөг байна. Дахин-хуваарьлалтын татварыг тийм учраас зөвтгөх аргагүй байдаг. Аливаа тохиолдолд эд баялаг "шударга"-аар хуваалцах гэж оршдоггүй; үүнийг хувь хүмүүсийн авьяас, ажил хэрэгч байдал, чармайлтаар бүтээх ёстой. Хэрэв эд баялагийг албадлагагүйгээр шударгаар олж авсан, дамжуулсан бол үр дүн нь гарах хувь хүмүүсийн дундахь эд баялагийн хуваарьлалт хэдий бүр энэ нь ижил тэгш биш байсан ч гэсэн мөн л шударга байх болно. Төрийн үүрэг бол зөвхөн хувь хүмүүсийг хүч хэрэглэх, хулгай, залилах, гэрээ зөрчихөөс л хамгаалах явдал юм. Гэвч төр хүмүүсийг өөр өөр зорилго болон алсын бодолдоо хүрэхээр чөлөөтэй тэмүүлсэн хэвээр нь орхино. Иймэрхүү харуулын төр[28] хүмүүс эрхээ, жишээлбэл маргаан шийдвэрлэх хувийн байгууллага байгуулж, хувиараа хамгаалах гэж хамтдаа нэгдэх учраас л Францын хувьсгалын дараа олон хүн айх болсон анархи байдал руу хүргэхгүй ажээ.

---

27 *categorical imperative*

28 *night-watchman state -Манаач төр, эсвэл харуул төр*

# АРВАННЭГДҮГЭЭР БҮЛЭГ:
# СОНГОДОГ ЛИБЕРАЛ ЭШЛЭЛ

## Магна Харт буюу Эрх Чөлөөний Аугаа Тунхаг[1]

Гүрэн улсынхаа бүх чөлөөт хүмүүст бид мөн бидэнд хийгээд бидний үр удамд үүр дор бичиж үлдээсэн эрх чөлөөт байдлыг, тэдэнд хийгээд тэдний үр удамд, бидэнд хийгээд бидний үр удамд байна, бас байсаар байх болно гэж баталгаажуулж олгож байна.... Ямар 'бамбайн хамгаалалт' эсвэл 'алба гувчуур'-ыг...манай гүрэн улсад түүний нийт олны зөвшөөрөлгүйгээр авахгүй байж болно.... Ямар ч чөлөөт хүнийг ижил тэнцүү хэн нэгний хуулийн дагуухь үндэслэл шалтгаан эсвэл улс гүрний хуулиас бусдаар баривчлахгүй эсвэл шоронд хорихгүй, эсвэл эрх эсвэл өмчөөс нь салгахгүй, эсвэл гэмтэн гэж зарлахгүй эсвэл цөлөхгүй, эсвэл түүний байр суурийг ямар нэг аргаар хураан авахгүй, бас түүний эсрэг хүч үл хэрэглэмой, эсвэл хүч хэрэглүүлэх гэж бусад хүмүүс үл илгээмой. .... Бид эрх эсвэл шударга ёсыг хэнд ч зарахгүй эсвэл эдлүүлэхээс татгалзахгүй эсвэл хойшлуулахгүй .... Бүх худалдаачид энд амьдран сууж, газраар мөн усаар нүүн явах, эртний зөв уламжлалаар юмаа худалдаа, юм худалдаж авах, бүх муу төлбөр татвараас татгалзах эрхтэй байж, Англиас аюулгүй, баталгаатай гарах, мөн Англи руу ормой.....

– Английн Хаан Жон (1166–1216 он) (дарамтан дор зөвшөөрөв)

## Жам ёсны эрх

Жам ёсны эрх ... бол өөрийн нөхцөлөө хадгалж үлдэхийн тулд

1 *Үүний бүрэн монгол орчуулгыг www.libraryforfreepeople.mn сайт болон Эрх Чөлөөт Хүмүүст зориулсан Номын Сан гэсэн фейсбүүк хуудаснаас үзнэ үү.*

өөрийн хүссэнээрээ өөрийн хүчээ ашиглах хүн бүрд байдаг эрх чөлөөт байдал юм; энэ нөхцөл жишээлбэл бидний амьдрал билээ.

– Томас Хоббэс (1588–1679 он), *Левиафан*[2]

Жам ёсны төлөв хүн бүрийг үүрэгжүүлдэг, түүнийг захирдаг байгалийн хуультай: хууль болох саруул ухаан түүнээс зөвхөн л сургамж авдаг хүмүүн төрөлхтөнд бүгдээрээ эрх тэгш, бие даасан болохыг, мөн хэн ч нөгөө нэгнийхээ амь нас, эрх чөлөөт байдал, эсвэл өмчийг хохироох ёсгүй болохыг заан сургадаг ....

– Жон Локк (1632–1704 он), *Иргэний Төр Засгийн Хоёр Номлол*

Бид бүх хүмүүсийг ижил тэгш бүтээсэн, тэдэнд Бүтээгч тодорхой салшгүй эрхүүд, үүн дотроо Амьдрах, Эрх Чөлөөт Байдалтай Байх, Аз Жаргалдаа хүрэхээр тэмүүлэх эрх хүртээсэн гэсэн эдгээр үнэнийг өөрөө илэрхий зүйл гэж үздэг.

– Томас Жефферсон (1743–1826 он), *Америкийн Тусгаар Тогтнох Тунхаг*[3]

---

2 *Leviathan-Энэ бол Библийн домогт өгүүлдэг, Бурхан бүтээсэн, галаар тургидаг олон толгойт могой мэт мангасын нэрээр нэрлэсэн бүтээл ажээ. Орос бичгийн хэлэнд th ийг ф гэж буулгадаг байсан үеэс үлдэж хоцорсон үг ажээ. Бүтэн нэр нь The Matter, Forme and Power of a Commonwealth Ecclesiasticall and Civil болович артгаалжин мангас буюу левиатан гэдэг байна. Анх түүнийг 1651 онд хэвлүүлжээ. Энэ номдоо Хоббэс төр засгийг хамтын аюулгүй байдлаа баталгаажуулах багаж хэрэглэсэн гэсэн үзлээ томьёолж харуулсан байдаг. Хоббэсийнхоор бол улстөрийн бүрэн эрхийг төсөөллийн нийгмийн гэрээнд үндэслэж гаргадаг ажээ. Хоббэсийн энэ бүтээл нийгмийн гэрээний бүтцийг нь хүлээн зөвшөөрсөн түүний алдартай дагалдагч нарт, үүнд дотор Жон Локк (1632–1704 он), Жан-Жак Руссо (1712–78 он), Иммануэл Кант (1724–1804 он)-аар зогсохгүй өөрийн-тусыг бодохтой холбоотой ёс суртахууны болон улстөрийн шийдвэрийн талаархи онолч нарт нөлөөлжээ.*

3 *Үүний бүрэн монгол орчуулгыг www.libraryforfreepeople.mn сайт болон Эрх Чөлөөт Хүмүүст зориулсан Номын Сан гэсэн фейсбүүк хуудаснаас үзнэ үү.*

Амьдралаа хөөх, эрх чөлөөт байдал, өмч хүн хууль гаргасан учраас оршдоггүй. Үүний эсрэгээр үнэндээ амьдралаа хөөх, эрх чөлөөт байдал, өмч хүмүүс юуны өмнө хууль гаргах шалтгаан болж өмнө нь оршиж байсан.

– Фредерик Бастиа (1801–50 он), *Хууль*[4]

Хувь хүмүүс эрхтэй бөгөөд ямар ч хүн эсвэл бүлэг хүн (эрхийг нь зөрчихгүйгээр) тэдэнд ямар нэг хийж үл болох гэж зүйл бий. Эдгээр эрх маш хүчирхэг, маш өргөн хүрээтэй байдаг нь төр болон түүний албан тушаалтан эдгээртэй хамаатайгаар юу хийж болох талаархи асуудлыг босгож ирдэг.

– Роберт Нозик (1938–2002 он), *Анархи, Төр, Утопи үзэл*

## Хязгаарлагдмал-эрх мэдэлтэй төр засаг

Хувь хүмүүсийн эдийн засгийг харж хянадаг, мөн тэдний зардлыг хязгаарладаг гэж дүр эсгэдэг, хамгийн дээд түрэмгий дээрэнгүй авир, бардам төсөөлөл ... хаадад, сайд нарт бий .... Тэд нар өөрсдөө бусдаас ямар ч ялгаагүй нийгмийн хамгийн үрэлгэн хүмүүс байдаг. Өөрсдөө зардлаа сайн анхаарч хардаг лугаа адилаар мөн хувь хүмүүст өөрсдийгөө мэдэх явдлыг итгэж өгүүштэй. Тэдний өөрсдийнх нь тансаглал төрөө сүйрүүлэхгүй л бол харьяат иргэд нь хэзээ ч төрөө сүйрүүлэхгүй.

– Адам Смит (1723–90 он), *Үндэстний Баялаг*[5]

Төр засгийн эрх мэдлийг зайлшгүй хэн нэгний гар өгдөг; тэднийг хориглохгүй л бол энэ эрх мэдлийг итгэл хүлээлгэн өгсөн хүмүүс тэдгээр эрх мэдлээ буруугаар ашиглах хязгааргүй шуналтай байдаг бөгөөд тэд нар хэзээ ч эдгээр эрх мэдлийг буруугаар ашиглахаа

